



МОНГОЛ БАНК



ЖИЛИЙН ТАЙЛАН 2013

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ



Эрхэмсэг хатагтай, ноёд оо!

Өнгөрсөн 2013 он бидэнд макро эдийн засгийн бодлогын том сорилтын жил байлаа. Европын өрийн хямрал ужгирсан, Хятадын эдийн засаг удаширсан, эрдэс түүхий эдийн үнэ буурсан, хөгжик буй орнуудаас хөрөнгө гадагшлах үзэгдэл үргэлжилсэн зэрэг нь манай эдийн засагт сөргөөр нөлөөлж байв. Ийм тодорхойгүй орчинд Төв банкны үүрэг нь зөвхөн үнийн тогтвортой байдлыг хангах хүрээгээр хязгаарлагдахгүй, эдийн засгийн өсөлт, бүтцийн шинэчлэл, бодит секторын идэвхжилийг дэмжиж, дотоодын хуримтлал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэлээ.

Монгол Улсын урсгал данс 2010-2012 онд жилд дунджаар 3.1 тэрбум ам.долларын алдагдалтай, үүнээс барааны гадаад худалдаа жил бүр 2 тэрбум ам.долларын алдагдалтай байсныг санхүүгийн дансны ашигaar буюу гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсалаар голлон нөхөж ирсэн юм. Гэтэл 2013 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.4 тэрбум ам.доллараар, экспортын орлого 0.8 тэрбум ам.доллараар тус тус буурсны зэрэгцээ Монгол Улс 2011-2012 онд ирээдүйн экспортын орлогыг барьцаалж богино хугацаат зээл авсан байсан нь эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг зөвхөн 2013 онд 4 тэрбум ам.доллараар буюу 6.1 их наяд төгрөгөөр, Монгол Улсын гадаад цэвэр активыг 78.5 хувиар буюу 3.5 их наяд төгрөгөөр тус тус огцом бууруулахад нөлөөлөв. Ийнхүү төлбөрийн тэнцэлд 2012 оноос эхлэн үүссэн дарамт, хүндрэл нь 2013 онд хямралын шинжтэй болсон нь эдийн засагт бий болсон хүндрэлийн суурь шалтгаан болсон юм.

2012 оны төгсгөлд зээлийн тасалдал бий болох, санхүүгийн салбар хүндрэх, 2013 онд мөнгөний нийлүүлэлт огцом буурах, улмаар санхүү, эдийн засгийн хямрал бий болох бодит аюул байсан учраас болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх, эдийн засаг, санхүүгийн системээ бүхэлд нь тогтвржуулах зорилгоор Монголбанк 2012 оны 11 дүгээр сараас эхлэн хуулийн хүрээнд, бие дааж мөнгөний нийлүүлэлтийг тодорхой үе шаттайгаар, хувийн хэвшлээр дамжуулж хийв. Үүнд:

Нэгд, Монголбанк “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвржуулах” хөтөлбөрийн хүрээнд 677 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг эдийн засагт нийлүүлсэн нь мах, гурил, жижиглэнгийн шатахуун зэрэг хэрэглээний суурь бүтээгдэхүүний үнийн өсөлтийг өмнөх онуудынхаас сааруулах, улмаар тогтвортой байлгахад эерэгээр нөлөөлсөн.

Хоёрт, Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, санхүүгийн салбарын итгэлийг сэргээх, зээлийн тасалдаас сэргийлэхийн тулд 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг банкуудад байршуулан, санхүүгийн салбарыг хамгааллаа.

Гуравт, инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй байсан үед мөнгөний бодлогын хүүг 3 удаа, нийт 2.75 нэгж хувиар бууруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжихийн зэрэгцээ мөнгөний нийлүүлэлтийг бодит секторт эргэлтийн

хөрөнгийн зээл олгох хэлбэрээр нэмэгдүүлэв.

Дээрх цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд 2013 онд нийт M2 мөнгө 24.3 хувиар, үүнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол 12.1 хувиар, ДНБ 11.7 хувиар тус тус өсч, 2012 оны сүүл үеэс болжошгүй байсан зээлийн тасалдал, системийн шинжтэй эрсдэлээс бүрэн сэргийлж, санхүүгийн салбарыг сайжруулж чадлаа.

Инфляцид үлэмж нөлөөтэй нийлүүлэлтийн хүчин зүйлсийн дарамтыг бууруулахын тулд “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвожуулах хөтөлбөр”-ийг Монголбанкаас тэргүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь гол нэрийн барааны үнийн өсөлтийг тогтвожуулах, нийлүүлэлтийн саад, дэд бүтцийн хязгаарлалтыг арилгах, хувийн хэвшилд суурилсан, урт хугацаанд үр ашигтай ажиллах механизмыг бий болгох зорилготой билээ.

Санхүүгийн үүсмэл хэрэгслээр ханшийн эрсдэлийг бууруулан үнийг тогтвожуулах бүрэн боломжтойг “Шатахууны жижиглэнгийн үнийг тогтвожуулах дэд хөтөлбөр”-ийн үр дүн харуулж байгаа бол “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвожуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлснээр мах, махан бүтээгдэхүүний инфляцид үзүүлэх нөлөө өмнөх оноос 3.1 дахин буурсан байна. Үүний сацуу үр тарианы нөөц, мах зэрэг бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг зах зээлд цоо шинээр нэвтрүүлснээр бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн зах зээлийн механизм, хувийн хэвшилд суурилсан байнгын тогтолцоог бүрдүүлэх эхлэл тавигдаж байна. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци өмнөх оноос Улаанбаатар хотын хэмжээнд 1.9 нэгж хувиар буурч 12.3 хувьд хүрсэн бол улсын хэмжээнд 1.5 нэгж хувиар буурч 12.5 хувьтай гарлаа. Хэрэв цахилгаан эрчим хүч, дулаан, усан хангамжийн үнэ тариф зэрэг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ болон боловсролын үйлчилгээний үнэ нэмэгдээгүй байсан бол 2013 оны эцэст жилийн инфляци улсын хэмжээнд нэг оронтой тоонд гарах бүрэн боломжтой байсан юм.

Монголбанк эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд барилгын салбарыг эрэлт, нийлүүлэлтийн аль аль талаас нь дэмжихэд анхаарч ажиллав. Тухайлбал, барилгын материалын дотоодын үйлдвэрлэл, орон сууцны барилгын нийлүүлэлтийг эхэлж дэмжсэнээр 2013 онд ашиглалтанд орсон орон сууцны тоо өмнөх оноос 60 хувиар өсчээ. Нөгөө талаас Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлснээр оны эцсийн байдлаар банкууд 739.1 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгож, 474.5 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлжээ. Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог цаашид ч үргэлжлүүлэх бөгөөд энэ хүрээнд үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжиж, Нийгмийн даатгалын сан дахин хөрөнгөжин, хөдөлмөрийн зах зээл, татвар, шимтгэлийн орчин илүү ил тод, тунгалаг болно.

Мөнгөний бодлогын хүүний нөлөөг сайжруулах, банк хоорондын захын хүүний хэлбэлзлийг бууруулах үүднээс Монголбанк 2013 оны 3 дугаар сараас 4 нэгж хувийн өргөнтэй хүүний коридорыг нэвтрүүлээд байна. Ингэснээр төв банкнаас банкуудад


овернайт хадгаламж, овернайт репо хэрэгслийг цоо шинээр санал болгож, нөөцөө илүү оновчтой удирдах боломжийг нь бүрдүүлэв.

2013 онд төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 15.5 хувиар, бодит ханш 7.2 хувиар тус тус суларсан нь гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсны илрэл төдийгүй 7 дугаар сарын сүүлчээр валютын захад үүссэн огцом цочрол, серөг хүлээлтийн үр дагавар байв. Ханшийн энэхүү өөрчлөлт нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулсан хэдий ч, урт хугацаанд манай эдийн засгийн өрсөлдөх чадвар болон экспортын боломжийг алдагдуулахгүй байх, гадаад валютын улсын нөөцийг хамгаалах, гадаад худалдаа, ургасл тэнцлийн алдагдлыг бууруулах, улмаар эдийн засагт бүтцийн шинжтэй томоохон шинэчлэл хийх урьдач нөхцөлийг хангахад чухал үүрэгтэй юм. Нөгөө талаас Монгол шиг гадаад худалдааны эргэлт нь ДНБ-ээсээ давсан эдийн засгийн хувьд валютын ханшийн хэт огцом өөрчлөлт нь эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй учраас Монголбанк ханшийн өөрчлөлтийн хандлагыг нь өөрчлөлгүйгээр, зөвхөн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор валютын захад оролцох бодлогыг үргэлжлүүлэн ажиллав. Ингэснээр санхүүгийн салбарт үүсч болзошгүй байсан сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн болно.

2013 онд банкны секторын нийт актив 74.1 хувиар өсч 20.1 их наяд төгрөгт, зээлийн өрийн үлдэгдэл 54.1 хувиар өсч 10.8 их наяд төгрөгт, татан төвлөрүүлсэн эх үүсвэр 77.7 хувиар өсч 19.6 их наяд төгрөгт тус тус хүрлээ. 2013 оноос эхлэн манай бүх банк зохицой харьцааны болон өөрийн хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүдээ бүрэн хангаж, банкны системийн үзүүлэлтүүд урьд хожид байгаагүйгээр сайжирсныг энд онцлон тэмдэглэхийг хүсч байна. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2013 оны эцэст 14.9 хувь болж, 2013 оны хамгийн өндөр түвшнээс 4.6 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2013 онд банк хооронд хийгдсэн гүйлгээний тоо өмнөх оноос 2.5 дахин, дүн нь 82 хувиар өсчээ.


Монгол улс бусад орны адил эдийн засгаа урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхийг зорьж байгаа билээ. Бидний эцсийн зорилго нь өнөөгийн хэрэглээнд суурилсан, түүхий эдийн үнэ, уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтаас үлэмж хамааралтай эдийн засгийн зохисгүй бүтцийг өөрчилж, дотоодын үйлдвэрлэл, хадгаламж, хуримтлал, хөрөнгө оруулалтыг дэмжсэн, бүтээмжид тулгуурласан, төрөлжсөн, өрсөлдөх чадвар, дархлаатай эдийн засаг болгоход оршиж байгаа бөгөөд чухамхүү энэ зорилгод Монголбанк төрийн мөнгөний бодлогыг чиглүүлсээр байх болно.



Н.ЗОЛЖАРГАЛ

Монголбанкны Ерөнхийлөгч

МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	
1.1 Бодит сектор	9
1.2 Гадаад сектор	13
1.3 Мөнгө, санхүүгийн сектор	18
1.4 Улсын төсөв	32
2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ	
2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн	33
2.2 Санхүүгийн тогтвортой байдал	37
2.3 Валютын бодлого	40
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага	41
2.5 Монгол Улсын төлбөр тооцооны систем	43
2.6 Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл	45
3. МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	
3.1 Төвбанкны үнэт цаас	47
3.2 Төвбанкны санхүүжилт	47
3.3 Засгийн газрын үнэт цаас	49
3.4 Гадаад валютын дуудлага худалдаа	50
3.5 Дотоод зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа	50
4. ГОЛ НЭРИЙН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙГ ТОГТВОРЖУУЛАХ	
4.1 Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөр	53
4.2 Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөр	54
4.3 Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр	56
4.4 Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөр	59
4.5 Нүүрсний аюулгүй нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчиний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчиний үнэ, тарифыг тогтвортжуулах дэд хөтөлбөр	61

5. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН	
5.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт	63
5.2 Олон нийттэй харилцах харилцаа	63
5.3 Гадаад харилцаа	64
5.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ	65
5.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага	67
5.6 Бэлэн мөнгөний хангалт	68
5.7 Мэдээллийн технологи	69
5.8 Монголбанкаас 2013 онд баталсан эрх зүйн баримт бичгүүд	69
6. АУДИТИН ТАЙЛАН	73
7. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	163


1.1 Бодит сектор

ДНБ-ий бодит өсөлт

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт 2013 онд 11.7% гарч, 3 дахь жилдээ дараалан 2 оронтой тоонд хадгалагдлаа. Монгол Улсад орж ирэх гадаад валютын урсгал болон гадаад цэвэр активын хэмжээ буурах хандлагатай болсон 2012 оноос эхлэн эдийн засгийн өсөлт улирал бүр саарсаар 2013 оны 1 дүгээр улиралд 7.1% болж буурсан юм. Гэвч Монголбанк эдийн засгийг бүхэлд нь тогтвортжуулах, учирч болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх зорилгоор мөчлөг сөрсөн мөнгөний бодлого хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангасны зэрэгцээ эдийн засгийн тэнцвэртэй өсөлтөд дэмжлэг үзүүлсний үр дүнд ДНБ-ий бодит өсөлт 2013 оны 2 дугаар улирлаас эхлэн тогтвортожиж, улмаар сэргэсээр оны эцэст хоёр оронтой тоонд хадгалагдав. Ингэснээр эдийн засгийн бодит секторт учруулах гадаад эдийн засгийн сөрөг нөлөөллийг саармагжуулж, 180 орчим мянган ажлын байраа алдах бодит аюулаас урьдчилан сэргийлж чадсан болно.


Эдийн засгийн бодит өсөлт дэх уул уурхайн салбарын нөлөөлөл 2013 онд эрс буурсныг барилга, хөдөө аж ахуйн салбарын өсөлтөөр голлон нөхлөө.

Зураг 1: Зэс, нүүрсний үнийн индекс (2007=1.0) болон экспорт (баруун тэнхлэгт)



Эх сурвалж: YCX

Зураг 2: ДНБ-ий өсөлтийн задаргаа



Эх сурвалж: YCX, Дэлхийн банк


2013 оны эцсийн байдлаар ДНБ-ий өсөлтийг бүтцээр нь авч үзвэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа, уул уурхай, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-ий өсөлтөд эзлэх хувь өнгөрсөн онтой харьцуулахад өсч, бүтээгдэхүүний цэвэр татвар, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны өсөлт буурсан байна.

Салбарын ангиллаар нь авч үзвэл үйлчилгээний салбар ДНБ-ий өсөлтийн дийлэнх хэсгийг эзэлж байгаа хэдий ч, жилийн эцэст буурсан, харин нийт өсөлтөд уул уурхайн салбарын эзлэх хувь жилийн 2 дугаар хагаст нэмэгдсэн байна.

Хүснэгт 1: ДНБ-ий бодит өсөлтийн задаргаа

ДНБ-ий бодит өсөлт	2013			
	I	II	III	IV
ДНБ-ий бодит өсөлт	10.7%	11.6%	12.2%	11.7%
Хөдөө аж ахуй	2.9%	3%	2.6%	2%
Уул уурхай	1.1%	0.8%	2.1%	3.2%
Аж үйлдвэр (уул урхайгаас бусад)	1.3%	1.7%	2.5%	1.9%
Үйлчилгээ	5.5%	5.6%	4.3%	4.3%
Бүтээгдхүүний цэвэр татвар	0.6%	1.1%	2%	1.4%

Зураг 3: ДНБ-ий задаргаа (эцсийн ашиглалтаар)



Эх сурвалжсууд: YCX

ДНБ-ий задаргааг эцсийн ашиглалтын аргаар авч үзэхэд эцсийн хэрэглээ 5.4 их наяд, нийт хуримтлал 4 их наяд, харин цэвэр экспорт -3.2 их наяд төгрөг байгаа нь эдийн засагт хэрэглээ давамгайлсан хэвээр байгааг харуулж байна. Цаашид хэрэглээнээс хуримтлалд шилжих, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн макро бодлогыг туштай хэрэгжүүлснээр дотоодын үйлдвэрлэл, бүтээмж, цэвэр экспорт нэмэгдэх, нийт хуримтлал өсөх эерэг хандлага бий болно.

Эрдэс баялгийн бус салбар

Барилга угсралт, бөөний ба жижиглэнгийн худалдаа, хөдөө аж ахуйн салбарт гарсан өсөлтийн нөлөөгөөр эрдэс баялгийн бус салбар 2013 онд өмнөх онтой харьцуулахад 10.1%-иар өссөнөөр ДНБ-ий 11.7%-ийн бодит өсөлтийн 8.5 нэгж хувийг бүрдүүлжээ.


2013 онд Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн дэд бүтцийн төслүүд болон орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, барилгын материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр Монголбанкнаас хэрэгжүүлсэн арга хэмжээний нөлөөгөөр барилгын салбарын үйлдвэрлэл 66.5%-иар өсч, өсөлт нь 2010-2012 оны дунджаас 2.2 дахин нэмэгдэн, ДНБ-ий бодит өсөлтийн 1.4 нэгж хувийг дангаараа бүрдүүлсэн байна. Ингэснээр 2013 оны ДНБ-ий бодит өсөлтөд барилгын салбарын үзүүлэх хувь нэмэр 2012 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.

Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн бодит өсөлтийн 2.0 нэгж хувийг бүрдүүлэв. Энэхүү өсөлтөд Монголбанкнаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөр чухал нөлөө үзүүлсэн болно. 2013 онд 15.7 сая толгой хээлтэгч мал төллөснөөс 15.2 сая толгой төл мал бойжиж, 0.8 сая толгой малын зүй бус хорогдол гарснаар оны эцэст 45.1 сая толгой мал тоологдон, өмнөх онтой харьцуулахад 10.3%-иар өсчээ.


Хөдөө аж ахуйн салбар эдийн засгийн бодит өсөлтийн 2.0 нэгж хувийг бүрдүүлэв. Энэхүү өсөлтөд Монголбанкнаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөр чухал нөлөө үзүүлсэн болно. 2013 онд 15.7 сая толгой хээлтэгч мал төллөснөөс 15.2 сая толгой төл мал бойжиж, 0.8 сая толгой малын зүй бус хорогдол гарснаар оны эцэст 45.1 сая толгой мал тоологдон, өмнөх онтой харьцуулахад 10.3%-иар өсчээ.

2013 оны ДНБ-ий бодит өсөлтийг зардлын аргаар тооцоход 16.8 нэгж хувийг өрхийн аж ахуйн хэрэглээ дангаараа бүрдүүлснээр эцсийн хэрэглээ 13.7%-иар өсчээ (Зураг 5). Төсвийн тогтвортой байдлын тухай хууль бүрэн агуулгаараа 2013 оноос эхлэн хэрэгжиж, төсвийн огцом тэлэлт, түүгээр дамжуулан бэлэн мөнгө тараах зохисгүй үйл ажиллагаа зогссон нь засгийн газрын хэрэглээ буурахад эрэггээр нөлөөлөв. Монгол Улсыг чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр буурсан нь эдийн засгийн өсөлтөд үндсэн хөрөнгийн нийт хуримтлалын эзлэх хувийг огцом бууруулж 1.5 нэгж хувьд хүргэжээ. Бараа, үйлчилгээний экспорт нь эдийн засгийг 8.9 нэгж хувиар өсгөх нөлөө үзүүлсэн боловч импорт -12.5 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлснээр цэвэр дүнгээрээ гадаад худалдаа эдийн засгийн өсөлтөд -3.6 нэгж хувийн сөрөг нөлөөлөл үзүүлжээ.

Зураг 4: Бодит ДНБ ба үйлдвэрлэлийн бүрэлдэхүүн салбаруудын өсөлт 2010-2013 онд



Зураг 5: Бодит ДНБ-ий өсөлт ба түүнд зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийн эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажил эрхлэлт


Нийт хөдөлмөрийн насны хүн амын тоо өмнөх оноос 5.6%-иар өсч, 2013 оны 3 дугаар улирлын байдлаар 1894.5 мянгад хүрсэн байна. Үүнээс эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу нийт ажиллах хүч 62.1%-ийг эзэлж байгаа бөгөөд ажиллах хүчиний оролцооны түвшин өмнөх оноос 0.5 нэгж хувиар нэмэгджээ (Зураг 6). Харин нийт ажилчдын тоо 2012 оноос 68.2 мянгаар өсч 1086.4 мянгад хүрсэн бол нийт ажилгүйчүүдийн тоо 89.5 мянга буюу ажилгүйдлийн түвшин өмнөх оноос буурч 7.6% болжээ (Зураг 7).

Нийт ажилчдын тоог эдийн засгийн гол салбаруудын ангиллаар авч үзвэл 2013 оны байдлаар 353.1 мянга буюу нийт ажилчдын 32.5% нь хөдөө аж ахуйн салбарт, 229.6 мянга буюу 21.1% нь үйлдвэрлэлд, 503.7 мянга буюу 46.4% нь үйлчилгээний салбарт тус тус ажиллаж байна (Зураг 8). Мөн нийт ажилчдыг хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр авч үзвэл 514 мянга буюу нийт ажилчдын 47.3% нь цалин хөлстэй ажилчид байгаа бол 14.1 мянга буюу 1.3% нь ажил олгогч байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчид 203.3 мянга буюу 18.7%, өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 25.5 мянга буюу 2.3% байгаа бол мал аж ахуй эрхлэгчид 325.2 мянга буюу нийт ажилчдын 29.9%-ийг бүрдүүлж байна (Зураг 9).


Зураг 6: Ажиллах хүчиний оролцооны түвшин*



Зураг 7: Ажилгүйдлийн түвшин



Зураг 8: Ажилчдын тоо
(эдийн засгийн салбараар)



Зураг 10: Аж үйлдвэрийн салбарын ажилчид



Эх сурвалжууд: YCX

Зураг 9: Ажилчдын тоо
(хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжээр)



Хүснэгт 2: Хөдөлмөрийн бүтээмж

Хөдөлмөрийн бүтээмж** (2005 оны зэрэгцүүлэх үнэр, мян.төгр)	2011	2012	2013	2013/ 2012
Нийт аж үйлдвэрийн салбар	37,745	39,244	40,764	3.9%
Уул уурхайн АҮ	70,472	69,805	71,422	2.3%
Боловсруулах АҮ	26,467	29,048	28,307	-2.6%
Цахилгаан, дулаан, эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	16,526	17,140	17,714	3.3%

* - Ажиллах хүчиний оролцооны түвшин нь эдийн засгийн идэвхтэй хүн амын нийт хөдөлмөрийн насны (15-с дээш) хүндээ зэлж хувийг илрүүлжээ.

** - Нэг ажилчинд ногдох нийт үйлдвэрлэл (Ажиллагчдын тоо жилийн дунджаар)


Аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын тоо 2013 оны эцсийн байдлаар 71.2 мянгад хүрсэн бол нэг ажилчинд ногдох үйлдвэрлэл буюу хөдөлмөрийн бүтээмж 40.7 сая төгрөг байна. Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж хамгийн өндөр буюу 71.4 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 2.3%-иар өссөн бол боловсруулах аж үйлдвэрийн хөдөлмөрийн бүтээмж 28.3 сая төгрөг болж, өмнөх оноос бага зэрэг буурсан байна. Харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн хувьд хөдөлмөрийн бүтээмж 17.7 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 3.3 хувиар өсчээ (Хүснэгт 2).

1.2 Гадаад сектор


Төлбөрийн тэнцэл

2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн урсгал данс 3,155.6 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 1,471.7 сая ам.долларын ашигтай гарснаар төлбөрийн тэнцлийн алдагдал 1,883.3 сая ам.долларт хүрсэн байна.

Зураг 11: Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл



Зураг 12: Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк

Урсгал тэнцлийн алдагдал 2013 онд өмнөх оноос 6%-иар буюу 206.7 сая ам.доллараар буурчээ. Үүнд: i/ барааны гадаад худалдааны дансны алдагдал 15%-иар буурч 1,314.5 сая ам.долларт, ii/ орлогын дансны алдагдал 29%-иар буурч 670.3 сая ам.долларт, iii/ урсгал шилжүүлэг дансны ашиг 40%-иар буурч 142.7 сая ам.долларт хүрсэн нь тус тус нөлөөлөв. Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал нь мөчлөг дагасан төсвийн огцом тэлэлт, хавтгайрсан халамжаар тэжээгдсэн хэрэглээний өсөлт, түүнийг дагасан хэрэглээний импортын огцом өсөлт, уул уурхайн бүтээгдхүүний үйлдвэрлэлээр голлон тайлбарлагдах нефтийн импортын өсөлт, хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх тоног төхөөрөмж, машин механизмын импортын өсөлттэй холбоотойгоор 2011 онд ДНБ-ий 32%, 2012 онд 33%-д тус тус хүрч байсан бол 2013 онд 26%-тай тэнцэх хэмжээнд болж буураад байна. Энэ нь нэг талаас төгрөгийн бодит ханш суларсантай уялдан хэрэглээний импорт буурснаар тайлбарлагдах бол нөгөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсантай бас холбоотой юм.


Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл тайлант онд 1,471.7 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 70%-иар буурахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 2,411.3 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 2,476.6 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ. Хөрөнгө оруулалт ийнхүү буурахад нөлөөлсөн хүчин зүйлсийг нэгтгэн дүгнэвэл дараах байдалтай байна:

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1,996.5 (урьдчилсан) сая ам.долларт хүрч, 2012 оноос 55%-иар буурахад:
 - Бүс нутгийн эдийн засагт хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдал бий болсон. Тухайлбал, Хятадаас хөгжиж буй болон бүрэлдэж буй эдийн засагтай орнуудад хийх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2012 оноос эхлэн эрс буурсан.
 - 2013 оны эхээр БНХАУ эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийж, экспорт болон хуримтлалд суурилсан эдийн засгаас дотоодын хэрэглээнд суурилсан эдийн засаг руу алхам алхмаар шилжих бодлого баримтлах болсон нь дэлхийн зах зээлд эрдэс түүхий эдийн үнэ буурахад нөлөөлсөн бөгөөд энэ нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдад хүлээлт үүссэн.
 - АНУ-ын холбооны нөөцийн банкнаас мөнгөний тэлэх бодлогын хүрээнд хийж буй мөнгөний нийлүүлэлтээ хумихаар төлөвлөсөн нь хөгжиж буй орнуудыг чиглэсэн хөрөнгийн ургалыг бууруулахад нөлөөлсөн.
 - 2012 оны 5 дугаар сард УИХ-аас баталсан хуулиас шалтгаалж Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин 2012 оны сүүлийн хагас, 2013 оны эхний 10 сарын турш сөрөг болж, хууль эрх зүйн орчин тодорхой бус болсон нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулсан. Улмаар энэ нь дунд болон жижиг хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 79 хувиар буурахад шууд нөлөөлсөн.
 - Оюутолгой төслийн эхний шатны бүтээн байгуулалтын ажил дуусч үйлдвэрлэл нь эхэлсэн хэдий ч, 2 дахь шатны хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдээгүй, талууд хоорондын хэлэлцээр он дамнан удааширч байгаа нь тус төслийн хөрөнгө оруулалтад төдийгүй Монголд орж ирэх нийт гадаадын хөрөнгө оруулалт буурахад нөлөөлсөн.
- Багцын хөрөнгө оруулалтын данс 151.1 сая ам.доллар алдагдалтай гарахад:
 - Худалдаа хөгжлийн банкны бондын эргэн төлөлт хийгдсэн,
 - Засгийн газар шинээр бонд гаргаагүй зэрэг нь нөлөөлсөн.

Зураг 13: Хөрөнгө ба санхүүгийн тэнцлийн бүтэц



Зураг 14: Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2013 оны 4 дүгээр улирлын эцэст -19,361.8 сая ам.доллар байна.

Хүснэгт 3: Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2013 оны эцэс (сая ам.доллар)

A. ГАДААД АКТИВ	4,033	B. ГАДААД ПАССИВ	23,395
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	552	6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	15,471
2. Багцын хөрөнгө оруулалт	120	7. Багцын хөрөнгө оруулалт	2,479
3. Санхүүгийн дериватив	0	8. Санхүүгийн дериватив	0
4. Бусад хөрөнгө оруулалт	1,113	9. Бусад хөрөнгө оруулалт	5,445
5. Нөөц актив	2,248	В. ПОЗИЦ	(19,362)

Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсаас эдийн засгийн харьят буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 4,032.9 сая ам.доллар байна. Үүний 56%-ийг гадаад валютын албан нөөц, 28%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 14%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 3%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 23,394.6 сая ам.долларт хүрчээ. Үүний 66%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 23%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 32%-ийг буюу 5,020.3 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 68% буюу 10,450.3 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Хүснэгт 4: Гадаад хөрөнгө оруулалтын позиц, данс тус бүрээр (сая ам.доллар)

	2010	2011	2012	2013
Нийт позиц	(1,678)	(7,692)	(14,219)	(19,362)
Гад. шууд хөр.оруулалтын позиц	(2,048)	(7,602)	(12,267)	(14,918)
Багцын хөр.оруулалтын позиц	(230)	(313)	(2,584)	(2,359)
Сан.үүсмэл.хэр-ийн позиц	(0)	(0)	-	-
Бусад хөр.оруулалтын позиц	(1,688)	(2,228)	(3,495)	(4,333)
ГВАН-ийн үлдэгдэл	2,288	2,451	4,126	2,248

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх 2012 оноос 36%-иар буюу 5,144.4 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 37%-иар буюу 2,347.2 сая ам.доллараар буурч, гадаад пассив 13%-иар буюу 2,797.1 сая ам.доллараар нэмэгдсэнээр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,651.4 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалт 24%-иар буюу 839.9 сая ам.доллараар тус тус өсч, харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 9%-иар буюу 224.9 сая ам.доллараар, ГВАН 46%-иар буюу 1,878.1 сая ам.доллараар тус тус буурснаар тайлбарлаж болохоор байна.

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр (улсын секторын болон хувийн хэвшлийн бүгд)-ийн үлдэгдэл 2013 оны эцэст 18,920.6 сая ам.долларт хүрч, 2012 оны эцсийн гүйцэтгэлээс 23%-иар буюу 3,536.1 сая ам.доллараар өсчээ. Үүнд:

- Банкнаас бусад дотоодын хувийн хэвшлийн салбарын аж ахуйн нэгж байгууллагын гадны банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл 2012 оноос 48%-иар өсч, 1,884 сая ам.долларт хүрсэн,
- Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй томоохон аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулагчаасаа авсан зээлийн эх үүсвэр 25%-иар буюу 2,092.9 сая ам.доллараар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Засгийн газрын болон түүний баталгаатай гадаад зээлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2011 онд 22%, 2012 онд 41%, 2013 онд 36% байна.

Хүснэгт 5: Монгол улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
Нийт гадаад өр	5,928	9,628	15,385	18,921	3,536	23%
I. Засгийн газар	1,788	1,951	4,264	4,256	-8	-0.2%
II. Төв банк	274	268	414	1,065	651	157%
III. Банк	506	710	1,074	1,265	190	18%
Богино хугацаат	77	82	58	118	60	103%
Урт хугацаат	429	628	1,016	1,147	131	13%
IV. Бусад сектор	646	949	1,275	1,884	609	48%
Богино хугацаат	289	502	508	451	-57	-11%
Урт хугацаат	357	447	768	1,433	665	87%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	2,715	5,750	8,357	10,450	2,093	25%

Эх сурвалж: Засгийн газрын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав

Шигтгээ 1:

Хөгжингүй орнуудад хэрэгжүүлж буй мөнгөний уламжлалт бус бодлого (QE)

Мөнгөний бодлогын уламжлалт арга хэрэгсэл болох бодлогын хүүг цаашид бууруулах орон зай байхгүй болсон буюу 0 орчим хувийн түвшинд ирсэн нехцөлд уламжлалт бус Quantitative Easing (QE) буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах замаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих бодлогыг хөгжингүй орнууд 2008 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2008, 2009 оны дэлхийн банк санхүүгийн хямраалаас хойш Холбооны нөөцийн банк (FED), Европын төв банк (ECB), Англи (BOE), Япон (BOJ) зэрэг орнуудын төв банкууд QE-г түлхүү ашиглах болсон. Гэхдээ QE-ээр нэмэгдүүлсэн мөнгөний нийлүүлэлт нь Англи болон АНУ-ын хувьд дээд тал нь M2 мөнгөний 14%-д хүрч байсан бол Японы төв банк 2013 онд M2-н 7.4%-тай тэнцэхүйц хэмжээгээр нэмэгдүүлж байжээ.

Хүснэгт 6: QE-ын хэмжээ, ДНБ ба М2 мөнгөний нийлүүлэлтэд харьцуулснаар

M2 мөнгөний нийлүүлэлтэд эзлэх хувь				2013 оны нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь				
	FED	BOE	BOJ		FED	BOE	BOJ	BOM
2008	7.4		0.2		1.0		0.3	
2009	13.8	13.6	2.4		1.8	13.2	3.8	
2010	6.9		3.6		1.0		5.9	
2011	0.0	3.6	2.6			4.0	4.4	
2012	6.4	5.0	7.0		0.4	5.3	12.2	
2013	9.3		7.4	38.6	1.5		13.3	20.8

Эх сурвалж: Улс бүрийн төв банкны цахим хуудас

Английн төв банкны QE хөтөлбөрийг 2009-2012 оны хооронд хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь Засгийн газрын бондын хүүг бууруулах, үнэт цаасны үнийг өсгөх замаар зээл олголт, хөрөнгө оруулалт, улмаар бодит үйлдвэрлэлийг дэмжиж, ДНБ-ий өсөлтөд жилийн 1.5 нэгж хувийн зерэг нөлөө үзүүлсэн хэмээн судлаачид дүгнэсэн байна. Хэдийгээр эдийн засгийн өсөлтөд зерэг нөлөө үзүүлсэн боловч QE хөтөлбөр нь дээрх хугацаанд инфляцийг жил бүр 1.25 нэгж хувиар нэмэгдүүлж, орлогын тэгш хуваарилалтад сөргөөр нөлөөлсөн хэмээн зарим судлаачид тооцоолсон байна. Тодруулбал санхүүгийн хөрөнгийн 40 гаруй хувийг нийт иргэдийн 5% буюу чинээлэг өрхүүд эзэмшдэг бөгөөд QE-н нөлөөгөөр дээрх өрхүүдийн баялаг төдий чинээгээр нэмэгдэж, нөгөө талаас QE-ийн нөлөөгөөр хадгаламжийн хүү буурахад тэтгэврийн сангийн өгөөж буурч, ядуу өрхийн ирээдүйн орлогод сергөөр нөлөөлсөн гэж тэд үзсэн байна.

Японы төв банк 2013 оны 4 дүгээр сараас эхлэн шинэ QQE (quantitative and qualitative easing) хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүний гол зорилго нь урт хугацааны хүүг бууруулж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, цаашид мөнгөний бодлогын төлвийг сулруулах замаар хувь хүн, корпорацийн инфляцийн хүлэлтийг нэмэгдүүлж, инфляцийн түвшинг 2%-д хүртэл нэмэгдүүлэх явдал юм. Тодруулбал, QQE хөтөлбөрийн хүрээнд төв банк нь засгийн газрын бондыг ихээр худалдан авч, тэдгээрийн дундаж хугацааг 3 жилээс 7 жил болгон сунгасан нь урт хугацааны хүүг бууруулахад чиглэсэн qualitative арга хэмжээ бөгөөд ингэснээр пүүс, ААН-Үүдийн урт хугацааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар цалинг өсгөх гол зорилготой байна. 15 жилийн турш дефляцитай байсан Япон улс энэхүү хөтөлбөрийн үр дүнд 2013 оны 12 дугаар сарын байдлаар 1.6%-ийн инфляцитай болсон нь том амжилт болоод байна.

АНУ-ын Холбооны нөөцийн банк түүхэндээ 3 удаагийн QE хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд үүний сүүлийнх буюу QE3 хөтөлбөр нь 2012 оны 9 дүгээр сараас өнөөдрийг хүртэл үргэлжилж байна. QE3 хөтөлбөрийн хүрээнд Холбооны нөөцийн банк сар бүр 85 тэрбум ам.доллартай тэнцэхүйц актив хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ABS) худалдан авч, санхүүгийн зах зээлийг мөнгөн урсгалаар тэтгэх, хөрөнгө оруулалт, ажилгүйдлийн түвшинг бууруулах зорилготой ажиллаж ирсэн. Үүний үр дүнд 2012 оны 8 дугаар сард 8.1% байсан ажилгүйдлийн түвшин 2014 оны 2 дугаар сард 6.7% болж буурчээ. Цаашид бизнесийн орчин сэргэж, ажил олголт, бодит секторын Үйл ажиллагаа нь өөрийн өсөлтийг хангах боломжтой гэж үзсэн тул 2013 оны 12 дугаар сараас эхлэн Холбооны нөөцийн банк үнэт цаасны худалдан авалтын хэмжээг аажмаар бууруулж, 2014 оны 4 дүгээр сарын байдлаар сар бүр 55 тэрбум ам.доллар ABS худалдан авч байна.

Ерөнхийдөө ажилгүйдлийн түвшин зорилтот 6.5%-д хүрч буурах, инфляцийн түвшин зорилтот 2%-ийн түвшинд хүрч өсөх хүргэлт QE3 хөтөлбөр үргэлжилж, бодлогын хүү 0-0.25% буюу хэт нам түвшинд байх бөгөөд 2014 оны 10 дугаар сар гэхэд бонд худалдан авах хөтөлбөрийг аажмаар зогсоох төлөвлөгөөтэй байна.

Монгол Улсад нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамт олон жилийн турш өндөр байсны зэрэгцээ 2013 онд эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал 4 тэрбум ам.доллараар буурч, гадаад цэвэр актив 78.5%-иар буюу 3.5 их наяд төгрөгөөр буурснаар санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй хямрал нүүрлэх бодит аюул тохиолдохоор байлаа. Иймд эдийн засгийг тогтвортжуулах зорилгоор Монголбанкнаас мөчлөг сөрсөн мөнгөний бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн бодит секторт мөнгөний нийлүүлэлтийг тодорхой зориулалтаар хийх шаардлага гарсан билээ. Ийнхүү эдийн засгийг тогтвортжуулах арга хэмжээний хүрээнд Монголбанк (i) нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулах, бараа, бүтээгдэхүүний хангамжийн зах зээлийн зарчимд суурилсан тогтолцоог бүрдүүлэх зорилгоор 677 тэрбум, (ii) банкны салбарт зээлийн тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн хямралын эрсдэлээс хамгаалах зорилгоор 900 тэрбум, (iii) орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор 534.5 тэрбум, (iv) орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлж, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 1540 тэрбум төгрөгийг, 2013 онд нийт 3.6 их наяд төгрөгийн буюу M2 мөнгөний 38.6%, нэрлэсэн ДНБ-ий 20.8%-тай тэнцэх хэмжээний мөнгөний нийлүүлэлтийг зөвхөн хувийн хэвшлээр дамжуулан, эдийн засгийн бодит секторт нийлүүлснээр санхүүгийн болон макро тогтвортой байдлыг хадгалж, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг ханган, болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлсэн болно.


Хөгжсөн орнуудын төв банкуудаас хийсэн QE-ийн M2 мөнгө, ДНБ-д эзлэх хувь хэмжээтэй харьцуулахад Монголбанкны QE-н Монголын M2, ДНБ-д эзлэх хувь хэмжээ өндөр байгаагаас үзэхэд 2011 оны сүүл үеэс эхлэлтэй гадаад эдийн засгийн сөрөг нөлөөлөл, 2012 оны эцэс, 2013 оны эдийн засгийн хүндэрэл нь Монгол Улсад санхүү, эдийн засгийн ямархуу хэмжээний ужиг хямрал авчирч болзошгүй байсан нь тодорхой байна.

1.3 Мөнгө, санхүүгийн сектор

Мөнгөний үзүүлэлтууд

2012 оны турш эрчимтэй буурч байсан мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт нь эдийн засгийг тогтвортжуулах Монголбанкны бодлогын арга хэмжээ, Монголбанк, Засгийн газрын хамтран хэрэгжүүлсэн гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах дунд хугацааны хөтөлбөрийн нөлөөгөөр 2012 оны 12 сараас тогтвортжсон бөгөөд 2013 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 24.3%-иар өсч, 9.5 их наяд төгрөгт хүрчээ. M2 мөнгөний 24.3%-ийн өсөлтөд бараг мөнгөний өсөлт, түүн дотроо төгрөгийн хадгаламжийн өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 31%-ийг дангаараа тайлбарлаж байна.

Зураг 15: Зээлийн өсөлт болон M2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүн хэсгүүдээр



Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний нийлүүлэлтэд гадаад цэвэр актив (ГЦА)-ын нөлөө -45.4% байгаа бол Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) 17.8%-ийг, Монголбанкаас хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд олгосон болон банк өөрийн эх үүсвэрээр олгосон зээл 49.6%-ийг, үлдсэн хэсгийг бусад дотоод цэвэр активын зүйл тайлбарлаж байна.


Монголбанкаас 2013 оны 12 дугаар сарын байдлаар нийт 1540.9 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийн эх үүсвэрийг банкуудад олгосон бөгөөд үүний 51.3% нь шинээр орон сууцны ипотекийн зээл болж гарсан байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ург хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэх, шинээр ипотекийн зээл олгох зорилгоор Монголбанкаас хийсэн мөнгөний нийлүүлэлтийг хасч тооцвол 2013 онд M2 мөнгөний жилийн өсөлт 12.1%, банкны салбарын нийт зээлийн жилийн өсөлт 40.8% байхаар байв. M2 мөнгөний жилийн өсөлт болон зээлийн жилийн өсөлтөөс орон сууцны ипотекийн зээлийн нөлөөг тусад нь салгаж харуулав (Зураг 16-17).

Зураг 16: М2 мөнгөний жилийн өсөлт (%)




Зураг 17: Зээлийн жилийн өсөлт (%)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 18. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц



Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл сүүлийн жилүүдэд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин буурч, төгрөгийн хадгаламжийн эзлэх хувийн жин нэмэгджээ. 2013 оныг өмнөх онтой харьцуулахад төгрөгийн хадгаламжийн эзлэх хувийн жин өсч, харин банкнаас гадуурх мөнгө, валютын харилцах, хадгаламжийн жин буурсан байна (Зураг 18).

Эх сурвалж: Монголбанк

Шигтгээ 2: Үнийн тогтвортой байдал


Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д “Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний монгол тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино” гэж, харин 22 дугаар зүйлийн 2-т “Монголбанк гадаад валюттай харьцах төгрөгийн ханишны бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ ханиш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална” хэмээн заасан байдаг.

Хуульд зааснаар Монголбанкны үндсэн үүрэг, зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх төгрөгөөр илрхийлэгдэж байгаа бараа, үйлчилгээний үнийн тогтвортой байдлыг хангахад буюу инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгахад оршиж байна. Харин төгрөгийн гадаад валюттай харьцах ханиш нь чөлөөтэй бөгөөд бодитой тогтоходоо үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилт болон эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангахад нийцтэй байхыг хуульд тодорхой зааж өгчээ.

Үнийн тогтвортой байдал гэдэг нь эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшний өөрчлөлттэй холбоотой ойлголт юм. Үнийг тогтвортой байлгана гэдэгт инфляци төдийгүй дефляци (үнийн бууралт)-аас зайлсхийх явдлыг ч хамруулж ойлгоно.


1997 онд Levine, 2000 онд Khan болон Senhadji нар ДНБ болон инфляцийн хоорондох хамаарлыг 140-өөд орны жишээн дээр зэрэгцүүлэн судалсны үр дүнд эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн зайлшгүй нөхцөл нь тогтвортой, бага инфляци гэдгийг олж тогтоожээ. Тэд эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхгүй байх инфляцийн хэмжээг хөгжингүй орнуудын хувьд 1-3%, харин хөгжиж буй орнуудын хувьд 7-11% байх боломжтой хэмээн дүгнэсэн байдаг.

Зураг 19: Инфляци болон эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Levine (1997), Khan, Senhadji (2000)

Зураг 20: Төв банкны зорилтын тоо ба нэг хүнд ногдох ДНБ



Эх сурвалж: BIS, 2008 (41 төв банкны судалгааны дүн)

Дэлхийн ихэнх Төв банк өдгөө үнийн тогтвортой байдлыг үндсэн зорилтоо болгон ажиллаж байна. Тухайлбал, Евро бүсийн гишүүн орнууд инфляцийг 1.5-2%-иас, харин зэсийн экспорт эдийн засагт нь голлох үүрэг гүйцэтгэдэг Чили улс 3%-иас хэтрүүлэхгүй байх зорилтыг тавьдаг байна.

Нөгөө талаас төв банкны зорилтын тоо (үнийн тогтвортой байдлаас гадна бусад) нэмэгдэх тусам нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ буурах хамаарал ажиглагдаж байна (Зураг 20).

Төв банк инфляцийг тогтвортой, бага түвшинд байлгаснаар үндэсний мөнгөн тэмдэгтийн худалдан авах чадварыг хамгаалж, хүмүүсийн ирээдүйдээ итгэх итгэлийг тогтвортой үнээр төсөөлүүлэн бий болгодог байна. Энэхүү тогтвортой байдал нь хадгаламж, хөрөнгө оруулалт, бүтээмжээс олох үр ашгийг урамшуулдгаараа эдийн засгийн өсөлттэй салшгүй холбоотой билээ. Үүгээр ч зогсохгүй, тогтвортой бага инфляци нь хүн амын эмзэг бүлэг, дундаж давхаргын бодит орлогыг хамгаалж байдгаараа нийгэмд орлогын хэт ялгаа бий болгохгүй байх ач холбогдолтой юм.

Ийм учраас мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлыг хангах хүрээнд эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөө (санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, ДНБ, ажил эрхлэлтийн савалгаа гэх мэт)-г зөөлрүүлэх зарчим баримталдаг.

Монгол Улсад үнийн тогтвортой байдлыг хангахад хэд хэдэн бодит хүндрэл тулгарч байдаг. Юуны түрүүнд, эдийн засагт бүтцийн өөрчлөлт үргэлжилж байгаа тул мөнгөний бодлогын шилжих механизмын мөн чанар, сувгууд, тэдгээрийн нөлөөллийг бүрэн гүйцэд тогтооход хүндрэлтэй юм. Хоёрдугаарт, төв банкны мөнгөний бодлого нь эдийн засаг дахь нийт эрэлтийг зохицстой удирдах замаар хэрэгжиж байдаг.

Гэтэл Монгол Улсын ХҮИ-ийн сагс нь эрэлт гэхээсээ илүүтэйгээр нийлүүлэлтээс хамаарах бүтэцтэй байдаг. Ийм ч учраас Монгол Улсад олон жилийн турш өндөр инфляцийн нэлээд хэсгийг нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын хүчин зүйлс, тэр дундаа хүнс, шатахууны тасалдал, нийлүүлэлтийн үр ашиггүй, сүл тогтолцоо, дэд бүтцийн хязгаарлалтууд тодорхойлж байв.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг бууруулахын тулд Монголбанкнаас Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү хөтөлбөр нь дундаж давхаргын хэрэглээний амин чухал бүтээгдэхүүн болох мах, гурил, шатахууны жижиглэнгийн үнийн өсөлтийг аль болох тогтвортой байлгах, санхүүгийн зах зээлд агуулахын санхүүжилтийн механизмыг шинээр бий болгоход чиглэж байна. Ийнхүү бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг цоо шинээр нэвтрүүлснээр бараа, бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн зах зээлийн зарчимд суурилсан байнгын бөгөөд үр ашигтай тогтолцоог бүрдүүлэх юм.

Үнийн тогтвортой байдал хангагдсанаар инфляцийн хүлээлт буурах ба улмаар санхүүгийн хэлцлүүдийн хугацаа уртсах, өгөөжийн муруй бий болох үндэс бүрдэнэ. Энэ нь хөрөнгийн зах (компанийн бондын зах, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн зах) хөгжих зайлшгүй угтвар нөхцөлүүдийн нэг юм. Ийнхүү үнийн тогтвортой байдлыг хангаснаар Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2-т заасан “Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжсилд дэмжслэг үзүүлнэ” гэсэн зорилтыг мөн давхар хангах боломжтой болно.

Санхүүгийн салбар

Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Банкны салбарт 2013 оны эцсийн байдлаар нийт 13 банк, 1409 салбар, нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.5 сая, зээлдэгчдийн тоо 693.9 мянгад тус тус хүрлээ.

• Актив

Тайлант оны эцэст банкны салбарын нийт активын хэмжээ 19.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 68.2%-иар өссөн нь банкны салбарын хувьд активын өндөр өсөлттэй он байсныг харуулж байна. Энэхүү өсөлтийг бүрдүүлэхэд богино хугацаат хөрөнгө оруулалт болон зээлийн өсөлт давамгайлах нөлөө үзүүлжээ. Тухайлбал, богино хугацаат хөрөнгө оруулалт болох засгийн газрын үнэт цаасанд байршуулсан хөрөнгө 2013 оны эцэст 400.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 24.2%-иар, Төв банкны үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалт 1.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 114%-иар тус тус өссөн байна.

Банкны салбарын активыг бүтцээр нь авч үзвэл 2013 оны эцсийн байдлаар банкны салбарын нийт активын 53.1% нь зээл, 22.3% нь мөнгөн хөрөнгө, 11.5% нь богино хугацаат хөрөнгө оруулалт, 8.7% нь урт хугацааны хөрөнгө оруулалт, үлдэх 4.3% нь бусад хөрөнгө байна. Богино хугацаат хөрөнгө оруулалтын 0.6% нь хувьцаа байна. Үүнээс үзэхэд хөрөнгийн зах зээл нь банкны системийн активын чанарт шууд нөлөөлөхөөргүй гэж дүгнэхээр байгаа юм.

Банкны салбарын үндсэн актив болох зээлийн өрийн үлдэгдэл тайлант онд нийт 10.4 их наяд

төгрөгт хүрч, өмнөх оноос 3.6 их наяд төгрөгөөр буюу 52.6%-иар өсчээ. Нийт зээлийн 96.6% болох 10 их наяд төгрөгийн зээл нь хэвийн ангилалд, 1.1% болох 115.6 тэрбум төгрөгийн зээл нь хугацаа хэтэрсэн ангилалд, 2.5% болох 261.4 тэрбум төгрөгийн зээл нь чанаргүй ангилалд тус тус бүртгэгдсэн байна. Зээлийн чанарын үндсэн үзүүлэлт болох чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 113.4 тэрбум төгрөгөөр буюу 76.4%-иар нэмэгдсэн хэдий ч, нийт зээлд эзлэх хувийн жин нь өмнөх онтой харьцуулахад харьцангуй тогтвортой буюу 0.3%-иар л өсчээ.

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар авч үзвэл барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт 30.1%, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 16.3%, уул уурхайн салбарт 12.4%, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 10.1%, бусад салбарт 31.1% тус тус ногдож байна. Нийт зээлд эзлэх тухайн салбарын хувийг өмнөх онтой харьцуулахад барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар хамгийн их буюу 3.1 нэгж хувиар өссөн бол бусад салбарынх 2.5 нэгж хувиар буурчээ.

Зээлийн эргэн төлөлтөд эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал, бизнесийн орчин, гадаад валютын урсгал, хөрөнгө оруулалт, валютын ханиш, инфляци, үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. 2013 онд Монгол Улсын гадаад валютын орох урсгал 4 тэрбум ам.доллараар буурч, гадаад цэвэр актив огцом багассанаас шалтгаалж эдийн засагт хүндрэл бий болсон билээ. Энэ нь банкны системд чанаргүй зээл өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байв. Зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлээс үүсч болзошгүй алдагдлаас хамгаалах чиглэлд банкууд 2013 оны эцсийн байдлаар чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн 71.6% буюу 187.2 тэрбум төгрөгийн сан байгуулж ажилласан байна. Чанаргүй зээлийг тус сангаар цэвэршүүлэхэд 74.2 тэрбум төгрөг буюу нийт зээлийн багцын 0.7% болж байгаагаас дүгнэхэд чанаргүй зээлээс үүсч болзошгүй хохирлыг барагдуулах, эрсдэл даах чадвар банкны системд хангалттай сайн байгааг харуулж байна.

• **Эх үүсвэр**

Банкны салбарын нийт пассивын хэмжээ тайлант оны эцэст 17.5 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 7.4 их наяд төгрөгөөр буюу 68.3%-иар нэмэгджээ. Энэхүү өсөлтөд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр буюу ялангуяа эдийн засгийг тогтвортжуулах бодлогын хүрээнд Монголбанкаас банкуудад олгосон зээл 2.8 их наяд төгрөгт хүрсэнтэй холбоотой. Нийт пассивыг бүтцээр нь авч үзвэл 43.4% хадгаламж, 16.9% харилцах, 28.8% банк бус санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 10.8% нь бусад эх үүсвэр байна.

Банкны салбарын үндсэн эх үүсвэр болох хадгаламжийн үлдэгдэл тайлант оны эцсийн байдлаар 7.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 49.7%-иар буюу 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдлээ. Нийт хадгаламжийн 67.3% буюу 5.1 наяд төгрөгийг хувийн салбар болох иргэд, аж ахуйн нэгж, гадаадын оршин суугчаас татсан нь өмнөх оноос 16.2%-иар буюу 714.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч, хувийн жингээрээ 19.4 нэгж хувиар буурлаа. Түргэн хугацаанд хэлбэлзэх шинж чанартай харилцахын үлдэгдэл 3 их наяд төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 28.2%-иар буюу 652.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд хувийн секторын харилцахын өсөлт харьцангуй өндөр байж 2 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 53.6%-иар буюу 691 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.

2013 оны эцэст банкны системийн гадаад валютаар татсан эх үүсвэрийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин 2012 оны эцсээс 8.6 нэгж хувиар буурч 30.6%-д хүрсэн нь гадаад валютын урсгал олон улирал дамжиж огцом муудсан, төлбөрийн тэнцэлд дарамт үүссэнтэй холбоотой юм. Үүнээс гадаад валютаар олгосон зээлийн хувийн жин тайлант онд 5.1 нэгж хувиар буурч 27.5%-д хүрсэн

байна. Энэ нь валютын ханшийн хэлбэлзлээс шалтгаалан зээлдэгч, зээлдүүлэгчийн валютаар зээл авах болон зээл олгох сонирхол буурсантай шууд холбоотой.

Тайлант оны эцсийн байдлаар банкны салбарын зээл ба хадгаламж, харилцахын харьцаа өмнөх оны мөн үеэс 6.2 нэгж хувиар нэмэгдэж 98.3%-д хүрчээ. Өөрөөр хэлбэл, банкны салбарт зээлийн өсөлтийг богино хугацаат эх үүсвэрээр санхүүжүүлэх үйл ажиллагаа нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2011 оны эцэст банкны системийн бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн 80.9% нь харилцах, хадгаламж байсан бол тус үзүүлэлт буурч 2012 оны эцэст 72.8%, 2013 оны эцэст 60.4% болсон байна. Гэвч Базелийн хорооноос шинээр нэвтрүүлж буй банкны системийн урт хугацааны санхүүжилтийн зохистой харьцааны үзүүлэлт (NSFR ratio¹)-ийг 2013 оны үзүүлэлтэд үндэслэн тооцоход 129.5% байгаа нь банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр буюу харилцах, хадгаламж, өөрийн хөрөнгө, 1-ээс дээш жилийн хугацаатай банк хоорондын захын эх үүсвэр давамгайлсан хэвээр байгааг харуулж байна.

Зураг 21: Тогтвортой санхүүжилтийн үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

• Зохистой харьцааны үзүүлэлтүүд

Банкны үйл ажиллагааны зохистой харьцааг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт, зээлийн төвлөрлийн эрсдэл зэрэг үзүүлэлтээр тооцоолж байна.

• Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкны системийн эрсдэл даах чадварын үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн хэмжээ тайлант оны эцэст 1.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны эцсээс 35.2%-иар буюу 477.3 тэрбум төгрөгөөр

¹ Базелийн хорооноос энэхүү үзүүлэлтийг тооцох нарийн аргачлалыг тодорхойлсон байдаг. Манай орны хувьд тус үзүүлэлтийг санал болгосон аргачлалаас бага зэрэг өөрөөр тооцсон.

нэмэгджээ. 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банкны системийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16%, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12% байгаа нь Монголбанкаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс харгалzan 4 болон 3 нэгж хувиар тус тус өндөр байна. Монголбанкаас тогтоон мөрдүүлж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт нь олон улсад шинээр нэвтрүүлж буй Базел III-ын суурь шаардлагуудаас өндөр байгаа болно.

- Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**

Банкуудын хөрвөх чадвар сайтай, эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд хийсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс шалтгаалан банкны салбарын эх үүсвэр гэнэт гадагшлах эрсдэлийг даах чадвар 2013 онд харьцангуй сайжирсан байна. Тухайлбал, тайлант оны эцэст төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 44.4%-д хүрсэн нь өмнөх оноос 5.6 нэгж хувиар, Монголбанкаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 19.4 нэгж хувиар тус тус өндөр байна.

Зураг 22: Зохистой харьцааны биелэлт



Зураг 23: Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Эх сурвалж: Монголбанк

Банкны төлбөр түргэн гүйцэтгэх болон хөрвөх чадварыг хадгалах чиглэлд Базел III-aas Liquidity coverage ratio (LCR)² гэсэн үзүүлэлтийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. LCR нь банкны богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны үзүүлэлт бөгөөд үүний хүрээнд хямралын үед банкнаас 30 өдрийн турш орж, гарах цэвэр мөнгөн ургалын тодорхой хувийг хангах чадвартай активыг байршуулах шаардлага тавигдах юм.

Манай орны хувьд LCR тооцох мэдээллийн боломж байхгүй хэдий ч, түүнтэй төстэй үзүүлэлт буюу банкны системийн хөрвөх чадвар сайтай актив (бэлэн мөнгө, богино хугацаат хөрөнгө оруулалт), банкнаас богино хугацаанд гадагшлах бололцоотой эх үүсвэр (харилцах, хугацаагүй хадгаламж, дотоодын болон гадаадын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр)-ийн харьцаа 2013

² LCR like-нь Liquidity coverage ratio бөгөөд манай орны хувьд түүнийг Базелаас тодорхойлсноор тооцох мэдээллийн боломж байхгүй тул ойролцоолон тооцсон.

оны эцсийн байдлаар 113.3% байгаа нь банкны систем богино хугацаанд гарч болзошгүй мөнгөн ургалыг барагдуулах чадвар сайтай байгааг харуулж байна.

• *Гадаад валютын зохистой харьцаа*

Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15%-ийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40%-ийн дотор барьж байх шаардлагатай. 2013 оны эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт хамгийн өндөр нэгж валютын хувьд -10.2%, нийт валютын хувьд 14.8% байсан бөгөөд энэ нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Бодлогын арга хэмжээ

Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 404 дүгээр тушаалаар өгөгдсөн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2013 оны эхний хагас жилд 16 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг банкууд амжилттай хэрэгжүүлсэн.

Банкуудын зээлийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд банкуудад хийх шалгалтын давтамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төвлөрөл ихтэй, холбогдох этгээдийн зээлүүдийг шалгахад илүү анхаарал хандуулж, тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасан албадлагын арга хэмжээг тухай бүр авч ажиллалаа. Үнийн зэрэгцээ газар дээрх шалгалтыг банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх чиглэлд түлхүү хандуулж, банкны эрсдэлийн үнэлгээний аргачлал нь оновчтой эсэх, хүлээж болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах бодлого нь үр дүнтэй эсэх, дотоод хяналтын систем нь хангалттай эсэх зэрэгт үнэлгээ өгч байна.

Банкны системийн тогтвортой байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хувь нийлүүлэгчтэй холбоотой чанаргүй зээлээс шалтгаалан өөрийн хөрөнгө нь алдагдсан Хадгаламж банкны зарим актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд шилжүүлэх үйл ажиллагааг ганцхан өдрийн дотор амжилттай зохион байгууллаа. Ингэснээр банкны нэг ч гүйлгээнд saat алгарч бөгөөд үйл ажиллагаа нь тасалдалгүй хэвийн явагдсан болно.

Түүнчлэн тайлант онд банкуудаас болзошгүй хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, холбогдох бусад төлөвлөгөөг гаргуулан авч, үнэлгээ дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон ажиллав. Энэхүү үйл ажиллагаа нь банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах, банкийг хүндрэлээс богино хугацаанд гаргах, төлбөрийн чадварыг шуурхай сэргээх ажлын суурь болох чухал ач холбогдолтой.

Монголбанкнаас эдийн засгийг тогтвортжуулах, болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн идэвхжилийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн бодлогын хүрээнд барилга, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, агуулахын салбарыг хөгжүүлэх чиглэлд явуулж буй бодлогыг банкны үйл ажиллагаагаар дэмжих, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үнэлгээ, эрсдэлийн түвшинг оновчтой тодорхойлох зорилгоор “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тодорхой өөрчлөлт оруулан, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаж байна.

Дунд хугацааны инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах үндсэн зорилтыг хангахын тулд гол нэрийн бараа, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, үнийг тогтвожуулах зорилготой хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс батлагдсан “Банкны өөрийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх түр журам”-ын хэрэгжилтийг тус хөтөлбөрт хамрагдсан банк бүрээр хянаж, холбогдох үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй 8%-ийн хүйтэй ипотекийн зээлийг олгох банкны бодлого, түүний хэрэгжилт нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгаж, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах, заавар зөвлөмж өгөх, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллав.

Хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий Хадгаламжийн даатгалын корпорацийн дүрэм, журам, бүтэц, орон тоог тогтоох үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан болно.

Төв банкны тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх, иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээг олон нийтэд ил тод, тодорхой болгох, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор “Банкны хүү бodoх аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна.

Базелын хорооноос шинээр хэрэгжиж буй Basel стандартын үзүүлэх нөлөөллийг судалж, түүнтэй Монголбанкны өөрийн хөрөнгийн болон бусад үзүүлэлтийг уялдуулах бодлого баримтлан ажиллаж байна. Ингэснээр санхүүгийн салбарын эрдэл даах чадварыг сайжруулснаар системд үүсч болзошгүй гэнэтийн сөрөг нөлөөллөөс үүдэлтэй санхүүгийн эмзэг байдлыг үүсгэхгүй байх, үүссэн тохиолдолд санхүүгийн тогтвортгүй байдал, улмаар хямралд орох нөхцөлөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлэх юм. Үүнтэй холбоотойгоор Монголбанкаас хяналт шалгалтын талаар 2018 он хүртэл баримтлах дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичгийг олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, олон улсад нийтээр мөрдөгдөх хэм хэмжээг үндэслэн боловсруулаад байна. Ингэснээр банкны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгох, эрдэлийн үнэлгээнд суурилсан хяналт, шалгалтын арга, аргачлалыг нэвтрүүлэх боломж бүрдлээ.

Түүнчлэн банкны системд мөрдөгдөж буй нягтлан бodoх бүртгэлийн багц материалыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг тайлант онд гүйцэтгэж, 2014 онд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Чанаргүй зээлийн эргэн төлөлтийг түргэтгэж, банкны зардлыг бууруулах үүднээс үл хөдлөх болон хөдлөх барьцаа хөрөнгийг шүүхийн бус замаар борлуулахтай холбоотой нийт 8 хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг нэгтгэн Хууль зүйн яаман дахь Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүллээ.

Банкны салбарын хяналт шалгалт

• Газар дээрх хяналт шалгалт

Монголбанкнаас 2013 онд баталсан хуваарийн дагуу хийсэн газар дээрх, иж бүрэн шалгалтанд үйл ажиллагаа явуулж буй бүх банкууд хамрагдсанаас, Хадгаламж, Капитрон, Голомт, Зоос банк болон Анод банкны Эрх хүлээн авагчдын зөвлөлийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн нэмэлт шалгалтыг тус тус хийж гүйцэтгэлээ. Тайлант онд нийт 17 удаагийн газар дээрх шалгалт хийснээс 14 шалгалтын тайланг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргасан байна.

Газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэхдээ банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоог үнэлэх чиглэлд түлхүү анхаарч, банкны эрсдэлийн үнэлгээний аргачлал нь оновчтой, хүлээж болзошгүй эрсдэлийн талаарх бодлого нь үр дүнтэй эсэх, дотоод хяналтын систем нь хангалттай эсэхэд үнэлгээ өгч ажиллав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 726 дугаар тушаалын дагуу банкны системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 14 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 9 хувь хүртэл нэмэгдүүлсэн ба тайлант хугацаанд системийн нөлөө бүхий банкууд эдгээр шаардлагуудыг хангаж ажилласан.

Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-168 дугаар тушаалаар баталсан Монголбанк, Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах”, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах”, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах”, “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвортжуулах” дэд хөтөлбөрүүдийн хүрээнд банкуудаас олгосон зээлүүд нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэх, зээл олгох үйл ажиллагааны дараалсан хяналтын тогтолцоо зохистой эсэх талаар үнэлэлт өгч, хяналт тавьж ажилласан болно.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй 8 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээлийг олгох банкны бодлого, түүний хэрэгжилт нь холбогдох хууль, тогтоомжид нийцэж буй эсэхэд үнэлэлт өгөх зорилгоор газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг тухай бүрт хийж гүйцэтгэлээ.

Сүүлийн хоёр жилийн турш Монголбанкны хяналт шалгалтын тусгай хөтөлбөртэй байсан Хадгаламж банкны алдагдлын хэмжээ нэмэгдсэнээс банкны өр төлбөр нь актив хөрөнгөөс давж, өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд алдагдан, төлбөрийн чадваргүй болсон тул Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтын дагуу тус банкинд 2013 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн банкны эрх хүлээн авагч томилон ажиллуулж байна. Банкинд эрх хүлээн авах арга хэмжээ авснаар банкны холбогдох хувь нийлүүлэгчид санхүүгийн хариуцлага хүлээлгэн, хувь нийлүүлсэн хөрөнгөөр алдагдлыг нөхөж, тодорхой хадгаламж, харилцах дансны үлдэгдэл болон бусад өр төлбөрийг актив хөрөнгийн хамт багцлан Төрийн банкинд богино хугацаанд шилжүүлсэн. Ингэснээр Хадгаламж банкны хадгаламж эзэмшигчид, харилцагчдын мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалж, олон нийтэд учрах хохирлыг бууруулснаар банкны салбарын тогтвортой байдлыг хадгалсан болно.

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хадгаламж банкны зарим актив, пассив хөрөнгийг Төрийн банкинд шилжүүлэхтэй холбоотой ажлын хэсэгт хянан шалгагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ орон нутгийн 22 салбар, нэгжид ажиллав.

Тайлант онд Хяналт шалгалтын газрын хянан шалгагч, Улсын байцаагчид шүүх, хууль сахиулах байгууллагын тогтоол, шүүгчийн захирамжаар банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбоотой эрүү, иргэн, захиргааны нийт 14 хэргүүдэд шинжээчийн дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагуудад нь хүргүүлсэн болно.

- Зайнаас хийх хяналт шалгалт***

Тайлант онд банкуудаас сар бүр Хяналт шалгалтын газарт ирүүлэх санхүүгийн тайлан мэдээ, газар дээрх шалгалтын дунд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүргийн биелэлт ба холбогдох бусад хууль, тогтоомжуудын дагуу банкуудад зайнаас хяналт тавих ажлыг тогтмол хийж гүйцэтгэлээ.

Банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу банкуудаас санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээллийг нийтэд ил тод болгох шаардлагын хэрэгжилтэнд тогтмол хяналт тавьж ажиллав.

Зайнаас хийх хяналтын хүрээнд активыг зохих журмын дагуу ангилаагүй, эрсдэлийн санг дутуу байгуулсан, нягтлан бодох бүртгэлийн холбогдох заалтуудыг биелүүлээгүй, тайлан мэдээг буруу гаргасан зэрэг зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт, шийтгэвэр тогтоох, холбогдох залруулгын гүйлгээг хийлгэх, зөрчлийг арилгуулах зэрэг арга хэмжээг авсан болно.

Банкинд тавих хяналт шалгалтыг хугацаанд нь, чанартай, тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх үүднээс гадаадын хөрөнгө оруулалттай банкуудын судалгаа, Банкны тухай хуулийн 38.2 дугаар заалтын биелэлт, өөрийн хөрөнгө болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн судалгааг улирал бүр, салбар нэгжийн өөрчлөлтийн судалгааг жилд нэг удаа гаргаж байна.

Шигтгээ 3: Банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Монголбанкны арга хэмжээ:

Монголбанкны зүгээс банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах зорилтыг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд сүүлийн жилүүдэд тогтмол тусган, хэрэгжүүлж ажиллаж байна. Ялангуяа банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд өөрийн хөрөнгийн зохистой харьцааг Базелийн цуврал стандартуудад заасан шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэв. Үүнд:

- Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудаас олгож буй дэд хөтөлбөрийн зээл, “Барилга, боловсруулах үйлдвэр, тээвэр ба агуулахын салбарын зээл” болон “Ипотекийн зээлээр баталгаажсан барьцаат үнэт цаас”-ны эрсдэлээр жигнэх хувийг харгалзан 0%, 70% болон 50% болгон тогтоосноор банкуудын эрсдэлээр жигнэсэн активын хэмжээг ялгавартай тооцох боломжтой болсон.
- Гадаадын банкны охин компани хэлбэрээр зохион байгуулагдсан банкны хувь нийлүүлсэн доод хөрөнгийн хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 65 тэрбум төгрөг болгон тогтоосон.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар:

- Сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5-аас дээш хувийг эзэлж байгаа банкийг “Банкны системд нөлөө бүхий банк” гэж тодорхойлсон.
- Системд нөлөө бүхий болон бусад банкуудад тавигдах өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуурыг тодорхой хугацааны давтамжтайгаар дараах байдлаар хангах үүрэг өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан.

Хүснэгт 7: Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур

Огноо	2012.6.30	2012.12.31	2013.6.30
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	7.0%	8.0%	9.0%
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	12.0%	12.0%	12.0%
Системд нөлөө бүхий банкны өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага	0.5%	1.0%	2.0%
Нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	12.5%	13.0%	14.0%

Эх сурвалж: Монголбанк

- Дотоодын банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 16 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн.
- Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар банкуудын хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг шинэчлэн тогтоож, харьцаанд агуулагдах түргэн борлогдох актив ба бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтцийг банкны санхүүгийн байдлыг бодитой харуулахуйц байдлаар өөрчлөн тогтоосон.
- Банкуудад Монголбанкнаас хийх хяналт шалгалтыг гүйцэтгэлд суурилсан аргачлаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан аргачлалд шилжүүлэх бодлогын үзэл баримтлал, зөвлөмж зааврыг боловсруулсан.
- Санхүүгийн байдлыг олон нийтэд ил тод мэдээлэх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв, олон улсын стандартад нийцсэн байдлаар тусгзуулах зорилгоор Банкуудын нягтлан бодох бүртгэлийн багц зөвлөмжийг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах ажлыг гүйцэтгэсэн.

Дээрхээс гадна Монголбанкнаас цаашид банкны системд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хямрал үссэн тохиолдолд түүний далайцыг бууруулах чадамж бүхий бодлогын шинэ хэрэгслүүдийг дэлхийн бусад улс орнуудын шилдэг туршлагыг судлан, өөрийн орны санхүүгийн системийн онцлог байдлыг харгалзан үзэж үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломж буй эсэхийг үнэлэх судалгааны ажлуудыг тогтмол хийж байна.

Хөрөнгийн зах зээл

Монголын хөрөнгийн бирж 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 254 удаагийн арилжаа явуулж, 134 компанийн 65.8 сая ширхэг хувьцааг 97.6 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар Засгийн газрын бондын 10 мянган ширхэг бондыг 1.01 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 98.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 47.1 тэрбум төгрөгөөр буюу 32.6%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8: Хөрөнгийн зах зээлийн арилжаа (тэрбум төгрөг)

	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2012	2013	Үнийн дүн	хувиар
Засгийн газрын бонд	0.000525	1.01	1.01	100.0
Хувьцаа	144.7	97.6	-47.1	-32.6
Компанийн бонд	0	0	0	0
Нийт	144.7	98.6	-46.1	-31.9

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 129.4 тэрбум төгрөгөөр буюу 7.2%-иар буурч 1670.5 тэрбум төгрөг болсон байгаа нь ДНБ-ий 9.4%-тай тэнцэж байна. Таван толгой, АПУ, Шивээ овоо, Багануур, Бэрх уул, Шарын гол зэрэг компаниуд нь зах зээлийн үнэлгээ өндөр компаниудад орж байгаа ба нийт зах зээлийн үнэлгээний 59%-ийг эзэлж байна.

2013 онд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 18,301.93 нэгж, доод үзүүлэлт 13,188.46 нэгж, дундаж үзүүлэлт 15,094.94 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1412.70 нэгжээр буюу 7.97%-иар буурч, 16,301.81 нэгж болсон байна. ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлж буй БидиСек (34%), Таван толгой (31%), Монголия девелопмент ресорсес (25%), Хөх ган (24%), Шивээ овоо (23%), Монголын цахилгаан холбоо (19%), Шарын гол (12%), Багануур (12%), Ремикон (11%) зэрэг ХК-иудын үнэт цаасны үнэ буурсан байна.

Тайлант онд 19 удаагийн багцын арилжаа явагдаж, 33.8 сая ширхэг хувьцааг 83.2 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 85%-ийг эзэлж байна. 2013 оны 10 дугаар сарын 21-нд “АПУ” ХК-ийн үнэт цаасны 14.7 сая ширхэг буюу 19.8%-ийг 47.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь түүхэн дэх хамгийн их үнийн дун бүхий арилжаа болжээ.

Зураг 24: Монголын хөрөнгийн бирж ийн ТОП-20 Индекс (тэрбум төгрөгөөр)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Хүснэгт 9: Идэвхтэй арилжигдсан үнэт цаас

	Тоо ширхэгээр (сая ширхэгээр)	Үнэт цаасны компани	Үнийн дүнгээр (тэрбум төгрөгөөр)
АПУ	15.150.762	АПУ	49.172.847.053
НАКО ТУЛИШ	12.152.641	БАГАНУУР	26.155.977.729
МОНИНЖБАР	10.816.995	МОНИНЖБАР	3.240.691.457
ХАЙ БИ ОЙЛ	5.538.337	НАКО ТУЛИШ	2.547.624.077
РЕМИКОН	5.131.385	ТАВАН ТОЛГОЙ	2.056.635.301

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Тайлант хугацаанд 134 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хаалтын ханштай харьцуулахад 84 компанийн үнэт цаасны ханш өсч, 43 компанийн үнэт цаасны ханш буурч, 7 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв. Хувьцааны арилжааны өдрийн дундаж үзүүлэлт өмнөх оноос 33.6%-иар буурч, өдөрт дунджаар 384.3 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

1.4 Улсын төсөв

Засгийн газрын санхүү

Монгол Улсын нийт тэнцвэржүүлсэн төсвийн орлого, тусlamжийн дун 2013 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5880.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дун 6178.0 тэрбум төгрөг болж, төсвийн алдагдал 297.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.7%-д хүрч Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангав.

Төсвийн орлого

Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусlamжийн дун 5880.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 7.9% буюу 503.4 тэрбум төгрөгөөр бага гарсан ч, өмнөх оноос 20.9% буюу 1017.6 тэрбум төгрөгөөр их байлаа.

Төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусlamжийн 99.9%-ийг бүрдүүлсэн урсгал орлого өмнөх оны мөн үеэс 21.8% буюу 1051 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Урсгал орлогын 86%-ийг бүрдүүлсэн татварын орлого өмнөх оны мөн үеэс 21% буюу 878 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 5057.3 тэрбум төгрөгт хүрсэн нь дотоодын бараа, үйлчилгээний татвар 16.8% буюу 276.2 тэрбум төгрөг, орлогын албан татвар 27.2% буюу 236.8 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн орлого 32.4% буюу 210.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин татварын бус орлого (урсгал орлогын 14%) өмнөх оны мөн үеэс 26.7% буюу 173 тэрбум төгрөгөөр өсч 821.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Төсвийн зарлага

Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дун төлөвлөсөн хэмжээнээс 622.9 тэрбум төгрөг буюу 9.2%-иар бага, өмнөх оны мөн үеэс 184.2 тэрбум төгрөг буюу 3.1%-иар өсч, 6178 тэрбум төгрөг байв.

Урсгал зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 73.8%) өмнөх оны мөн үеэс 155.2 тэрбум төгрөг буюу 3.5%-иар, эргэж төлөгдөх цэвэр зээл (нийт зарлага ба цэвэр зээлийн 2.8%) 107 тэрбум төгрөг буюу 166%-иар нэмэгдсэн бол хөрөнгийн зардал (нийт зарлага ба цэвэр зээлийн 23.4%) 78 тэрбум төгрөг буюу 5.1%-иар буурсан байна.

Урсгал зардлыг бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзвэл бараа, үйлчилгээний зардал (урсгал зардлын 52.5%) өмнөх оны мөн үеэс 341.2 тэрбум төгрөг буюу 16.6%, зээлийн үйлчилгээний төлбөр (урсгал зардлын 2.8%) 144.5 тэрбум төгрөг буюу 114.8%-иар нэмэгдсэн бол татаас ба шилжүүлэг (урсгал зардлын 41.1%) 330.5 тэрбум төгрөг буюу 14.8%-иар буурчээ. Татаас ба шилжүүлгийн зардал буурахад бусад урсгал шилжүүлгийн зардал 323 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

2013 онд 308.5 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл авч, өмнөх онуудад орсон 76.5 тэрбум төгрөгийн урьдчилгааг орлогод тооцож, Засгийн газрын 1,563 тэрбум төгрөгийн богино хугацаат бонд, 1,085.7 тэрбум төгрөгийн урт хугацаат бондыг тус тус арилжаалсан байна.

2.1 Мөнгөний бодлогын үндсэн зорилт, арга хэмжээ, үр дүн

Монголбанк 2013 онд төрийн мөнгөний бодлогын хүрээнд санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангах, дундаж давхаргын бодит орлогыг хамгаалж, хуримтлалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжих, ДНБ-ий тэнцвэртэй өсөлтөд дэмжлэг үзүүлэн, ажлын байрыг хамгаалах цогц бодлогыг хувийн хэвшлээр дамжуулан үе шаттай хэрэгжүүллээ.

Улаанбаатар хотын жилийн инфляцийн түвшин 2013 оны эхнээс 7 сарын турш буурч 7%-д хүрсэн боловч оны сүүлийн хагаст нэмэгдсээр 2013 оны эцэст 12.3% гарсан нь зорилтот түвшнээс 4.3 нэгж хувиар өндөр байв. Энэхүү инфляцийн дийлэнх хувийг махнаас бусад хүнсний бүтээгдэхүүний үнэ (2.92%), төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнэ (1.52%), мах, махан бүтээгдэхүүний үнэ (1.43%), бусад бараа үйлчилгээний үнэ (6.42%) бүрдүүлэв. Түүнчлэн 2013 онд эдийн засгийн гадаад орчин таагүй, төлбөрийн тэнцилийн дарамт өндөр, эдийн засаг дахь санхүүгийн эх үүсвэр 6.1 их наяд төгрөгөөр буурсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах шалтгаан болж, оны сүүлийн хагаст ханшийн сувгаар дамжин импортын инфляци өсөхөд нөлөөлөв. Тухайлбал, зөвхөн ханшийн шууд нөлөөгөөр Улаанбаатар хотын 2013 оны жилийн инфляцийн 3.7 нэгж хувийг импортын бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгожээ. Хэрэв 2013 онд Монголд Улсад орж ирсэн гадаад валютын урсгал нь гүйцэтгэлээс 2 тэрбум ам.доллараар их байсан бол инфляцийн 8 хувийн зорилтыг бурэн хангахын зэрэгцээ эдийн засгийн бодит өсөлтийг 13-14%-д байлгах боломжтой байсан юм.

Тайлант онд Монголбанк үнийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд шаардлагатай бодлогын арга хэмжээг авч ажиллалаа. Улсын төсвийн инфляцид үзүүлэх дарамт бага байсан, гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвржуулах хөтөлбөрүүдийн үр дүнд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл багасахаар хүлээгдэж байсан тул Монголбанк 2013 оны 1, 4, 6 дугаар саруудад мөнгөний бодлогын хүүг 0.75, 1.0, 1.0 нэгж хувиар тус тус бууруулж, 10.5%-д хүргэв. Бодлогын энэхүү арга хэмжээ нь мөнгө, зээлийн өсөлтийг тогтвржуулах, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд эерэгээр нөлөөллөө.

2013 оны туршид Монголбанк нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг бууруулах, зах зээлийн зарчимд суурилсан, байнгын тогтолцоог бий болгоор Засгийн газартай хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвржуулах дунд хугацааны хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн үр дүнд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт саарч, хүнсний бараа, үйлчилгээний инфляци 2012 онд 19.9% байсан бол 2013 онд 13.3% болж, 6.6 нэгж хувиар, махны үнийн өсөлт 2012 онд 44% байсан бол 2013 онд 10.5% болж 4.2 дахин буураад байна. Барилгын материалын дотоодын үйлдвэрлэл, орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжих арга хэмжээний үр дүнд 2013 онд ашиглалтанд орсон орон сууцны тоо өмнөх оноос 60 хувиар өссөн байна.

Эдийн засгийг тогтвржуулах, болзошгүй хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлсэн макро бодлогын хүрээнд Монголбанкаас дараах арга хэмжээг үе шаттайгаар, мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлттэй уялдаатайгаар хэрэгжүүлсэн билээ. Үүнд:

- Банкны салбарын чадавхийг сайжруулж хамгаалах, санхүүгийн тогтвортой байдал бий болох эрдэлээс сэргийлэх зорилгоор банкуудад 900 тэрбум төгрөгийн хадгаламжийг шаардлагатай цаг үед нь байршуулав. Банкууд уг эх үүсвэрийг эдийн засгийн бодит секторт ажлын байр, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зээл болгон гаргаснаар системд зээлийн тасалдал бий болох эрдэлээс сэргийлж, бизнесийн идэвхжилийг дэмжин, эдийн засгийн бодит өсөлтөд дэмжлэг болов.
- “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх” хөтөлбөрийг 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх, улмаар хэрэглээний эдийн засгийг хуримтлалд шилжүүлэх бодлогыг эхлүүлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах үндсэн нөхцөлийг бүрдүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд орон сууцны ипотекийн 8 хувийн санхүүжилтийг банкуудаар дамжуулан иргэдэл олгосноор орон сууцны ипотекийн зээлийн 2013 оны дундаж өсөлт 19% болсон нь 2011 оноос 12 нэгж хувиар, 2012 оноос 17 нэгж хувиар тус тус өндөр байна. Түүнчлэн 2013 оны 12 дугаар сард ипотекийн зээлийг багцлан худалдах, үнэт цаасжуулах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, ипотекийн зээлээр баталгаажсан анхны бонд гарч арилжаалагдсан нь хөрөнгийн зах дээр шинэ хэрэгсэл бий болж, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн хөгжилд чухал алхам боллоо.
- Дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүний коридорыг шинээр нэвтрүүлэв. Ингэснээр богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан, хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурах, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлөх зэрэг олон талын ач холбогдолтой болсон юм.
- Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх болон урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдэлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, ЗГҮЦ-ны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, ЗГҮЦ-ны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой байна.
- Монголбанкнаас 2013 оны 12 дугаар сард “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлав. Уг журмыг банкууд 2014 оны 1-р сарын 2-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандaa мөрдөх юм. Энэхүү журмыг мөрдөж эхэлснээр банкны бүтээгдхүүн, үйлчилгээний үнэ, шимтгэл, хураамжийн нөхцөлийн талаарх мэдээллийг ил тод болгож, харилцагчдад үнэн зөв мэдээлэл авах боломж олгох, банкны системийн хүүний өрсөлдөөнийг дэмжих замаар хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх, харилцагчийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой юм.

Дээрх бодлогын үр дүнд:

1. Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг эрс багасгаж, инфляцийг 2012 оны түвшнээс нь улсын хэмжээнд 1.5 нэгж хувиар, Улаанбаатар хотын хэмжээнд 1.9 нэгж хувиар тус тус бууруулан, макро тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хадгалсан.
2. Санхүүгийн тогтвортой байдлыг ханган, банкны салбарын чадавхийг сайжруулж хамгаалснаар

банкны салбарыг зээлийн тасалдлын болон системийн шинжтэй эрсдэлээс сэргийлж бэхжүүлсэн.

3. Эдийн засгийн бодит сектор, түүний идэвхжилийг дэмжсэнээр нийт M2 мөнгөний нийлүүлэлт огцом буурах, эдийн засаг хямрах, хөдөлмөрийн зах зээл 180 мянган ажлын байраа алдах эрсдэлээс сэргийлсэн нь ДНБ-ий бодит өсөлтийг 2013 онд 11.7%-тай гараад эерэгээр нөлөөлсөн.

Шигтгээ 4: Эдийн засгийг тогтвортжуулах цогц арга хэмжээ

2013 онд Монгол Улсын экспортын орлого 800 сая ам.доллараар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 2.4 тэрбум ам.доллараар тус тус буурч, Монгол Улс ирээдүйн экспортын орлогоо барьцаалж 2011-2012 онуудад 800 орчим сая ам.долларын богино хугацаатай зээл авсан байсан нь Монголын эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгалыг 4 тэрбум ам.доллараар буюу ДНБ-ий 35%-тай тэнцэх хэмжээгээр бууруулсан юм. Ийнхүү эдийн засаг дахь санхүүгийн эх үүсвэр үлээмж хэмжээгээр багасч, мөнгөний нийлүүлэлт дэх гадаад цэвэр актив 3.5 их наяд төгрөг буюу 78.5%-иар буурснаар банкны системд зээлийн тасалдал бий болох, зээл 3.9%-иар буурах, нийт M2 мөнгөний нийлүүлэлт 10.9%-иар буурах, санхүүгийн салбар болзошгүй хямралд өртөх, ДНБ-ий өсөлт серөг утгатай болох, улмаар эдийн засгийн гүнзгий хямралд нэрвэгдэх, хөдөлмөрийн зах зээлээс 180 гаруй мянган ажлын байр үгүй болох болзошгүй аюул нүүрлэхээр байсан юм.

Иймд Монголбанк санхүүгийн салбар, эдийн засгийг болзошгүй хямралаас сэргийлэх, эдийн засгийг бүхэлд нь тогтвортжуулах, бодит секторын идэвхжилийг дэмжих зорилтын хүрээнд дараах цогц арга хэмжээг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

Нэгд, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг арилгах зорилготой тусгайлсан хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж эхлэв. Энэхүү дунд хугацааны хөтөлбөр нь гол нэрийн бараа, бүтээгдэхүүн болох шатахуун, мах, гурил, зарим нэр төрлийн барилгын материалын жижиглэнгийн үнийг тогтвортжуулах, зах зээлийн зарчимд сууриссан агуулахын санхүүжилтийн механизмыг шинээр бий болгоход чиглэгдэж байна. Ийнхүү санхүүгийн зах зээлд бараа, бүтээгдэхүүний агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг цоо шинээр нэвтрүүлснээр дунд хугацаанд бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн байнгын тогтолцоог бүрдүүлэх боломжтой болов.

Хоёрт, Монголбанкаас эдийн засгийн бодит секторт бүтээмж бий болгох мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллав. Банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, зээлийн тасалдал үүсэхээс сэргийлэх, эдийн засгийн идэвхжил, бодит секторыг дэмжихийн тулд Монголбанк бодлогын хүүг нийт 2.75 нэгж хувиар бууруулахын зэрэгцээ 900 тэрбум төгрөг буюу M2 мөнгөний 15 хувьтай тэнцэх хэмжээний хадгаламжийг банкуудад байршуулснаар 2012 оны сүүлээс үүсч болзошгүй байсан зээлийн тасалдлыг сэргийлж, эдийн засаг, зах зээлийн итгэлийг сэргээн, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангасан юм. Түүнчлэн банкны системийн хяналт шалгалтад анхаарч, зохицой харьцааны дүрэм журмыг сайжруулан, санхүүгийн салбарт итгэх итгэлийг бэхжүүлж ажиллав.

Гуравт, Монголбанк хөдөө аж ахуй, орон сууцны барилга зэрэг эдийн засгийн тодорхой салбаруудыг дэмжих замаар эдийн засгийн тэнцвэртгий хөгжилд дэмжлэг үзүүлэх, ажлын байрыг хамгаалах, орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх замаар дундаж давхаргын хуримтлалыг туштай нэмэгдүүлэх, дотоодын зээл, хуримтлал, хөрөнгө оруулалтыг сайжруулахад анхаарч ажиллав.

2013 онд ДНБ 11.7%-иар өсөхөд Монголбанкнаас хэрэгжүүлсэн мөнгөний зөвлөн бодлого шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Энэ нь нэг талаас мөчлөг сөрсөн, идэвхтэй, өрхийн зардлын бүтцийг ошилсон, эдийн засгийн бодит секторт чиглэсэн мөнгөний бодлого, сахилга баттай санхүүгийн орчин бүхий эдийн засагтай болж байгаагийн, нөгөө талаас эдийн засгийн өсөлтөд хувийн хэвшлийн оруулж буй хувь нэмэр, оролцоо өсөн нэмэгдэж байгаагийн тод илрэл билээ.

Дөрөвт, Монголбанк ханшийн уян хатан тогтолцоог хэрэгжүүлсээр ирлээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэйгээр хэлбэлзэж байна. Гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурч, эдийн засагт 6.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад валютын эх үүсвэр дутагдсаны улмаас төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 2013 онд 19 хувиар суларсан байна. Ийнхүү төгрөгийн нэрлэсэн ханш суларч, бодит үйлчилж буй ханш нь урт хугацааны тэнцвэрт түвшинд ойртож, төгрөг хэт үнэлэгдэх эрсдэл үгүй болсон нь богино хугацаанд тодорхой зардлыг дагуулсан хэдий ч, дунд, урт хугацаанд гадаад худалдааг тэнцвэржүүлэх, экспортыг хөхиулэн дэмжих, эдийн засагт зайлшгүй шаардлагатай тохигоог хийлгэх, улмаар дотоодын үйлдвэрлэл, бүтээмж, үндэсний хуримтлал, хөрөнгө оруулалтад суурилсан эдийн засгийн зохистой бүтэцтэй болоход чухал үүрэг гүйцэтгэж байна.


Шигтгээ 5: Мөнгөний бодлогын арга хэрэгслүүд ба хүүний коридор

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс 2013 оны 2 дугаар сард 4 нэгж хувийн өргөнтэй хүүний коридорыг нэвтрүүлэх шийдвэр гаргасан билээ. Хүүний коридорын дээд, доод хязгаар нь Монголбанкны бодлогын хүүнээс шууд хамаарч тогтоно. Тухайлбал, хүүний коридорын дээд хязгаарыг овернайт репо санхүүжилтийн хүү, харин доод хязгаарыг овернайт хадгаламжийн хүү тус тус тодорхойлно (Зураг 25).

Монголбанкны овернайт репо санхүүжилт гэдэг нь заавал байлагах нөөц (ЗБН)-ийн шаардлага хангахгүй байгаа банкинд клирингийн гүйлгээ хаахаас дараагийн ажлын өдрийн клирингийн гүйлгээ нээх хүртэл хугацаагаар олгож байгаа зээл бөгөөд түүний хүү нь бодлогын хүү (10.5%) дээр нэмэх нь 2 нэгж хувь буюу 12.5%-тай тэнцүү байна. Харин ажлын өдрийн төгсгөлд банкууд илүүдэл нөөцөө Төв банкны овернайт хадгаламжинд байршуулж, өгөөж олох боломжтой ба түүний хүү нь бодлогын хүүнээс хасах нь 2 нэгж хувь буюу 8.5%-тай тэнцүү байна.

Банкуудын өөр хоорондоо зээл өгч, авч байгаа хүүг банк хоорондын зах (БХЗ)-ын хүү гэнэ. Энэхүү БХЗ-ын хүү нь Монголбанкны бодлогын хүүг дагах ба ингэхдээ зөвхөн хүүний коридор дотор хэлбэлзэнэ. БХЗ дээр зээл хайж буй банк хүссэн үедээ овернайт репо санхүүжилтийг Төв банкнаас 12.5%-иар авах боломжтой бөгөөд үүнээс илүү хувиар авахгүй. Нөгөө талаар зээл олгож буй банк илүүдэл нөөцөө Төв банкинд 8.5%-ийн овернайт хадгаламжид байршуулах боломжтой тул хэлцэл үүнээс доогуур хувиар хийгдэхгүй юм.

Зураг 25: Монголбанкны хүүний коридор, 2013 оны 3-12 сарын байдлаар




2.2 Санхүүгийн тогтвортой байдал

Санхүүгийн салбарын үндсэн үүрэг нь санхүүгийн хөрөнгийг бий болгож, түүнийг зах зээлд үр ашигтай хуваарилан, оновчтой хөрөнгө оруулалтад байршуулахад оршдог. Санхүүгийн салбарын өргөн цар хүрээ, бусад салбартай нягт уялдаатай байдал зэргээс шалтгаалан санхүүгийн тогтвортой байдлыг тодорхойлох, хэмжих нь төвөгтэй байdag бөгөөд өнөө хэр энэ талаар нэгдсэн ойлголтод хүрээгүй байгаа юм. Гэсэн хэдий ч, санхүүгийн тогтвортой байдалд өгсөн тодорхойлолтуудын нийтлэг утга нь аливаа гадаад орчны серөг нөлөөлөл, эрсдэлтэй үед санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үр ашигтай, тасралтгүй явагдаж байх чадвар гэдэгт чиглэж байна.

Монгол Улсын санхүүгийн системийн 96 хувийг банкны салбар дангаар бүрдүүлж буй хэдий ч, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад дан ганц мөнгөний бодлого, банкны салбарыг тойрсон асуудлаар хандах бус санхүүгийн дэд салбарууд дахь тэнцвэртэй хөгжил, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн үр ашигтай, харилцан уялдаатай макро болон микро түвшний бодлогууд, нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилттой уялдсан санхүүгийн институци, дэд бүтцийн оновчтой бөгөөд шат дараалсан шинэчлэл, олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголт, төлөвшлийг хамарсан санхүүгийн тогтвортой байдлын ерөнхий хүрээ байдлаар авч узэх нь зүйн хэрэг юм. Дэлхий нийтэд ч энэ хандлага хүрээгээ тэлж, багагүй өөрчлөлтийг бий болгож байна.


Зураг 26: Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) ба хөрөнгөөр тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, СЗХ.

Тэмдэглэл: Үнэт цаасны оролцогч компаниудын 2013 оны 3 дугаар улирлын тайлан гараагүй байгаа тул энэ үеийн активыг 2012 оны 4 дүгээр улирлын активаар төлөөлүүлэн тооцсон.

Зураг 27: Ашиг (тэрбум төгрөг) ба ашгаар тооцсон салбарт эзлэх хувь хэмжээ



Эх сурвалж: Монголбанк, СЗХ.

Тэмдэглэл: Үнэт цаасны оролцогч компаниудын 2013 оны 3 дугаар улирлын тайлан гараагүй байгаа тул энэ үеийн ашгийг 2012 оны 3 дугаар улирлын ашгаар төлөөлүүлсэн тооцсон.

Монголбанкны санхүүгийн систем дэх үндсэн үүрэг нь санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах явдал бөгөөд манай улсын хувьд банкны салбарын тогтвортой байдал нь санхүүгийн тогтвортой байдлын гол цөм юм. Энэхүү үүргийг хэрэгжүүлэх хүрээнд банкны үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж байна. Монголбанк санхүүгийн системийн үр ашигтай, тогтвортой байдлыг дэмжих, банкны үйл ажиллагааны доголдлоос санхүүгийн системд учруулж болзошгүй хор хохирлоос зайлсхийх зорилгоор банкуудад хяналт шалгалтыг тогтмол хийсээр ирсэн. Мөн 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль”-ийг баталснаар хадгаламжийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, улмаар банкны салбарын тогтвортой байдлыг хангахад чухал алхам болов. Түүнчлэн, “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль” 2013 оноос бүрэн агуулгаараа хэрэгжиж эхэлсэнтэй уялдан мөчлөг дагасан төсвийн санхүүгийн системд үзүүлэх сөрөг нөлөө буурч, санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлөх хандлагатай байна.

Санхүүгийн систем банкны салбарт суурилж буй хэдий ч, иргэдийн багагүй хэсэг нь банкны бус санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлж, тэдгээр байгууллагын үйл ажиллагаа ойрын жилүүдэд идэвхжих хандлагатай байна. Тухайлбал, 2013 оны эцсийн байдааар нийт бүртгэлтэй 263 банк бус санхүүгийн байгууллага, 141 хадгаламж зээлийн хоршоо, 87 брокер дилерийн байгууллага, 17 даатгалын компани, 323 хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж, үйл ажиллагааных нь цар хүрээ тэлсээр байна. Санхүүгийн салбарыг тэнцвэртэй хөгжүүлэх зорилгоор холбогдох хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр зохих арга

хэмжээг, шат дараатайгаар авч хэрэгжүүлсээр байна. Тухайлбал, 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийг баталж, улмаар дагалдах хууль, журмууд ар араасаа батлагдахаар төлөвлөгджэй байгааг дурдаж болно.

Төвбанкны тухай хууль болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл)-ийн ажиллах дүрэмд заасны дагуу 2013 онд Зөвлөл 4 удаа хуралдаж, нийтдээ 13 асуудал хэлэлцлээ. Тухайлбал, Зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд санал боловсруулах, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлж, 5 хүний орон тоотой ажиллуулахаар болсон. Мөн 2013 оны 9 дүгээр сарын 25, 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 баримлах үндсэн чиглэлийн төсөл, Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газраас хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих хөтөлбөр”, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөл, 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтвржуулах, эдийн засгийн идэвхжилийг дэмжих бодлогын санал”, “Санхүүгийн зохицуулах хороо МИК Актив нэг ХХК-ийн гаргах хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай”, “Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны 2013 оны үйл ажиллагааны тайлан”, “Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2014 оны ээлжит хуралдааны товыг тогтоох тухай” зэрэг асуудлуудыг хэлэлцэж, Зөвлөлийн гишүүд холбогдох газруудад санал, зөвлөмж хүргэж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажиллав.

Олон нийтийн санхүүгийн салбарын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, санхүүгийн салбарын талаарх бодит мэдээллийг нийтэд тэгш, цаг тухайд нь хүргэж, бодит хүлээлтийг төлөвшүүлэх нь санхүүгийн салбарт итгэлийг нэмэгдүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний хоёр дугаарыг бэлтгэж, 2013 оны 7, 12 саруудад анх удаа олон нийтийн хүртээл болгоод байна.

Сангийн яаманд Дэлхийн банкнаас хэрэгжүүлж байгаа MSTAP төслийн хүрээнд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, түүний ажлын албаны чадавхийг сайжруулах чиглэлээр гадаадын ба дотоодын зөвлөхийг тус зөвлөлийн Ажлын албатай хамтран ажиллуулав. Энэ хүрээнд санхүүгийн тогтвортой байдлын асуудал эрхэлсэн институцийн хэм хэмжээ, бусад орны сайн туршилага, санхүүгийн тогтвортой байдалтай холбоотой Монгол Улсын хууль, эрх зүйн орчинд өгөх үнэлгээ дүгнэлт, бодлогын болон техникийн түвшинд учирч буй асуудлууд зэрэг өргөн хүрээг хамарсан эхний шатны тайлан гарч, Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороог хамарсан хоёр удаагийн семинарыг зохион байгууллаа.

2.3 Валютын бодлого

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш уян хатан тогтох байх бодлого нь макро эдийн засгийн ерөнхий тэнцвэрийг зах зээлийн зарчмаар хангах, гадаад зах зээлийн сөрөг өөрчлөлтийн нөлөөллийг валютын ханшаар дамжуулан шингээх замаар эдийн засгийн дунд ба урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжих, санхүүгийн болон эдийн засгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх суурь нөхцөл болдог билээ. Ийм учраас Төрөөс мөнгөний бодлогын талаар суулийн жилүүдэд баримталсан үндсэн чиглэлд “Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох байх”-аар заасан бөгөөд Монголбанк уг бодлого, зарчмыг тууштай хэрэгжүүлсээр ирлээ.


2013 онд Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдал 3.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны түвшинд байсан хэдий ч, хөрөнгө санхүүгийн дансны ашиг 1.5 тэрбум ам.долларт хүрч өмнөх оноос 3.3 дахин буурсан, зөвхөн 2013 онд Монголын эдийн засгаас 6.1 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний гадаад валютын эх үүсвэр дутагдсан нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд үйлчилсэн суурь нөхцөл нь болсон юм.

Монголбанк валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гаригт тогтмол зохион байгуулж ирлээ. Валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны, түр зуурын шинжтэй зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, захад оролцогчдын хүлээлтийг тогтвортжуулах зорилгоор Монголбанк валютын дуудлага худалдааг зохион байгуулж, шаардлагатай зохицуулалтыг тухай бүр хийсний үр дүнд гадаад зах зээлийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг зөөлрүүлж, гадаад худалдаа, эдийн засаг дахь зайлшгүй шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлэн, валютын ханшийн хямралын эрдэлээс сэргийлэв. Мөн шаардлагатай үед ам.доллар, юанийн спот захад оролцох нөхцөлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ төгрөг-ам.долларын болон төгрөг-юанийн спот, форвард хэлцлүүдийг банкуудтай хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг бууруулах, ханшийн эрдэлээс хамгаалах зэрэг ач холбогдолтой болж байна.

Зураг 28: Төлбөрийн тэнцэл ба төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Зураг 29: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж



Төгрөгийн амдоллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар оны эхнээс 19%-иар суларч 1659.34 төгрөгт хүрсэн бөгөөд тайлант хугацаанд ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл 0.25%, чангасан болон суларсан дундаж хэмжээ харгалзан 0.24%, 0.26% байв. 2013 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл жилийн нийт хоногийн 60 хувьд нь 0.2%-иас хэтрээгүй байна. Нэгээс дээш хувийн ханшийн хэлбэлзэл бүтэн жилийн туршид ердөө 5 өдөрт л ажиглагджээ.

2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн (ГВУН) удирдлагыг хэрэгжүүлэхдээ “Төв банк (Монголбанк)-ны тухай” хуулийн 5, 21 дүгээр зүйлд заасны дагуу нөөцийн гадаад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, найдвартай байдлыг хангаж байна. Зөвхөн дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмыг баримтлан ажилладаг билээ.

2013 онд Монголбанк хүлээн зөвшөөрөгдхүйц эрсдэлийн түвшинд гадаад валютын улсын нөөцийн бүтцийг баталж, түүний хүрээнд гадаад валютын улсын нөөцийн активын бүтэц, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хөрөнгө оруулалтын боломжит хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажилласан. Мөн гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтуудын зах зээлийн үнэлгээг тогтмол хийж, зах зээлийн эрсдэлүүдийг тооцох, зээлийн эрсдэл болон холбогдох лимитүүдэд хяналт тавих, дэлхийн зах зээлийн нөхцөл байдлыг тогтмол ажиглан судалж, холбогдох мэдээ тайлан бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2013 онд Монголбанкнаас ГВУН-ийг зээлийн эрсдэл харьцангуй бага, дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц гэх мэт орнуудын төв банкууд, Олон улсын төлбөр тооцооны банк (BIS), зээлжих зэрэглэл өндөртэй банкуудад харилцах, хадгаламж хэлбэрээр байршууллаа. Үнээс гадна дэлхийн эдийн засаг тайлант онд 2012 онтой харьцуулахад сэргэсэн, АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ) мөнгөний зөвлөн бодлогоо хумьж эхлэх хүлээлттэй байсан тул дэлхийн эдийн засагт тэргүүлэгч орнуудын Засгийн газрын богино, урт хугацаат үнэт цаас зэрэг хэрэгсэлд хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацааг дээд тал нь 3 жил байхаар тооцоолж хөрөнгө оруулав.

Евро бүсийн эдийн засгийн удашрал нь хөгжиж буй орнуудын төлбөрийн тэнцэлд сергөөр нөлөөлж, дэлхийн санхүүгийн салбарын эрсдэлийн ерөнхий түвшинг нэмэгдүүлсэн тул гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад зэрэглэл харгалзахгүйгээр баталгаагүй хөрөнгө байршуулаагүй болно.

ГВУН-ийн удирдлагыг сайжруулах зорилгоор бусад орны төв банкууд, Дэлхийн банктай хамтран ажилласны зэрэгцээ АНУ, Япон улсын засгийн газрын үнэт цаасны хөрөнгө оруулалтыг найдвартай, үр өгөөжтэй гүйцэтгэх, хөрөнгийн зах зээлийн судалгааг сайжруулах үүднээс гадаадын тэргүүлэгч банкуутдай туршлага солилцсон.

ГВУН-ийн амдолларын багцыг 2013 оноос Дэлхийн банкны зөвлөгөө, бусад төв банкуудын сайн туршлагын дагуу богино хугацаат багц, хөрөнгө оруулалтын багц хэмээн ангилик, богино хугацаат багцыг 0-1 жилийн хугацаатай, хөрөнгө оруулалтын багцыг 0-3 жилийн хугацаатай индексийн жишиг хэмжүүртэй харьцуулан удирдах шийдвэр гаргасан нь нөөцийн удирдлагын хүрээнд гарсан голлох өөрчлөлт байлаа. Мөн зэрэглэл өндөртэй АНУ-ын Засгийн газрын 0-3 жилийн хугацаатай үнэт цаасны индексийг хуулбарлан, хөрөнгө оруулалтын багцыг удирдах аргаар хүүгийн эрсдэлийг бууруулж ажиллав.


2013 онд өндөр хөгжилтэй орнуудын төв банкууд бодлогын хүүгээ өмнөх оны түвшинд буюу бага хувьд барьж байсан бол АНУ-ын ХНБ-наас үнэт цаас худалдан авах хөтөлбөрөө хумих тухай олон нийтэд мэдэгдэж, улмаар 12 дугаар сараас үнэт цаас худалдан авалтаа бууруулсан нь АНУ-ын урт хугацаат үнэт цаасны өгөөжийн муруй дээшлэх, мөнгөжсөн алтны үнийг нийт 28%-иар бууруулахад голлон нөлөөлсөн байна.

Түүнчлэн, шинээр сонгогдсон Засгийн газрын тэргүүн Шинзо Абэгийн удирдлага дор Япон улс 2013 оноос шинэчлэлийн “Абеномикс” хэмээх гурван шатлалт мөнгөний эрчимтэй тэлэх бодлогыг баримталж эхэлснээр иенийн ханш ам.долларын эсрэг 22%-иар суларсан билээ. Мөн Евро бүсийн эдийн засгийн таатай бус байдал хэвээр үргэлжилж, эдийн засгийн өсөлт зорилтот хэмжээнд хүрээгүй нь Европын төв банкнаас бодлогын хүүг түүхэн доод түвшинд хүргэлжилж, улмаар еврогийн мөнгөний зах зээл дээрх богино хугацааны хүү буурахад нөлөөлснөөр тайлант онд хүүгийн түвшин сөрөг хэвээр байлаа. Эдгээр хүчин зүйлүүд нь ГВУН-ийн өгөөжийн түвшинг бууруулахад голчлон нөлөөлсөн.

ГВУН 2013 оны байдлаар 2,248 сая ам.долларт хүрч оны эхнээс 45.5%-иар буюу 1,887.8 сая ам.доллараар буурсан байна. Гэсэн хэдий ч энэ нь олон улсын жишиг доод түвшин болох 12 долоо хоногийн импортын хэрэгцээг дараах байдлаар бүрэн хангасан үзүүлэлт юм (Зураг 30).

- 2013 оны 12 дугаар сарын валютын шууд төлбөртэй импортын дүнгээр авч үзвэл, 4.3 сарын буюу 17.3 долоо хоногийн;
- Монгол Улсын валютын шууд төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд, 4.3 сарын буюу 17.3 долоо хоногийн;
- 2014 оны импортын төсөөллөөр тооцвол, 4.4 сарын буюу 17.7 долоо хоногийн импортын төлбөрийг гүйцэтгэх хэмжээнд байна.

Зураг 30: Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк

2013 онд дотоодын аж ахуйн нэгж, иргэдийн алт тушаалт нэмэгдэж, Монголбанкинд нийт 6 тонн алт тушаасан. Монголбанк он дамжуулан болон тайлант онд худалдан авсан нийт 7.4 тонн алтыг цэвэршүүлснээр ГВУН-ийг 328.4 сая ам.доллараар нэмэгдүүлэв.

ГВУН-ийн удирдлагын хүрээнд Монголбанк харилцах, хадгаламжийн хүүгийн орлого, богино хугацаат үнэт цаас, гадаад валютын арилжааны орлогоос 16.7 сая ам.долларын ашиг олсон бол мөнгөжсөн алт болон бусад валютуудын дахин үнэлгээний бодит алдагдал 51.1 сая ам.долларт хүрч, ГВУН-ийг нийт 34.3 сая ам.доллараар хорогдуулсан байна.

2.5 Монгол Улсын төлбөр тооцооны систем

Төв банк нь Монгол Улсын санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих, төлбөр тооцооны системийн үр ашигтай, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, бэлэн бус төлбөр тооцоог хөгжүүлэх бодлогыг баримтлан ажилладаг.

Төлбөрийн системийн хууль эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор их, бага дүнтэй төлбөр тооцооны журам, төлбөрийн картын журамд тус тус шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулж, нийт оролцогчдод мөрдүүлэн ажиллаж байна.

Бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг хөгжүүлэх, эрх зүйн орчинг төлөвшүүлэх, төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Хувьсан шинэчлэгдэх дэвшилтэй мобайл банкны үйлчилгээ” төслийг амжилттай хэрэгжүүлж, төслийн үр дүн болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар Төлбөр тооцооны үндэсний зөвлөл (PTY3)-ийн 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэж тодорхойлсон.

Монгол Улсын төлбөрийн системийн дэд бүтцийг шинэчлэх, эрх зүйн орчинг сайжруулах, системүүдийн нэгдмэл байдлыг хангасан стандартыг бий болгох, бэлэн бус төлбөр тооцоог дэмжих үндсэн зорилготойгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Азийн хөгжлийн банк хамтран “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монголбанкны зүгээс төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, үр ашигийг нэмэгдүүлэх, харилцагчдын эрх ашигийг хамгаалах зорилтын хүрээнд техник технологийн хөгжилтэй зэрэгцэн төлбөр тооцоонд шинээр нэвтрэч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан, системийн оролцогчдод холбогдох зөвшөөрлийг олгож, хяналт тавин ажиллалаа.

Хүснэгт 10: Банк хоорондын 2010-2013 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)

	2010		2011		2012		2013	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
I улирал	693.8	2.2	798.0	3.7	914.9	5.7	3846.3	9.0
өсөлт (%)	38.2	25.8	15.1	68.2	14.6	53.8	320.4	57.9
II улирал	908.9	3.0	1077.5	5.4	1249.4	7.5	4 664.1	13.3
өсөлт (%)	27.0	69.6	18.5	80.0	16.0	38.5	273.3	77.3
III улирал	801.9	3.4	903.6	6.0	1018.5	8.4	4 524.5	16.1
өсөлт (%)	28.1	74.2	12.7	73.5	12.7	40.2	344.2	91.7


IV улирал	983.1	4.7	1139.3	8.3	3954.9	9.0	4 780.1	17.5
Өсөлт (%)	22.8	86.2	15.9	76.6	247.1	8.4	20.9	94.4
Нийт	3387.7	13.2	3919.3	23.4	7137.8	30.6	17 815.0	55.9
Өсөлт (%)	28.1	66.5	15.7	77.3	82.1	30.7	149.6	82.7

Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын гүйлгээний тоо, дүнг өмнөх оныхтой харьцуулахад 2010 онд гүйлгээний тоо 28.1%-иар, гүйлгээний дүн 66.5%-иар өсч, харин 2011 онд 15.7% ба 77.3%, 2012 онд 82.1% ба 30.7%, 2013 онд 149.6% ба 82.7%-иар тус тус нэмэгдсэн байна.

Гүйлгээний тоо, дүн 2010 оноос хойш тогтмол өссөөр 2013 онд 55.9 их наяд төгрөгийн 17.8 сая ширхэг гүйлгээ боловсруулагдсан үзүүлэлттэй байна.

Зураг 31: Банк хоорондын 2010-2013 оны гүйлгээний тоо, дүн



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн карт

Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төв нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Хүний хөгжил сан (XXC)-гаас хүүхдэд олгож буй мөнгө, малчдын ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан урамшууллыг банкууд дахь тухайн харилцагчийн дансанд байршуулах ажиллагааг гүйцэтгэж байна. Түүнчлэн XXC-гаас хүүхдэд олгож буй мөнгийг иргэд хүүхдийн “Ирээдүй” ৎ картаар авах боломжтой юм.

Хүснэгт 11: Төлбөрийн картын хэрэглээ

Картын хэрэглэгчийн тоо	2011	2012	2013	Орон нутаг	Өөрчлөлт (%)
Карт эзэмшигч	2 169 838	2 855 378	3 456 440	1 098 072	21.1
Карт идэвхтэй ашиглагч	440 177	1 123 041	1 343 284	306 779	19.6
Төхөөрөмжийн тоо	2011	2012	2013	Орон нутаг	Өөрчлөлт (%)
ПОС	5624	7210	9535	2011	32.2
ПОБ	2354	2384	2765	1696	16.0
АТМ	634	915	1032	244	12.8
Бусад	373	316	314	-	-

Гүйлгээний тоо, дүн	2011	2012	2013	Орон нутаг	<i>Өөрчлөлт (%)</i>
ПОС Тоо. сая ширхэг	5.9	10.3	13.6	1.2	32.0
Дүн. тэрбум төгрөг	448.8	735.1	738.7	24.9	0.5
ПОБ Тоо. сая ширхэг	2.2	1.7	1.4	0.4	-17.6
Дүн. тэрбум төгрөг	515.5	557.0	422.5	67.8	-24.1
АТМ Тоо. сая ширхэг	36.7	57.4	57.0	10.8	-0.7
Дүн. тэрбум төгрөг	2603.8	3993.2	4647.5	854.7	16.4
Нийт Тоо. сая ширхэг	44.8	69.5	72.0	12.4	3.6
Дүн. тэрбум төгрөг	3568.1	5305.3	5808.7	947.4	9.5

Эх сурвалж: Монголбанк

Картын хэрэглээний үзүүлэлтийг авч үзвэл ПОБ төхөөрөмжөөр буюу банкин дээр очиж картаар хийсэн гүйлгээний тоо, дүнгээс бусад үзүүлэлтүүд жил тутамд өссөн байна. Энэ нь иргэдийн дунд бэлэн бус төлбөрийн хэрэгслийн хэрэглээ улам нэмэгдэж байгаатай холбоотой.

2.6 Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл

Тайлант онд УИХ-аас Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг тус тус баталж, эдгээр хууль батлагдсантай холбогдуулан Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль 2013 оны 1 дүгээр сарын 10-ний өдөр батлагдав. Энэ хуульд банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоож, хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан. Банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгайлсан чиг үүрэг бүхий хуулийн этгээд (Хадгаламжийн даатгалын корпораци)-ийг үүсгэн байгуулж, банкаас харилцах болон хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгийг Хадгаламжийн даатгалын корпорацид даатгуулах, даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр төлөхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулнаараа уг хууль ач холбогдолтой юм.

Энэ хууль батлагдсанаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчийн тухайн банкин дахь төгрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлөхдөө тухайн банкны хадгаламж эзэмшигч бүрийг хамруулах, Банкны тухай хуулийн дагуу банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламжийн даатгалд хамрагдах зэргийг зохицуулахаар тусгажээ.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан)-д үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа (үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах, арилжих, бүртгэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, хадгалах, бусад зохицуулалттай үйл ажиллагаа)-г зохицуулах, хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай

холбогдсон харилцааг зохицуулжээ. Бараа, түүхий эдэд суурилсан санхүүгийн үүсмэл хэрэгсэл гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцаа, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар мөн зохицуулсан. Энэ хууль нь үнэт цаасны зах зээлийн эрсдэлийг бууруулах, шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зэрэг ач холбогдолтой.

3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдөр батлагдсан. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2006)-ийг мөрдсөн хугацаанд Монгол Улсад банк, санхүүгийн тогтолцоо хөгжиж, гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр түүний тогтвортой байдлыг хангах, хууль бус хөрөнгийг илрүүлэх, таслан зогсоох, битүүмжлэх, хураах талаарх эрх зүйн орчинг илүү боловсронгуй болгох зүй ёсны шаардлага урган гарсан. НҮБ-ын холбогдох конвенц, Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллагын зөвлөмжид манай эрх зүйн орчин нийцэхгүй байснаас олон улсын хяналт, шаардлагад өртөх үндсэн нөхцөл болж байв. Иймд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг энэ шаардлагад нийцүүлэн шинэчилснээр банк, санхүүгийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг хаах эрх зүйн үндэс бүрдэв.
4. Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Энэ хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, татварын орчинг тогтвржуулах, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох зохицуулалт оржээ. Ингэснээр Монгол Улсад хөрөнгө оруулалтын урт хугацааны бодлого хэрэгжүүлэх нөхцөл болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын тогтвортой, ойлгомжтой, тодорхой орчинг бүрдүүлэв.
5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан. Энэ хуулиар хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, сангийн үйл ажиллагаа эрхлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, сангийн үйл ажиллагааг төрийн эрх бүхий байгууллагаас зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг хуульчилсан.


3.1 Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)

ТБҮЦ нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын богино хугацаат хүүг удирдах, мөнгөний бодлогын төлвийг илэрхийлэх гол хэрэгсэл бөгөөд дараах хоёр төрлийн ТБҮЦ-ыг банкуудад арилжаалж байна. Үүнд:

- 7 хоногийн хугацаатай ТБҮЦ³
- 4 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ⁴

ТБҮЦ-ны хүүг зах зээлийн зарчимд илүү нийцтэй болгох, төгрөг болон валютын захын өгөөжийн тэнцвэр тогтох боломжийг бүрдүүлэх зорилгоор 2013 оны 3 дугаар сард долоо хоногтой ТБҮЦ-ыг 7 хоногт гурван удаа буюу Даваа, Лхагва, Баасан гаригуудад арилжаалж эхлээд байна. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ТБҮЦ-ний нийт үлдэгдэл 2 их наяд байсны 92%-ийг 7 хоногтой, 8%-ийг дөрвөн 7 хоногтой ТБҮЦ-үүдээ эзэлж байгаа бөгөөд энэхүү үзүүлэлт нь 2012 оны нийт ТБҮЦ-ны үлдэгдлээс 62%, 2011 оноос 56%-иар тус тус өссөн үзүүлэлт юм (Зураг 32).

Зураг 32: Банкуудын эзэмшиж буй ТБҮЦ-ны үлдэгдэл (Хугацаа, сар бүрээр)



Эх сурвалж: Монголбанк

3.2 Төв банкны санхүүжилт

Монголбанкаас банк хоорондын захын богино хугацаат хүүгийн түвшин, түүний хэлбэлзлийг хянах чадварыг нэмэгдүүлэх, хүүний шилжих механизмын эхний хэсгийн нөлөөг сайжруулах зорилгоор 2013 оны 3 дугаар сараас эхлэн “Хүүний коридор”-ыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь

³ Дээд хязгаартай, хэмжээ хязгаарлахгүй зарчмаар 7 хоногийн Даваа, Лхагва, Баасан гаригуудад тогтмол арилжаалж байна. Монголбанк БХЗ-д тодорхой хэмжээний нөөц үлдээхийг зоривол арилжааны хэмжээг таслах бөгөөд бусад тохиолдолд банкуудын ирүүлсэн саналаар арилжааны хэмжээг тогтоодог.


⁴ Хүүний дээд хязгаар (репо санхүүжилтийн хүү буюу бодлогын хүүн дээр нэмэх нь 0.5 нэгж хувь)-тай, урьдчилж зарласан хэмжээн дээр банкууд хүүгээр өрсөлдөх зарчмаар 4 долоо хоногийн давтамжтайгаар тогтмол арилжаадаг.

мөнгөний бодлогын хэрэгжилтийг боловсронгуй болгох чухал алхмын нэг болсон билээ. Хүүний коридорыг нэвтрүүлснээр Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдэд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

1. “Төв банкны Овернайт хадгаламж”-ийн байнгын хэрэгслийг шинээр нэвтрүүлж, түүний хүүг коридорны доод хязгаараар тогтоосон (Бодлогын хүү+2 нэгж хувь).
2. Өмнө нь ашиглаж байсан “Төв банкны Овернайт зээл”, “Төв банкны репо хэлцэл”-ийг зогсоож, тэдгээрийн оронд “Овернайт репо хэлцэл”-ийг нэвтрүүлсэн бөгөөд түүний хүүг коридорын дээд хязгаараар (Бодлогын хүү+2 нэгж хувь) тогтоосон.
3. Төв банкны санаачлагаар хийж буй урвуу репо санхүүжилтийг 7 хоногийн хугацаатай болгон өөрчилж, түүний хүүг Бодлогын хүү+0.5 нэгж хувиар тогтоож, арилжааг хэмжээ хязгаарлахгүй хэлбэрээр зохион байгуулахаар тогтсон.

2013 онд Монголбанк өөрийн санхүүжилтийн хэрэгслүүдээр дамжуулан банкуудад нийт 24.9 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд үүний 90% нь овернайт хадгаламж, 9% нь овернайт репо, репо санхүүжилт, үлдсэн 1% нь өдрийн зээл, овернайт зээл⁵ байв.


Зураг 33: Төв банкны санхүүжилт, 2010-2013 он



Эх сурвалж: Монголбанк

Тайлант онд банкуудын нөөцийн эх үүсвэр өссөн тул Монголбанкаас авах овернайт репо санхүүжилтийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 2.2 дахин буурч, 2.2 их наяд төгрөгт хүрсэн ба шинэ санхүүжилтийн хэрэгсэл овернайт хадгаламжийн дун 22.5 их наяд төгрөгт хүрчээ (Зураг 33).

Зураг 34: Бодлогын хүү ба БХЗ-ын хэлцлийн хүүнүүд



Хүүний коридорыг нэвтрүүлж, нээлттэй захын үйл ажиллагаа (НЗҮА), Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдэд өөрчлөлт оруулснаар банк хоорондын захын хэлцлийн хүүнүүдийн хэлбэлзэл буурсан нь Зураг 34-т харагдаж байна.

Эх сурвалж: Монголбанк

⁵ Хүүний коридорыг нэвтрүүлэх хүртэл ашиглагдаж байсан.

3.3 Засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)


ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаа

2012 оны 10 дугаар сард Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлогын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ыг баталсан билээ. 2013 онд тус журмын дагуу анхдагч зах дээр нийт 63 удаагийн арилжаагаар 2.6 их наяд төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий Засгийн газрын богино хугацаат үнэт цаас, Засгийн газрын бондыг Монголбанкаар дамжуулан борлуулав (Зураг 35).

Засгийн газрын үнэт цаасны арилжааг тогтмолжуулж, долоо хоног бурийн Лхагва гарагт зохион байгуулж эхэлснээр хүүгийн түвшин тогтмол буурсаар ирлээ. Тухайлбал, оны эхэнд 12.88%-ийн хүйтэйгээр арилжигдаж байсан 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны хүү оны эцэст 9.1% болж буурсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа тогтмолжин, зах зээл дэх үнэт цаасны үлдэгдэл хангалттай хэмжээнд хүрч, улмаар хоёрдогч зах зээлийг идэвхижүүлэхэд бэлэн болсны нэг илрэл юм.

Зураг 35: 2013 оны ЗГҮЦ-ны нийт арилжаа, хугацааны ангиллаар



Эх сурвалж: Монголбанк

ЗГҮЦ-ны хоёрдогч захын арилжаа

2013 онд Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ыг баталж, хоёрдогч захын үйл ажиллагааг амжилттай эхлүүллээ. Улмаар 2013 онд нийт 295 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ЗГҮЦ хоёрдогч зах дээр арилжигдсанаас 55 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг мэргэжлийн хөрөнгө оруулагчид шууд оролцогчоор дамжуулан худалдан авсан байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч захыг хөгжүүлснээр өгөөжийн муурдигийн болгохын зэрэгцээ үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах бөгөөд энэ нь төгрөгийн эрсдэлгүй хүүгийн түвшинг тодорхойлох төдийгүй санхүүгийн зах зээлийн суурь хүү болж, санхүүгийн салбарын хөгжилд ихээхэн түлхэц болох учиртай.

Цаашид Сангийн Яам, Монголбанк хамтран Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцох эрхийг тодорхой тооны оролцогчдод олгож, төрөл бүрийн хугацаатай ЗГҮЦ-ыг эзэмшиж, хөрөнгө оруулагч наарт худалдах, худалдан авах боломж бий болгох “Үндсэн дилериийн систем” нэвтрүүлэхээр ажиллаж байна.

3.4 Гадаад валютын дуудлага худалдаа

2013 онд Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг тууштай баримтлан, эрэлт нийлүүлэлтийн зөрүүнээс шалтгаалсан ханшийн огцом савлагааг зөөлрүүлэх, валютын захын тогтвортой байдлыг хангах үүднээс гадаад валютын дуудлага худалдааг нийт 103 удаа зохион байгууллаа.

Сүүлийн жилүүдэд манай улс ургал дансны их хэмжээний алдагдлаа гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж ирсэн бол 2013 онд гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт үлэмж буурснаар төлбөрийн тэнцлийн хүндрэл нь хямралын шинжтэй болсноор төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд хүчтэй нөлөөлсөн. Энэ үед эрэлт нийлүүлэлтийн зөрүүнээс шалтгаалсан ханшийн огцом савлагаа үүсэхгүй байх зорилгоор Монголбанк валютын заход спот хэлбэрээр болон санхүүгийн үүсмэл хэрэгслээр идэвхтэй оролцож, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулж ажиллалаа.

2013 онд Монголбанк дуудлага худалдаагаар спот заход цэврээр 1.2 тэрбум ам.доллар нийлүүлсэн бол дотоодын валютын заход юанийн хомсдол үүсгэхгүй байх, юаниар дамжиж ам.долларын эрэлт дээр ирдэг дарамтыг бууруулах зорилгоор 4.3 тэрбум юанийг валютын заход нийлүүллээ. Түүнчлэн, тайлант онд шаардлагатай үед валютын заход дуудлага худалдааны бус аргаар оролцож, нийт 213 сая ам.долларыг валютын заход нийлүүлэн, ханшийн огцом хөдөлгөөн, зохисгүй хэлбэлзлийг багасгаж ажиллалаа.


Монголбанк спот заход оролцохын зэрэгцээ банкууд, тэдгээрийн харилцагчдын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүгийн үүсмэл хэрэгслийг идэвхтэй ашиглаж байна. Тухайлбал 2013 онд нийт ессөн дүнгээр 6.6 тэрбум ам.долларын дүнтэй тэнцэх төгрөгийн споп, 457 сая ам.долларын дүнтэй тэнцэх ам.долларын споп, 305 сая ам.долларын форвард хэлцлийг хийжээ. Харин Хятадын Ардын банктай байгуулсан үндэсний мөнгөн тэмдэгт солилцох споп хэлцлийн гэрээний хүрээнд 2013 онд нийт 183 сая юанийн споп хэлцлийг арилжааны банкуудтай байгуулсан байна.

3.5 Дотоодын зах зээлээс алт худалдан авах үйл ажиллагаа

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх дотоодын эх үүсвэрүүдийн нэг нь алт худалдан авах үйл ажиллагаа билээ. Монголбанк дотоодын алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс худалдан авсан алтыг гадаадын байгууллагуудад олон улсын жишигт хүргэн цэвэршүүлэн мөнгөжүүлж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг. Тайлант хугацаанд Монголбанк 75

аж ахуйн нэгж, 13 иргэнээс нийт 6.04 тонн алтыг 378.1 тэрбум төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үзэс 2.7 тонн буюу 81.8%-иар өссөн үзүүлэлт юм. 2013 онд Монголбанк нийт 7.4 тонн алт цэвэршүүлж, гадаад валютын улсын нөөцийг 328.4 сая ам.доллараар нэмэгдүүллээ.

Зураг 36: Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (бохир жин, кг-аар)



Эх сурвалж: Монголбанк

Дурсгалын зоос

Монголбанкнаас Coin Invest Trust компанийтай байгуулсан зоос цутгах ерөнхий гэрээний хүрээнд “Бүргэд” мөнгөн зоос, “Чингис хаан” алтан зоос, “John F Kennedy” алтан зоос, мөнгөн зоос, “Морь” алт болон алтадсан мөнгөн зоос, “Чингис хаан” мөнгөн зоос ба өнгөт мөнгөн зоосуудыг цутгуулж, олон улсын зоос цуглувлагчдын зах зээлд гаргаад байна.



“Бүргэд” алт, мөнгөн зоос



“John F. Kennedy” алтан зоос



“Чингис хаан” алт, мөнгө, өнгөт мөнгөн зоос





“Морь” алт, алтадсан мөнгөн зоос

“Мануул” алт, мөнгөн зоос

Тайлант хугацаанд Coin Invest Trust компанитай байгуулсан ерөнхий гэрээний хүрээнд борлуулсан зоосны роялти төлбөр болох 4,249.25 ам.доллар, 6,195.90 евrog зоосны борлуулалтын орлогоос Монголбанкинд оруулсан. Мөн тайлант онд Олон улсын үзэсгэлэнгээс Монголын зооснууд шагнал хүртсэн. Үүнд: “Нохой зээх” цэвэр мөнгөн зоос Берлинд болсон дэлхийн үзэсгэлэнд Krause Publications-н олон улсын шагнал “Оны шилдэг зоос” (Coin of the year), мөн “Шилдэг мөнгөн зоос” (Best silver coin of the year) шагналуудыг, “Хув ууль” цэвэр мөнгөн зоос Берлины дэлхийн мөнгөний үзэсгэлэнд Krause Publications-н олон улсын шагнал “Хамгийн алдартай зоос” (most popular coin), Москвад болсон олон улсын дурсгалын зоосны 6 дугаар уралдаанаас Water Mark Publishing House “Оны шилдэг мөнгөн зоос”-ны төрөлд 3 дугаар байрын шагналыг тус тус хүртсэн. Энэхүү зоос 2014 оны Берлины олон улсын үзэсгэлэнгээс мөн шагнал авах магадлал өндөр байна.

Монгол Улсад өргөн хэрэглээний зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн механизм олон жилийн турш үр ашиг муутай, тогтвортой бус байснаас нийлүүлэлтийн гаралтай буюу зардлын шалтгаантай инфляци байнга өндөр байсаар ирсэн. Иймд Монголбанк инфляцийг бууруулж, иргэдийн бодит орлогыг хамгаалах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах замаар гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, улмаар зах зээлийн зарчимд суурилсан, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон юм.

Дээрх зорилтын хүрээнд Монголбанк, Засгийн газар хамтран “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталж⁶, энэ хүрээнд дараах дэд хөтөлбөрүүдийг зөвхөн хувийн хэвшлээр дамжуулан богино хугацаатай эргэлтийн хөрөнгийн зээл олгох хэлбэрээр хэрэгжүүлж, зохих үр дүнд хүрч байна. Үүнд:

- **Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах (FPS) дэд хөтөлбөр**


Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтвожуулах хөтөлбөр: Дэд хөтөлбөрийн хүрээнд хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагаанд шинэ тогтолцоо нэвтрүүлэн, амжилттай зохион байгуулж дууслаа. УХААЯ-наас Улаанбаатар хотод “Жаст Агро” ХХК, Дархан хотод “Баатрууд тэнгэр” ХХК, Эрдэнэт хотод “Эрдмийт” ХХК-ийг нөөцийн махны менежерээр сонгон шалгаруулж, 2012 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Хөтөлбөрт оролцогч банкууд нь УХААЯ-наас сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан нөөцийн махны менежер компаниудын эрсдэлийг үндэслний үндсэн дээр махны нөөц бүрдүүлэхэд зориулж 87 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон бөгөөд олгогдсон зээл бүхэлдээ компаниудаас банкинд, банкнаас Монголбанкинд бүрэн төлөгдсөн.

Дэд хөтөлбөрийн хүрээнд 11,446.1 тонн махны нөөц бэлтгэснээс Дархан хотод 1025.1 тонн, Эрдэнэт хотод 1016.1 тонн мах нөөцөлж, нийт нөөцийг 100 хувь борлуулжээ. Эдгээр хотууд дахь нөөцийн менежерүүд нь нөөцийн махны худалдан авалтад 5.45 тэрбум төгрөгийн зээл авч, төлбөрийн хуваарийн дагуу 7 дугаар сарын эцэст зээлийг бүрэн төлж дууссан болно. Улаанбаатар хотод 9405 тн мах нөөцөлж, борлуулалт нь 7 дугаар сард 100% байлаа.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн хугацаанд буюу 2012 оны 10 дугаар сараас 2013 оны 7 дугаар сарын хооронд махны дундаж үнийн өсөлт өмнөх оны мөн үеэс 2 дахин бага байна. Мөн үхрийн цул махны үнийн жилийн өсөлт 2013 оны 7 дугаар сард өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөс 2.5 дахин бага, үхрийн ястай махны үнийн жилийн өсөлт 2.2 дахин бага, хонины махны үнийн жилийн өсөлт 3.4 дахин бага байна (Зураг 37).

⁶ Төвбанкны тухай хууль, УИХ-ын 2012 оны 57 дугаар тогтоол, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус тус үндэслэсэн.

Зураг 37: Махны үнийн жилийн өсөлт



Эх сурвалжууд: УСХ

2013 онд махны үнэ 10.5%-ийн өсөлттэй гарсан нь 2012 оны махны үнийн өсөлтөөс 4.2 дахин, 2010-2012 оны дундаж өсөлтөөс 3.3 дахин буурсан үзүүлэлттэй гараад байна.

2014 оны махны нөөц бүрдүүлэх, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагаанд зориулан 2013 оны 11-12 дугаар саруудад Монголбанкнаас 61.6 тэрбум төгрөг, оролцогч банкуудаас 15.4 тэрбум төгрөг, нийт 77 тэрбум төгрөгийн зээлийг хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниудад олгоод байна. Ийнхүү 2014 оноос эхлэн махны нөөц бүрдүүлэх зээлийн эх үүсвэрийг Монголбанкнаас гадна банк өөрийн эх үүсвэрээр хэсэгчлэн олгож эхэллээ. Цаашид агуулах дахь махны баталгаажсан нөөцийг банк өөрийнхөө эх үүсвэрээр бүрэн санхүүжүүлдэг болсноор Монголбанк хөтөлбөрөөс гарах юм. 2014 оны махны нөөц бүрдүүлэх ажил эхэлснээс 2013 оныг дуусталх хугацаанд нөөцийн менежер 4 компаниуд 13.2 мянган тонн мах буюу нийт нөөцийн 94.3%-ийг бүрдүүлсэн байна.


Гурилын үнийг тогтвортжуулах хөтөлбөр: Гурилын үйлдвэрүүдийн улаан буудай худалдан авах зардлыг бууруулах, гурилын нөөц бүрдүүлэх, нөөцийн чанар, борлуулалтад хяналт тавих ажлуудыг хэрэгжүүлж байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас банкуудад зээл өгч, банкууд нийт 61 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 36 гурилын үйлдвэрт олгохоор төлөвлөсөн бөгөөд 2013 онд 23 гурилын үйлдвэрт нийт 48.7 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Үүнээс 36.2 тэрбум төгрөгийн зээлийг эргүүлэн төлж, 17 гурилын үйлдвэр зээлээ бүрэн төлж дуусгаснаар нийт зээлийн үлдэгдэл 12.5 тэрбум төгрөг байв. Эдгээр зээл нь эргэн төлөлтийн хуваарийн дагуу бүрэн төлөгднө. Үйлдвэрүүд тариаланчид болон Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас авсан буудайн үнийг төлж барагдуулсан бөгөөд гурилын үйлдвэрлэл нь хэвийн явагдаж байна.

Хөтөлбөрийн хүрээнд гурилын үйлдвэрүүд үйл ажиллагаагаа өргөжүүлж, Улаанбаатар хотын гурилын хэрэгцээг 100 хувь хангах хүчин чадалтай болсон бөгөөд хөтөлбөрийн зорилтот бүтээгдэхүүн болох 1 дүгээр гурилын үнэ оны туршид тогтвортой байлаа.

- Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтвортжуулах (HPS) дэд хөтөлбөр**

Тус хөтөлбөрийг БХБЯ-тай хамтран 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дараах үндсэн чиглэл, зорилттойгоор хэрэгжүүлж байна:

Зураг 38: Махны үнийн жилийн өсөлт



Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтвортжуулах:


- Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах;
- Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих.

Энэ хүрээнд Засгийн газартай гэрээ байгуулсан барилгын материал үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөллөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх боломжийг олгох, барилгын гол нэрийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангахад зориулж 71 компанид 174.7 тэрбум төгрөг, зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгахад зориулж 55 компанийд 125.4 тэрбум төгрөг, нийт 301.6 тэрбум төгрөгийн зээлийг банкууд олгожээ. БХБЯ-ны мэдээллээс үзэхэд хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2013 онд цемент, арматур импортлогч компаниуд нийт 1,520,000 тонн цемент, 179,198 тонн арматур импортолсон байна. Үүнээс хөтөлбөрийн санхүүжилтээр 490,000 тонн цемент (32%), 161,605 (90%) тонн арматур оруулж иржээ.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр цементийн үнэ 2013 онд эхний 6 сард маш тогтвортой, 7 дугаар сараас эхлэн хэлбэлзэл өндөртэй байжээ. Арматурын үнэ 2013 онд тогтвортой байлаа. Хөнгөллтэй зээл авсан ААН-үүд нь гэрээнд заасан үнээр буюу нэг тонн арматурыг 1150 төгрөгөөр борлуулж гэрээний үүргээ хүлээнээр хөтөлбөрийн зорилго биелсэн байна.

Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвортжуулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дунд барилгын салбар 2013 онд 66.5%-ийн өсөлттэй гарснаар ДНБ-ий бодит өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалж, хөдөлмөрийн зах зээлд ажлын байрыг хамгаалахад чухлаар нөлөөллөө.

Зураг 39: Арматур, цементийн үнэ (сараар, мянган төгрөг)



Эх сурвалж: БХБЯ

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох:

Инфляци буурч макро тогтвортой байдал хангагдсан, банкуудын өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүд сайжирч банкны салбар бэхжэсэн, санхүүгийн салбарыг зээлийн тасалдал, болзошгүй хямралын эрсдэлээс сэргийлсэн, орон сууцны барилгын нийлүүлэлт болон


Эдийн засгийн бодит секторын идэвхжилийг дэмжсэн орчинд Монголбанкнаас нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх зорилгоор “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлсэн.

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Монголбанк Засгийн газартай 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. Энэ хүрээнд Монголбанкнаас 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдөр баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын дагуу ерөнхий гэрээг банкууд болон МИК-тай байгуулж, өмнө олгосон орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхэд болон шинээр ипотекийн зээл олгоход зориулж 1.5 их наяд төгрөгийг банкуудад байршуулсан болно.

Хөтөлбөрийг 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхлэв. Банкууд 2013 оны эцсийн байдлаар 16,750 зээлдэгчийн 474.5 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн хүүг 8%-д шилжүүлжээ. Мөн 12,803 иргэнд 739.1 тэрбум төгрөгийн орон сууцны ипотекийн зээл шинээр олгосон байна.

Ийнхүү орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор Монгол Улс хэрэглээний эдийн засгаас хуримтлалтай эдийн засагт шилжих, нийгмийн дундаж давхаргын хуримтлал, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн ил тод байдлыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлнэ. Уг тогтолцоо нь эргээд урт хугацаанд инфляцийг бууруулахад эерэгээр нөлөөлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангах болно.

Зураг 40: Орон сууцны ипотекийн зээл



Эх сурвалжүүд: Монголбанк, банкуудын тайллан мэдээлэл

- **Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах TLF дэд хөтөлбөр**

Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго: Монгол Улсын гадаад худалдааны тээвэр, логистикийн өндөр зардал, хүчин чадлын дутагдалтай байдал нь бүтээгдэхүүний үнийг өсгөх, нийлүүлэлтийн хомсдол үүсгэнээр олон жилийн турш инфляцийн дарамт үүсгэж байлаа. Иймд өргөн

хэрэглээний импортын бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах шаардлагатай болсон.

Дээрх шаардлага, зорилгыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Зам, тээврийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан тушаалаар “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь дунд хугацаанд хэрэгжих бөгөөд төмөр замын үйлчилгээг сайжруулах, хөнгөвчлөх зорилгоор гадаад, дотоод харилцааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлэхийн сацуу нийт 303 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр дараах арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1. Вагон паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	136 тэрбум төгрөг
2. Зүтгүүрийн паркийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	95 тэрбум төгрөг
3. Шатахууны эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх	22 тэрбум төгрөг
4. Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх	50 тэрбум төгрөг

Хэрэгжилтийн байдал:

2013 оны 3 дугаар сарын 21-ний өдөр “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэхээр хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан жилийн 3.8%-ийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 22 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, хуваарийн дагуу энэ онд нийт 10 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөөд байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд нэмэлт санхүүжилт шаардагдахгүй дараах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлт Замын-Үүдээс Улаанбаатар чиглэлд 2-3 хоног байсныг 23 цагт багтаан тээвэрлэдэг болгож хурдасгасан.
- Замын-Үүд өртөө, Замын-Үүд шилжүүлэн ачих ангийн ачилтын технологийн цаг 24 байсныг 11 цаг болгон бууруулснаар, ачигдсан вагонууд тухайн өдөртөө хатуу зурмагт галт тэргэнд холбогддог болсон.
- Ачилтын ажлыг шуурхай болгохын зэрэгцээ сэлгээний ажил болон ачаа ачих, буулгах үйл ажиллагааг зохицуулах тусгай журам боловсруулан 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдөрөөс эхлэн мөрдөн ажилласнаар ачигдсан вагонууд өдөртөө хатуу зурмагт галт тэргэнд холбогдож, вагон эргэлтийн хугацаа 2011 онд 4.41 хоног, 2012 онд 3.59 хоног байсныг 2013 онд 3 хоног болгон буурууллаа.
- Импортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх төмөр замын үйлчилгээг сайжруулж хэвшүүллээ. Энэ хүрээнд авто зам, төмөр замаар орж ирсэн ачааг сааталгүй сэлгэн ачих, ачилтын бригадын зохион байгуулалтыг сайжруулах, хэрэглэгчдэд зөвлөгөө өгөх, Улаанбаатар хотод ирсэн ачааг гар утасны мессежээр хэрэглэгчдэд мэдэгдэх, “хаалганаас хаалганд” ачаа хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх, ачаалалтай өдрийд нэмэлт галт тэргийг аялзуулах зэрэг ажлыг зохион байгууллаа.
- Зам, тээврийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 76 дугаар тушаалаар “Улаанбаатар төмөр зам”-ын хэрэгцээнд шатахуун импортлох талаар ОХУ-ын “Роснефть” ХК-тай хэлэлцээр хийж, шатахуун худалдан авах нөхцөлийг бүрдүүлж, зохицуулах чиг үүрэг бүхий

Ажлын хэсэг байгуулснаар “Улаанбаатар төмөр зам” ОХУ-ын “Роснефть” НК болон БНСУ-ын “KB Energy” ХХК-тай шатахууны импортын худалдааны гэрээг байгуулж, 2013 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар нийт 4 тэрбум төгрөгийн шатахууны зардал хэмнэлээ.

- Тянжин-Замын-Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хурдан шуурхай зохион байгуулахын тулд нарийн царигийн төмөр замаар ирж байгаа вагонуудыг шуурхай хүлээн авч шилжүүлэн ачих, гадаад вагоныг хурдан суллаж буцаах ажлыг 2012 оны 11 дүгээр сараас тогтмол зохион байгуулж байна. Вагон эргэлтийг түргэтгэж, нарийн царигийн төмөр замаар ирж байгаа ачааг хуримтуулалгүй шилжүүлэн ачиж, тээвэрлэснээр Хятадын төмөр зам, Тяньжин боомтод ачааны саатал гараагүй.
- “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгт шаардлагатай ачааны 400 хагас вагон, 60 битүү вагон, гол замын 3 зүтгүүр, сэлгээний 3 зүтгүүрийг 70 тэрбум төгрөгийн зээлээр худалдан авах асуудал тус нийгэмлэгийн 2013 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн Ерөнхий хорооны хурлаар дэмжигдсэн. Худалдан авах вагоны судалгаа, төсвийг ОХУ-ын вагон үйлдвэрүүд рүү явуулсны дагуу ОХУ-ын төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэдэг 6 компанийн холбоо тогтоож, нийлүүлэх вагонуудын судалгааг хийсэн. Улмаар 2013 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн Ерөнхий хорооны хурлаар “Трансмашхолдинг” компанийн хөдлөх бүрэлдэхүүн худалдан авах гэрээ хийхээр шийдвэрлэж, худалдан авах гэрээний бэлтгэл ажлыг хангаж байна.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дунд өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүн Замын-Үүд боомтоос Улаанбаатар хотод 24 цагийн дотор тээвэрлэгдэн хүргэгддэг болсноор импортын бүтээгдэхүүний өртөг дэх дэд бүтцийн хязгаарлалтаас шалтгаалсан серөг нөлөөллийг үлэмж бууруулав. Ингэснээр суурь инфляци бага байх нөхцөл бүрдэнэ.

Одоо хийгдэж байгаа ажил:

- “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгт шаардлагатай ачааны 400 хагас вагон, 60 битүү вагон, гол замын 3 зүтгүүр, сэлгээний 3 зүтгүүрийг 70 тэрбум төгрөгийн зээлээр худалдан авах асуудал Ерөнхий хорооны хурлаар дэмжигдэн, улмаар ОХУ-ын Трансмашхолдинг компанийн худалдан авах гэрээ хийхээр тохиролцож, бэлтгэж ажлыг хангаж байна.
- 2013 оны 5 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Бээжин хотноо болсон Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын ХIII хуралдаанаар Хятадын тал тус улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэр, далайд гарах гарц, төмөр замын тээврийн салбарын бусад асуудлаар Монголын талд шаардлагатай дэмжлэгийг үзүүлэхээр тохиролцсон.

Цаашид авах арга хэмжээ:

- Хятад-Монголын хилийн өртөөдийн хооронд галт тэрэгний ойртолтын мэдээ солилцох асуудлаар Хятадын төмөр замтай гэрээ байгуулж шийдвэрлүүлэх.
- “Замын-Үүдийн логистикийн төвийн шилжүүлэн ачих битүү болон дээвэр бүхий задгай агуулах барих төсөл”-ийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, санхүүжилтийн асуудлыг журмын дагуу шийдвэрлэх, төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих.

Олон нийтэд нээлттэй байдал:

Хамтарсан тушаалын дагуу Монголбанк, ЗТЯ хамтран дэд хөтөлбөрийн зорилтот ажлын хэрэгжилтийн байдлыг дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон үнэлгээний тайлангуудыг Монголбанкны цахим хуудаст байршуулсан.

- **Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах SIFS дэд хөтөлбөр**

Дэд хөтөлбөрийн шаардлага, зорилго: Газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтын үнийн өсөлтийн инфляцид үзүүлэх шууд болон шууд бус нөлөө хүчтэй, нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт нь бусад бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх өдөөгч болж байдаг тул шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах нь үнийн тогтвортой байдлыг хангах Монголбанкны үндсэн зорилттой шууд хамаарлтай юм.

Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулахын тулд Засгийн газраас нефть боловсруулах үйлдвэр байгуулах, улсын нөөц бүрдүүлэх зэрэг дунд болон урт хугацаанд хэрэгжих ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Гэхдээ эдгээр ажлууд хийгдэх хүртэлх хугацаанд шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн өсөлтийг аль болох бага байлгахын тулд шатахууны импортын санхүүжилтийн өргтийг багасгах, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах зэрэг арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх шаардлага гарсан юм.

Иймд дээрх шаардлага, зорилтыг хэрэгжүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч, Уул, уурхайн сайдын 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хамтарсан тушаалаар энэхүү дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Хэрэгжилтийн байдал: (Монголбанкны хэрэгжүүлсэн ажил)

- Дэд хөтөлбөрийн хүрээнд УУЯ-тай гэрээ байгуулсан, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 13 компанийд хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан 3.8%-ийн хүйтэй, 1 жилийн хугацаатай 192 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 173.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Валютын ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2-6 сарын хугацаатай форвард хэлцлийг хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан шатахууны жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдтэй хийж байгаа бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төлбөр тооцоо хийгдсэн хэлцлийн дүн 621 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний ам.доллар болсон байна.
- Дээрх арга хэмжээ авсны үр дүнд шатахуун импортлогч компаниудын эргэлтийн хөрөнгийн дутагдал, валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ өсөх эрсдэлийг бууруулж, түлш шатахууны үнийн тогтвортой байдлыг хангаж чадлаа.


Уул уурхайн яам болон бусад төрийн байгууллагуудын хэрэгжүүлсэн ажил:

- Компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөтөлбөрийг эхлүүлсэн үетэй харьцуулахад 3.3 дахин нэмэгдэж, газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдсан.
- Уул уурхайн яамнаас санаачлан “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлын хүрээнд Засгийн газар БНХАУ-ын “Чайна Ойл” ХХК-тай гэрээ байгуулж, сар бүр 10 мянга хүртэл тонн шатахуун худалдан авахаар болсны зэрэгцээ БНСҮ-ын “SK Energy” зэрэг компаниудаас шатахуун худалдан авах боломжтой болсон.
- Уул уурхайн яамнаас БНСҮ-ын компаниудтай шатахуун худалдан авах талаар хэлэлцээр хийж байгаатай холбогдуулан БНХАУ-ын “Хятадын төмөр зам” компанийтай жилд 200 мянган


тонн шатахууныг тус улсын нутаг дэвсгэрээр тээвэрлэх гэрээ байгуулсан бөгөөд шатахууны тээвэрлэлтийг шийдвэрлэсэн.

- ОХУ-ын “Роснефть”, БНХАУ-ын “Чайна Ойл” компаниудаас худалдан авдаг шатахууны үнийг газрын тосны олон улсын биржийн үнэд суурilan тооцдог болсон. Ингэснээр нийлүүлэгч талаас шалтгаалах үнийн өсөлтийг хязгаарлах, үнийг харьцангуй тогтвортой байлгах, үнийн таамаглал хийх боломж бүрдсэн.
- Шатахууны импортын татварыг хилийн үнийн бууралттай уялдуулан сэргээж, татварын зохицуулалтын орон зайд нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гааль, онцгой албан татварын тухай” 236 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварыг нэмэгдүүлсэн.

Зураг 41: А-92 шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



Зураг 42: Дизель түлшний жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)




Эх сурвалжууд: Монголбанк, УУЯ, ГТГ

Хөтөлбөрийн үр дүн:

- Газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулсан.
- Шатахууны жижиглэнгийн худалдааны үнэ дэх валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах эрсдэл эрс буурсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний биет нөөц нэмэгдсэн.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлсэн.
- Засгийн газраас газрын тосны бүтээгдэхүүний үнийн талаар гадаад талтай зөвшилцөх чадавхи сайжирсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний татварын зохицуулалтыг сэргээсэн.

Зураг 43: Газрын тосны бүтээгдэхүүний сарын нөөц (мянган ам.доллар)



Эх сурвалжсууд: Монголбанк, УУЯ, ГТГ

Олон нийтэд нээлттэй байдал: Хамтарсан тушаалын дагуу Монголбанк, УУЯ хамтран дэд хөтөлбөрийн зорилтот ажлын хэрэгжилтийн байдлыг дүгнэж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон үнэлгээний тайлангуудыг Монголбанкны цахим хуудаст байршуулсан.

- Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчиний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчиний үнэ, тарифыг тогтвортжуулах дэд хөтөлбөр**


Түлш, эрчим хүчиний салбарын төрийн өмчтэй компаниудын санхүүгийн чадавхийг бүрдүүлэх замаар 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, эрчим хүчиний үнэ, тарифийг тогтвортжуулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Эрчим хүчиний сайдын 2013 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар энэхүү дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Эрчим хүчиний зохицуулах хорооноос цахилгааны үнэ тарифыг 2013 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 20%-иар нэмэгдүүлэх шийдвэрийг энэхүү дэд хөтөлбөр батлагдахаас өмнө гаргасан байна. Иймд цаашид зардлын шалтгаантай инфляцийн дарамтыг огцом нэмэгдүүлэхгүй байлгах зорилтын хүрээнд энэхүү дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага гарсан юм.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Түлш, эрчим хүчиний үнэ, тарифт өөрчлөлт оруулах бодит шаардлага гарсан тохиолдолд тухайн оны зөвхөн 6-12 дугаар сард өөрчлөлт оруулах, ингэхдээ нэг сард ногдох тарифын өөрчлөлтийг 2%-иас ихгүй байлгах жишгийг ЭХЯ, Эрчим хүчиний зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Засгийн газрын холбогдох яамд хамтран хэрэгжүүлнэ.
- ТӨК-иудад 2013-2014 оны нүүрсний аюулгүйн нөөц бүрдэнэ.
- Түлш, эрчим хүчиний нийлүүлэлт тасралтгүй, найдвартай байх нөхцөл хангагдана.
- Цахилгаан, дулааны үнэ, тариф харьцаангуй тогтвортой байж, зардлын шалтгаантай инфляцийн дарамт тодорхой хэмжээгээр буурах суурь нөхцөл бүрдэнэ.

Зураг 44: Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийн сарын өөрчлөлт (төгрөгөөр)



5.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт

Монголбанк 9 газар, 2 бие даасан алба, орон нутаг дахь Монголбанкны 17 салбар, Лондон дахь төлөөлөгчийн газар бүхий бүтэц зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 онд Монголбанкинд 455 ажилтан ажилласнаас 334 ажилтан Төв аппаратад, 121 ажилтан орон нутагт ажиллаж байна.

2013 онд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 229 удаагийн сургалт, семинарт 168 ажилтан чиг үүргийн дагуу богино хугацааны сургалтад хамрагдсан ба 36 ажилтан 86 удаагийн олон улсын хурал, уулзалтад оролцжээ.

Тайлант онд Ардын хувьсгалын 92 жилийн ойн баяр, Улс тунхагласны ойг тохиолдуулан Төрийн одон медаль, шагналд Монголбанкнаас нийт 46 ажилтны нэр дэвшсэнээс Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2 ажилтан, “Алтан гадас” одонгоор 11 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 12 ажилтан тус тус шагнагдсан байна.

5.2 Олон нийттэй харилцах харилцаа

Монголбанкнаас олон нийттэй харилцах чиглэлээр мөнгөний бодлогын зорилго, түүнд хүрэх арга замыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгаж, Төв банкны бодлогод итгэлийг нэмэгдүүлэн инфляцийн хүлээлтэнд нөлөөлөх чадамжкаа дээшлүүлж, Төвбанкнаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой ажиллав. Энэхүү зорилтын хүрээнд Монголбанкнаас 2013 оны турш макро эдийн засаг, санхүүгийн салбарын төлөв байдал, Төв банкны үндсэн зорилт, бодлогын арга хэмжээ, хэрэгжилтийн үр дүн, үйл ажиллагааны ил тод байдал, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдаа зэрэг сэдвээр олон нийт, оюутан сурагчид, хэвлэл мэдээллийн байгууллагад тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд эдийн засгийн чиглэлээр ажилладаг сэтгүүлчдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтыг тогтмол зохион байгуулж, ярилцлага мэдээлэл өгөх, оюутан сурагчид, санхүүгийн захын оролцогчдод сургалт, семинар зохион байгуулах, лекц үнших зэрэг ажлыг оны турш зохион байгуулсан болно. Түүнчлэн оюутан сурагчдад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд “Монголбанкинд зочил” экспурс хөтөлбөрийг үргэлжлүүлэн, их дээд сургуулиудаар зочлон илтгэл үншиж, мэдээлэл өглөө.

“Мөнгөний бодлогын үндсэн чиглэл”-ийг сурталчлах, тайлбарлан таниулах

Монголбанк “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг УИХ, Засгийн газар, хэвлэл мэдээллийн байгууллагууд, санхүүгийн зах зээл, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Энэ хүрээнд Монголбанкнаас хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдэд сургалт, семинар зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбарлан таниулах ажлыг гүйцэтгэв. Мөн үндсэн чиглэлтэй холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн хэлсэн үг болон удирдлагуудын ярилцлагыг томоохон сонин хэвлэлээр тогтмол нийтлэн, олон нийтийн хүртээл болгов.

“Мөнгөний бодлогын шийдвэр гаргалт ба хэвлэлийн хурал”

Монголбанк 2012 оны 10 дугаар сард Мөнгөний бодлогын зөвлөлийг шинээр, Захирлуудын зөвлөлөөсөө тусад нь байгуулж, зөвлөл дэх хараат бус гишүүдийн тоог нэмэгдүүлэн, шинэ бүтэц, зохион байгуулалт, журмаар мөнгөний бодлогын саналыг 3 үе шаттайгаар, өргөн хүрээнд нухацтай

хэлэлцсэний үндсэн дээр бодлогын шийдвэр гаргадаг болсон билээ. Ийнхүү асуудлыг тал бүрээс нь нухацтай хэлэлцсэний үндсэн дээр гаргасан шийдвэрээ албан ёсны хэвлэлийн хурлаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол тайлбарлан мэдээлж байна.

Мөнгөний бодлогын асуудлаар болон цаг үеийн сэдвээр хийсэн хэвлэлийн хурлаар Монголбанкны удирдлагууд сэтгүүлчдийн сонирхсон асуултад хариулт өгөх, мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэл, шалтгаан, бодлогын хэрэгжилт, хүлээлт зэрэг сэдвээр зохих тайлбар, тодруулга өгч ажиллав. Монголбанк “Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийг тухай бүр цахим хуудастаа байршуулан мөнгөний бодлогын хүү, бусад хэрэгсэлд өөрчлөлт орсон эсэх асуудлаарх мэдээллийг олон нийтэд өгч, Мөнгөний бодлогын зөвлөлийн болон Монголбанкны хэвлэлийн хурлын протоколуудыг цахим хуудаст байршуулан ажиллав.

“Монголбанкны хэвлэмэл бүтээгдэхүүн”

Монголбанкны уламжлалт хэвлэмэл бүтээгдэхүүн болох Жилийн тайлан, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл, Монголбанкны судалгааны ажил, Санхүүгийн тогтвортой байдлын тайлан зэргийг хэвлүүлэн УИХ, Засгийн газрын гишүүд, төрийн байгууллагууд, арилжааны банкууд болон их дээд сургууль, номын сангутад хүргүүлэв. Түүнчлэн Монголбанкны цахим хуудаст байршуулан олны хүртээл болгож байна.

“Цахим хуудсыг боловсронгуй болгох”

Монголбанк өөрийн цахим хуудасны үйл ажиллагааг боловсронгуй болгоход онцгой анхаарал хандуулан ажиллалаа. Төв банкны цахим хуудаст “8%^{+/-1} баннер” “Гадаад секторын мэдээлэл”, “Эдийн засгийн цагаан толгой” зэрэг дэд цэсүүдийг шинээр үүсгэж, шаардлагатай мэдээллийг тухай бүр шинэчилж байна. Мөн “Мөнгөний бодлогын зөвлөл” цэсийн агуулга, бүтцэд анхааран, зөвлөлийн гишүүдийн мэдээлэл, бодлогын шийдвэр зэрэг мэдээг шинээр оруулах, шинэчлэн найруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Төв банкны хараат бус байдал, хариуцлага, ил тод байдал, Төв банкинд итгэх итгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэхэд онцгойлон анхаарч ажиллалаа. Монголбанкны удирдлагуудын ярилцлага мэдээллийг тухай бүр цахим хуудаст байршуулж олны хүртээл болгов. Монголбанкнаас цахим хуудсаараа дамжуулан судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийг олон нийтэд цаг хугацаанд нь хүргэх ажлыг ургэлжлүүлж байна.

5.3 Гадаад харилцаа

Монголбанк гадаад харилцааны бодлогын хүрээнд бүс нутгийн санхүүгийн байгууллагын гишүүнчлэлээр Азийн Төв банкуудтай хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлж, тухайн бүс нутгийн санхүүгийн интеграцчилалд түлхүү анхааран, гадаадын Төв банкуудтай тогтоосон хоёр талт харилцааг цаашид өргөжүүлэн ажиллаж ирлээ.

Гадаад харилцааны чиглэлээр 2013 онд хийгдсэн гол ажлуудыг тоймлон дурдвал:

- Зүүн Өмнөд Азийн Төв банкуудын холбооны Гүйцэтгэх зөвлөлийн 12 дахь хурал, хурлын өмнөх дээд түвшний семинарыг 2013 оны 9 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд “Мөнгөний бодлогын шинэ хэв шинж ба санхүүгийн салбарын макро уялдаа” сэдвээр Улаанбаатар хотноо зохион байгуулав. Уг хурлыг Монголбанкны Ерөнхийлөгч даргалан хуралдуулсан ба БНХАУ, БНСУ, БНВУ зэрэг Зүүн Өмнөд Азийн нийт 16 орны Төв банкны ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нар оролцсон юм. Энэ хүрээнд дэлхийн санхүүгийн хямраалаас хойшхи хугацаанд

Төв банкуудын авсан сургамж; Хөрөнгийн урсгалын тогтвортой байдал, ханшийн савлагааны үед санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах асуудал; Санхүүгийн мөчлөг, түүнд нийцсэн бодлого; Хөгжингүй орнуудын мөнгөний бодлогын төлвийн өөрчлөлтөд хөгжиж буй орнуудын зүгээс үзүүлэх хариу үйлдэл зэрэг асуудлуудыг хөндөж ярилцаа. Мөн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл, арга барил өөрчлөгдж, тэрхүү өөрчлөлт нь шинэ стандарт болон хэвшиж байгааг онцлов.

- Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн байгууллага, Евро-Азийн бүсийн байгууллагын хамтарсан топологийн хуралдаан болон мөнгө угаахтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх сургалтыг Улаанбаатар хотноо 9 дүгээр сарын 23-27-ны хооронд зохион байгуулав. Монгол Улс анх удаагаа мөнгө угаахтай тэмцэх чиглэлээр олон улсын томоохон хуралдааныг эх орондоо зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн хуралдааны нэг онцлог нь Ази Номхон далайн бүсийн байгууллага, Евро-Азийн бүсийн байгууллага хамтран хуралдаж байгаа явдал юм. Энэхүү хуралдаанд Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн байгууллага, Евро-Азийн бүсийн байгууллагын гишүүн орнуудаас нийт 250 гаруй төлөөлөгч оролцлоо. Мөн Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага /FATF/, Дэлхийн банк, ОУВС зэрэг найман байгууллага ажиглагчаар оролцсон юм.
- Монголбанк, Сангийн яамнаас Европын сэргээн босголт, хөгжлийн банктай “Дотоодын валютаар зээл олгох хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурав. Уг санамж бичиг нь тус банкнаас Монгол Улсад хийх зээл, хөрөнгө оруулалт, бусад санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг чухал ач холбогдолтой юм. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас Монголын хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдэд харьцангуй хямд өртөг бүхий төгрөгийн зээлийг олгож эхлэх юм. Ингэснээр гадаад валютын орлогогүй зээлдэгчдийн ханшийн эрсдэл буурч, улмаар банк, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх бөгөөд тус банкнаас Монголд оруулах хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдэх боломж бүрдэв.
- Тайлант онд Монголбанкаас ХБНГУ-ын Бундесбанк, БНХАУ-ын Ардын банк, Азийн банкуудын холбоо болон олон улсын бусад банк, санхүүгийн байгууллагатай гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллав.

5.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх олон улсын бодлогыг боловсруулах чиг үүрэгтэй Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бүлэг (ФАТФ)-ээс манай улсад тавьж байгаа хяналтын хүрээнд 2012, 2013 оны турш Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол улсын хууль тогтоомжийг олон улсын стандарт (ФАТФ-ын 40 зөвлөмж)-д нийцүүлэхтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлыг ХЗЯ, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэлээ.

Үүний үр дүнд УИХ-ын чуулганы 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга, Терроризмтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталсан.

ФАТФ-тай тохирсон төлөвлөгөөний дагуу 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Терроризмтэй тэмцэх тухай хуулийн холбогдох нэмэлт өөрчлөлт, НҮБ-ын Аюулгүйн

Зөвлөлөөс гаргасан 1267, 1373 дугаар тогтоолуудад үндэслэн “Террористуудын жагсаалтыг гаргах, тэдгээрийн хөрөнгийг битүүмжлэх, хянах журам”-ыг батлуулсан.

Түүнчлэн, 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр УИХ-аар Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулинд тус тус холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулснаар Монгол Улс ФАТФ-тай тохирсон ажлуудыг бүгдийг хийсэнд тооцсон байна. Ингэснээр 2014 оны 2 дугаар сарын 17-нд Францын Парис хотноо болсон ФАТФ-ын 22 дугаар чуулга уулзалтын үеэр энэ чиглэлд манай улсын гаргасан ахицыг өндөрөөр үнэлж, Монгол Улсыг “хар саарал жагсаалт”-аас гаргаж зэрэглэлийг нь дээшлүүлсэн юм.

Дээрх хуулийн төслийдийг боловсруулахад Дэлхийн банк, ОУВС, НҮБ-ын терроризмын эсрэг хяналтын баг, Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгийн хяналтын бүлэг зэрэг олон улсын байгууллагуудтай Монголбанк нягт хамтарч ажилласан.

2013 онд Монголбанк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулинд орох нэмэлт, өөрчлөлтийн талаар гаргаж байгаа ахиц дэвшлийн талаар ФАТФ, APG байгууллагад улирал бүр бичгээр болон амаар танилцуулж, тайлagnаж ирсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Монголбанкны бүтцэд ажилладаг, санхүүгийн байгууллагуудаас мөнгө угаах, эсхүл терроризмыг санхүүжүүлэх сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авч, дүн шинжилгээ хийн, хууль сахиулах байгууллагуудад дамжуулах чиг үүрэгтэй Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ны орон тоо, чадавхийг дээшлүүлэхтэй холбоотой ажлуудыг хэрэгжүүлэв. Үүний үр дүнд Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцоонд хийсэн 2012 оны харилцан үнэлгээний дагуух үнэлгээ (mutual evaluation follow up)-гээр СМА-ны үйл ажиллагааг, ялангуяа түүний дүн шинжилгээ хийх, орон тоог нэмэгдүүлэх, хяналт шалгалтын чадавхийг сайжруулах чиглэлээр хийсэн ажлуудыг “хангалттай” түвшинд хүрсэн гэж үнэлсэн байна.

2013 онд санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан зайнаас болон газар дээрх хяналт шалгалтын хөтөлбөр, журам боловсруулахад ОУВС-гаас Техникийн туслалцаа авч, эн талаарх Монголбанк, Санхүүгийн мэдээллийн албаны хяналт шалгалтын чадавхийг сайжруулах ажлуудыг зохион байгууллаа.

2013 онд СМА нь 2 сая 500 мянган ширхэг 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайланг банк, банк бус санхүүгийн байгууллагуудаас хүлээн аваад байна. Тайлант онд СМА нь санхүүгийн байгууллагуудаас нийт 285 ширхэг сэжигтэй гүйлгээний тайлан мэдээг хүлээн авч мэдээллийн сандаа бүртгэсэн. Ингэснээр, СМА-нд ирүүлсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн нийт дун 601 болж байна. Дан ганц 2013 онд 258 ширхэг сэжигтэй гүйлгээний тайлан ирүүлсэн байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс даруй 2 дахин нэмэгдсэн үзүүлэлт болов.

Тайлант хугацаанд Монголбанкны СМА нь дотоодын хууль сахиулах байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн мэдээлэл солилцох үр ашигтай суваг, харилцааг бий болгож ажиллалаа. 2013 онд СМА нь Санамж бичгийн хүрээнд хамтран ажилладаг 3 хууль сахиулах байгууллагын нийт 780 орчим хувь хүн, хуулийн этгээд, нийт онуудын дүнгээр 1329 хувь хүн, хуулийн этээдийн талаарх санхүүгийн лавлагаанд шалгалт хийж, хариу өгч ажилласан.

Түүнчлэн, СМА нь өөрийн санаачлагаар дээрх 3 байгууллагад 2013 онд 10 сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг, нийт онуудын дүнгээр 199 сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг шалгуулахаар шилжүүлсэн байна.

Гэмт хэргээс олсон орлогыг илрүүлэх, сэжиглэхтэй холбоотой дэлхийн санхүүгийн мэдээллийн албадын холбоо Эгмонт бүлгийн гишүүний хувьд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны бусад орны санхүүгийн мэдээллийн албадтай санхүүгийн мэдээлэл солилцох Санамж бичиг байгуулах, тэдгээртэй үр дүнтэй хамтран ажиллах олон сувгийг үүсгэний үр дүнд Монгол Улсаас гадаад руу гарсан, эсхүл гадаад орноос Монгол Улсад орж ирсэн хууль бус мөнгөний урсгалыг олж илрүүлэх хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллав.

2013 онд Ази Номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх бүлэгт Монгол Улсыг төлөөлж Монголбанк өөрийн орны ахиц дэвшлийг тогтмол тайлагнаж хамтран ажиллалаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд заасан чиг үүргийн хүрээнд 2013 онд СМА нь санхүүгийн байгууллагуудын 229 ажилтан, албан хаагчдад зориулж дангаар 4 сургалтыг, бусад байгууллагатай хамтарч 421 хүнд 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан болно.

5.5 Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар нь Дотоод хяналт, шалгалтын хэлтэс (ДХШХ), Үйл ажиллагааны эрсдэлийн хэлтэс (ҮАЭХ) гэсэн бүтэцтэйгээр ажиллаж байна. ДХШХ нь Монголбанкны бүтцийн нэгжүүдэд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авах, үүрэг даалгавар өгөх, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг, харин ҮАЭХ нь Монголбанкны үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлийг тогтоох, хянах, урьдчилан сэргийлэх, энэ талаар баримтлах заавар, журам боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, санал боловсруулах, Монголбанкны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийлгэх чиг үүргийг тус тус хэрэгжүүлж байна.

Дотоод хяналт шалгалтын 2011-2015 оны төлөвлөгөөний хүрээнд тайлант онд газар дээрх шалгалтыг Монголбанкны бүх газар, хэлтэс, алба, орон нутаг дахь 17 хэлтэс, салбарыг бүрэн хамруулан хийж ирлээ. Зайны хяналт, газар дээрх шалгалтын дүнг улирал бүр нэгтгэн Монголбанкны Захирлуудын зөвлөл, Хяналтын зөвлөлд тайлагнаж байна.

ДХҮАЭГ-ын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг илүү боловсронгуй болгох, үйл ажиллагааны үе шат бүрт анхан шатны болон дараалсан хяналтыг тогтмол, тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бурдуулэх, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэлэг арга барил, хэлбэрээр ажиллах зэрэг ажлуудыг тодорхой төлөвлөгөөтэй, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Орон нутаг дахь хэлтэс, салбарын бэлтгэл сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг өндөржүүлэх зорилгоор тайлант онд Мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газартай хамтран гэнэтийн шалгалтыг орон нутаг дахь хоёр салбарт хийж, холбогдох шийдвэрийг гаргуулж ажиллалаа.

5.6 Бэлэн мөнгөний хангалт

Монголбанкнаас 2013 онд мөнгөн тэмдэгттэй холбоотой дараах үйл ажиллагааг эрхлэв. Аравт, хорьт, тавьтийн дэвсгэрийг Франц улсын Обертур Федюшир компани, 500-т болон 1000-тын дэвсгэртүүдийг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улсын Де Ла Руе компани, 5000-т болон 20000-тын дэвсгэртүүдийг ХБНГУ-ын Гийзеке Девриент компаниар тус тус хэвлүүлж, нөөц бүрдүүлсэн.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 842.2 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16.2 тэрбум төгрөгөөр буюу 1.9%-иар өссөн байна. Оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өмнөх онтой харьцуулахад дэвсгэрийн тоогоор 23.2 сая ширхэгээр буюу 7.9%-иар өссөн байна. Энэхүү өсөлт нь 1-т, 5-т, 10-т болон 20-тын дэвсгэртүүд өссөнтэй холбоотой байв.

Хүснэгт 12: Бэлэн мөнгөний хангалтын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31				2013 оны 12-р сарын 31			
		Үлдэгдэл-дэвсгэрт (сая төгрөг)	Хувь	Мянган ширхэг	Хувь	Үлдэгдэл-дэвсгэрт (сая ширхэг)	Хувь	Мянган ширхэг	Хувь
1	1	26	0.0%	26,437	9.0%	29	0.0%	29,264	9.3%
2	5	12	0.0%	23,481	8.0%	131	0.0%	26,237	8.3%
3	10	527	0.1%	52,729	18.0%	571	0.1%	57,064	18.1%
4	20	736	0.1%	36,804	12.6%	880	0.1%	43,999	13.9%
5	50	1676	0.2%	33,516	11.5%	1,843	0.2%	36,858	11.7%
6	100	3375	0.4%	33,753	11.5%	3,745	0.4%	37,447	11.9%
7	200	68	0.0%	338	0.1%	34	0.0%	169	0.1%
8	500	5200	0.6%	10,400	3.6%	5,661	0.7%	11,321	3.6%
9	1000	13,727	1.7%	13,727	4.7%	14,263	1.7%	14,262	4.5%
10	5000	64,394	7.8%	12,878	4.4%	53,975	6.4%	10,794	3.4%
11	10000	234,702	28.4%	23,470	8.0%	207,230	24.6%	20,723	6.6%
12	20000	501,525	60.7%	25,076	8.6%	553,908	65.8%	27,695	8.8%
		826,074	100.0%	292,615	100.0%	842,269	100.0%	315,840	100%

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 13: Банкуудаас хүлээн авсан, банкинд олгосон бэлэн мөнгөний тоо, үнийн дүн

Он	Банкинд олгосон		Банкнаас хүлээн авсан	
	Үнийн дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг	Үнийн дүн (тэрбум төгрөг)	Мянган ширхэг
2009	630.5	111,489	761.4	117,774
2010	827.9	131,954	862.5	123,713
2011	1246.4	181,258	1310.6	170,460
2012	1564.2	213,305	1663.4	198,521
2013	1601.6	216,394	1728.7	202,035
Нийт дүн	6694.0	993,650	7293.0	963,774

Эх сурвалж: Монголбанк

Тайланд онд орон нутгийн Монголбанкны салбаруудад 225.2 тэрбум төгрөгийн зузаатгал хүргүүлж, 38.5 тэрбум төгрөгийн муу мөнгөн тэмдэгтийг төвд татан авсан.

5.7 Мэдээллийн технологи

Монголбанк нь тайлант онд банк хоорондын төлбөр тооцооны болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллав.

Засгийн газрын урт болон богино хугацаат үнэт цаасны арилжааны анхдагч зах болон хоёрдогч захын арилжааг гүйцэтгэх програм хангамжийг боловсруулж, ашиглалтад орууллаа. Түүнчлэн дотоод үйл ажиллагаанд ашиглагдах шинэ програм хангамжуудыг боловсруулах, ашиглаж буй програм хангамжийн системүүдийг өргөтгөх, сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Монголбанкинд ашиглагдаж буй мэдээллийн технологийн системүүдэд тохиолдож болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэгдсэн цахим мэдээллийн системүүдийн нууцлал, аюулгүй байдал, тасралтгүй ажиллагааг хангасан болно.

5.8 Монголбанкнаас 2013 онд баталсан эрх зүйн баримт бичгүүд

№	Огноо	Дугаар	Нэр	Агуулга
1	2013.01.24	A/15	Төв банкны Бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Мөнгө, зээлийн есөлтийг тогтвортжуулах, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 0.75 нэгж хувиар бууруулж, 12.5 хувь болгов.
2	2013.01.24	24/A-9	Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам	Монголбанк, арилжааны банкинд Засгийн газрын болон төсвийн байгууллагуудын дансыг нээх, хаах, улсын төсвийн тэг Үлдэгдэлтэй данс байршуулах зөвшөөрөл олгох харилцааг журамлав.
3	2013.03.06	A-40	Төв банкны овернант хадгаламжийн журам	Банкнаас Монголбанкинд байршуулах овернант хадгаламжийн харилцааг зохицуулахаар журамлав.
4	2013.03.06	A-41	Төв банкны овернант репо санхүүжилтийн журам	Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк хоорондын захын хүүг зорилтот түвшинд хүргэх зорилгоор Монголбанкнаас банкинд олгох овернант репо санхүүжилтийн харилцааг журамлав.
5	2013.03.06	A-42	Төв банкны репо арилжааны журам	Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор банкинд репо арилжаагаар санхүүжилт олгох харилцааг журамлав.
6	2013.03.06	A-43	Төв банкны үнэт цаасны арилжааны журам	Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас үнэт цаас гарган арилжаалах үйл ажиллагааг зохицуулахаар журамлав.

7	2013.03.06	A-44	Төв банкны өдрийн зээлийн журам	Банк хоорондын төлбөр тооцооны системийн хэвийн ажиллагааг хангах зорилгоор Монголбанкнаас банкинд олгох төгрөгийн өдрийн зээлийн харилцааг зохицуулахаар журамлав.
8	2013.03.11	A-51	Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцооны журам	Төлбөрийн системд оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог “Банксүлжээ” системээр гүйцэтгэх харилцааг журамлав.
9	2013.04.02	A-6	Гадаад арилжааны үйл ажиллагаа явуулах заавар	“Гадаад валютын албан нөөцийн удирдлагын журам”, “Арилжааны багцын үйл ажиллагаанд мөрдөх журам”, “Засгийн газрын тусгай эх үүсвэрийн удирдлагын журам”-ын дагуу гадаад валютын улсын нөөцийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулах, хөрөнгө оруулалтын хэрэгслийг худалдах, худалдан авах, харилцан хөрвүүлэх зэрэг нөөцийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлон зохицуулсан.
10	2013.04.05	76/A-66	Хадгаламжийн даатгалын корпораци байгуулах тухай	Монголын Хадгаламжийн даатгалын корпорацийн хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны бүрэлдэхүүн, тус байгууллагын ажлын нэгдсэн төлөвлөгөөг баталсан.
11	2013.04.05	A-67	Төв банкны Бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 11.5 хувь болгов.
12	2013.04.19	24/A-77	Сонгуулийн зардлын данс нээх, хаах, мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулах, бүртгэл хөтлөх тайлан гаргах журам	Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо, Монголбанкнаас хамтран Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлын сангийн дансыг нээх, хаах, уг дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулах, бүртгэл хөтлөх, зардлын тайлан гаргах үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон харилцааг журамласан.
13	2013.05.07	A-84/, A/39, 540	Мэдээлэл солилцох журам	Улсын бүртгэлийн ерөнхий газраас Монгол Улсын гадаад секторын статистик нэгтгэлийг боловсруулахад зориулан Монголбанк журмын хавсралтад заасан мэдээллийг бэлтгэж өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан.
14	2013.05.17	A-101	Гадаад валютын албан нөөцийн удирдлагын журам	Гадаад валютын албан нөөцийн удирдлагын зорилго, хөрөнгө оруулалтын бодлого, эрсдэлийн удирдлагуудын зарчмууд, нөөцийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, нөөцийн удирдлагад оролцогч талуудын эрх үүргийг тодорхойлсон харилцааг журамласан.

15	2013.05.21	111/A-105/131	Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам	Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа, түүний шууд оролцогчийн үүрэг, хариуцлага, дотоод хяналт, хориглох үйл ажиллагаа, шууд оролцогч хооронд хийх арилжаа, шимтгэл, шууд бус оролцгчтой гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, дуусгавар болгох, түүнд мэдээлэл хүргэхтэй холбоотой харилцааг зохицуулан журамласан.
16	2013.05.24	A-105, 118	Хадгаламжийн даатгалын Корпорацийн дүрэм, Хадгаламжийн даатгалын Үндэсний хорооны ажиллах журам	Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны үйл ажиллагаа болон түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулан баталсан.
17	2013.05.28	A-109	Мөнгөн тэмдэгтийн мэдээллийн сангийн журам	Монголбанкаас гүйлгээнд гаргасан мөнгөн тэмдэгтийн насхилтыг тодорхойлох мэдээллийн сангийн үйл ажиллагааг зохицуулан журамласан.
18	2013.06.12	A-121 /158/360	Гүйлгээнээс илэрсэн хуурамч, мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам	Монгол улсын нутаг дэвсгэрт бэлэн мөнгөөр гүйлгээ хийж байгаа иргэн, аж ахуйн нэгж, банк, санхүүгийн байгууллагуудын гүйлгээнд хуурамч мөнгөн тэмдэгт оруулахгүй байх, гүйлгээнээс илэрсэн тохиолдолд хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох болон хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, ашиглах, борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдо байгууллага /Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Цагдаагийн ерөнхий газар/-уудын хамтын ажиллагааг зохион байгуулахаар журамласан.
19	2013.06.14	A-122	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам	Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга хот байгуулалтын сайдын 2013 оны А-2/06 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвржуулах” дэд хөтөлбөр, Засгийн газар, Монголбанкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үндэслэн орон сууцны ипотекийн санхүүжилтийн харилцааг зохицуулахаар журамласан.
20	2013.06.24	A/136	Төв банкны Бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	Эдийн засгийн бодит секторыг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 10.5 хувь болгов.
21	2013.12.13	A-236	Банкны хүү бодох аргачлал, хүү шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам	Хүү бодоход баримтлах зарчмыг тодорхойлох, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангахаар журамласан.

МОНГОЛ БАНК (Төв банк)

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2013 оны 12 дугаар сарын 31

МОНГОЛБАНК

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байна.

Монголбанкны санхүүгийн тайланг Санхүүгийн тайлagnalын олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн болно. Захирлуудын Зөвлөл нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны үйл ажиллагаа, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүн ба мөнгөн гүйлгээг энэхүү санхүүгийн тайланд үнэн зөвөөр илэрхийлэхийг баталгаажуулах үүрэгтэй.

Захирлуудын Зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв илэрхийлэх, нягтлан бодох бүртгэлийг зөв зохистой хөтөлж явуулдаг бөгөөд санхүүгийн тайлан нь Тодруулга 2-т тусгагдсан шаардлагуудад нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил, дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах нь Захирлуудын Зөвлөлийн үүрэг байdag.

Энэхүү санхүүгийн тайланг (5-91 дүгээр хуудсанд үзүүлсэн) бэлтгэхдээ зохих бодлогыг баримталж, үндэслэлтэй бөгөөд зохистой шийдэл, тооцооллыг ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн бүхий л холбогдох стандартуудыг дагаж мөрдсөн гэж Захирлуудын Зөвлөл үзэж байна.

Захирлуудын Зөвлөлийн шийдвэрийн дагуу гарын үсэг зурсан:



Н.ЗОЛЖАРГАЛ
(Монголбанкны Ерөнхийлөгч)

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2014 оны 4 дүгээр сарын 28

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОНГОЛБАНКНЫ ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛД

Бид Монголбанкны (“Банк”) 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь удирдлагын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

МОНГОЛБАНКНЫ ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛД

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагнальн олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын Төв банкны тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Захирлуудын Зөвлөлийн захиалсан аудиттай холбогдуулан Банкны Захирлуудын Зөвлөлд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид



Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2014 оны 4 дүгээр сар 28

ПЕТР МАРКИ
Захирал

МОНГОЛБАНК

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Хүүгийн орлого	3	132,717	59,349
Хүүгийн зардал	4	(255,387)	(104,773)
Хүүгийн цэвэр зардал		(122,670)	(45,424)
Алт, үнэт металлын арилжааны цэвэр ашиг/ (алдагдал)	5	(66,805)	20,753
Валютын ханшийн зөрүүний цэвэр ашиг/ (алдагдал)	6	21,278	(23,694)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн алдагдал		(14,381)	(10,267)
Үнэт цаас борлуулсны алдагдал	10	(6,529)	(453)
Үйл ажиллагааны бусад орлого	8	4,205	3,297
Үнэ цэнийн бууралтын (алдагдал)/нөөц сангийн буцаалт	7	23,508	(88,616)
Үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бусад зардал	9	(89,678)	(36,990)
Нийт алдагдал		(251,072)	(181,394)
Бусад дэлгэрэнгүй орлого			
<i>Тайлангийн дараа орлого зардалд дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн нөөц			
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз/(гарз)		425	(837)
- Борлуулах үед орлогын тайланда шилжүүлсэн		(135)	453
		290	(384)
Тайлангийн дараа орлого зардалд дахин ангилагдах цэвэр бусад дэлгэрэнгүй орлого		290	(384)
<i>Тайлангийн дараа орлого зардалд дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц		4,263	-
Тайлангийн дараа орлого зардалд дахин ангилагдахгүй цэвэр бусад дэлгэрэнгүй орлого		4,263	-
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		4,553	(384)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		(246,519)	(181,778)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө	11	63,691	28,317
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	12	1,951,095	3,272,979
Санхүүгийн хөрөнгө оруулалт- Борлуулахад бэлэн	13	953,530	142,553
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	14	1,529,215	2,123,953
Алт ба үнэт металл	15	287,169	439,669
Засгийн газрын үнэт цаас	16	-	159,210
Дотоодын банкуудад байршиулсан хөрөнгө, хадгаламж	17	405,896	-
Дотоодын банкуудад олгосон зээл	18	2,787,461	202,488
Бусад хөрөнгө	19	208,227	7,421
Үндсэн хөрөнгө	20	28,446	26,631
НИЙТ ХӨРӨНГӨ		8,214,730	6,403,221
ӨР ТӨЛБӨР			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		841,129	828,450
Гаргасан үнэт цаас	21	1,627,017	752,151
Засгийн газрын байгуулагуудын харилцах, хадгаламж	22	1,710,024	2,959,686
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	23	2,497,197	1,371,671
Гадаад өр төлбөр	24	1,774,807	576,414
Бусад өр төлбөр	25	158,707	62,481
НИЙТ ӨР ТӨЛБӨР		8,608,881	6,550,853
ДҮРМИЙН САН БА НӨӨЦ			
Дүрмийн сан	26	5,000	5,000
Хуримтлагдсан алдагдал		(424,209)	(302,685)
Бусад нөөц	27	25,058	150,053
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		(394,151)	(147,632)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		8,214,730	6,403,221

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Тодруулга	Дүрмийн сан сая төгрөг	Хуримтлагдсан алдагдал сая төгрөг	Бусад сан сая төгрөг	Нийт сая төгрөг
2012 оны 01 дүгээр сарын 01-нээр		5,000	(91,799)	120,945	34,146
Нийт дэлгэрэнгүй орлого Хуримтлагдсан ашгаас бусад нөөцөд шилжүүлсэн	27	-	(181,394) (29,492)	(384) 29,492	(181,778) -
2012 оны 12 дугаар сарын 31-нээр		5,000	(302,685)	150,053	(147,632)
Нийт дэлгэрэнгүй орлого Бусад нөөцөөс хуримтлагдсан ашигт шилжүүлсэн	27	-	(251,072) 129,548	4,553 (129,548)	(246,519) -
2013 оны 12 дугаар сарын 31-нээр		5,000	(424,209)	25,058	(394,151)

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

МОНГОЛБАНК

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Тайлант жилийн алдагдал		(251,072)	(181,394)
<i>Toхируулга :</i>			
Алтны дахин үнэлгээний бодит бус (ашиг)/алдагдал	5	23,021	(15,291)
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус (ашиг)/алдагдал	6	264,438	(14,201)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүрийн үнэлгээний бодит бус алдагдал	31	67,214	399
Засгийн газрын үнэт цаас борлуулсны гарз		6,664	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний алдагдал	9	3,618	-
Үндсэн хөрөнгө борлуулсны олз		(56)	-
Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	9	-	17,895
Данснаас хассан үндсэн хөрөнгө	9, 20	151	8
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл	9, 20	2,038	1,800
Үнэ цэнийн бууралтын сан		-	88,616
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгө		3,000	2,000
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны алдагдал		135	453
Хүүгийн орлого	3	(132,717)	(59,349)
Хүүгийн зардал	4	255,387	104,773
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		241,821	(54,291)
Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:			
Алт ба үнэт металлын (өсөлт)/бууралт		129,479	(156,293)
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн (өсөлт)/бууралт		594,738	(1,353,135)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийн бууралт		-	155
Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийн өсөлт		(405,896)	-
Дотоодын банкуудад олгосон зээлийн өсөлт		(2,566,817)	(59,614)
Засгийн газрын үнэт цаасны өсөлт		-	(1,320)
Бусад хөрөнгийн (өсөлт)/бууралт		(198,023)	523
Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Төв банкны үнэ цаасны өсөлт/(бууралт)		884,812	(138,009)
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламжийн өсөлт/(бууралт)		(1,315,175)	1,810,983
Дотоодын банкуудын харилцах, хадгаламжийн өсөлт		1,125,525	356,441
Бусад өр төлбөрийн өсөлт		13,921	297
Үйл ажиллагаанаас үүссэн/(зарцуулсан) хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		(1,495,615)	405,737

МОНГОЛБАНК

2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Тодруулга	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүлээн авсан хүү		118,384	53,406
Төлсөн хүү		(261,116)	(92,493)
Үйл ажиллагаанаас үссэн/(зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		(1,638,347)	366,650
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт	20	(3,951)	(2,574)
Үндсэн хөрөнгө борлуулалтаас хүлээн авсан		66	138
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслүүдийн худалдан авалт		(2,953,721)	(137,970)
Борлуулахад бэлэн санхүүгийн хэрэгслүүдийн борлуулалтаас хүлээн авсан		2,153,898	203,371
Засгийн газрын үнэт цаасны борлуулалт болон эргэн төлөлтөөс хүлээн авсан		149,931	-
Хөрөнгө оруулалтаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		(653,777)	62,965
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өсөлт		12,679	115,099
Гадаад өр төлбөрийн эргэн төлөлт		(222,920)	-
Гадаад өр төлбөрийн татан авалт		1,235,512	471,002
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		1,025,271	586,101
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(19,808)	(3,350)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		(1,286,661)	1,012,366
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,300,601	2,288,235
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11	2,013,940	3,300,601

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь Монгол Улсын Төв Банк (цаашид Банк гэх) бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Төв банкны тухай хууль болон бусад хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг. Банк нь 1924 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан ба байршил нь: Монгол Улс, Улаанбаатар - 46, Бага тойруу 3, 15160.

Банк нь бүхий л үйл ажиллагаагаа Монгол Улсад явуулдаг ба орон нутагт нийт 17 хэлтэс, салбар болон Англи Улсын Лондон хотод төлөөлөгчийн газартай.

Төв Банкны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулах ба санхүүгийн зах зээл, банкны системийн тогтвортой байдлыг хангах замаар тэнцвэртэй, тогтвортой үндэсний эдийн засгийн хөгжлийг дэмжих явдал юм.

Банк нь ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болоод хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Төв банкны тухай хуулийн дагуу Банк нь дараах үндсэн үйл ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

- ◆ Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, зохицуулах;
- ◆ Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- ◆ Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх (“Засгийн газар” эсвэл ”Төрийн”);
- ◆ Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- ◆ Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- ◆ Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, зохицуулах;
- ◆ Бусад банкуудын хувьд үндсэн зээлдүүлэгч байх замаар дахин санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;
- ◆ Бусад орны Төв банкууд, олон улсын банкууд, бусад хамтран ажилладаг хуулийн байгууллагуудын өмнө Монгол улсыг төлөөлж ажиллах;
- ◆ Хуулинд заасны дагуу бусад санхүүгийн болон зээлийн үйл ажиллагааг явуулах.

Хуульд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нь дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах ба худалдан авах, гадаад валют, үнэт металл худалдах болон худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт металл болон энгийн металлаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагуудын дансыг Банкинд байршуулах, олон улсын байгууллагуудын дансыг байршуулан шаардлагатай тохиолдолд дэмжин ажиллах үүрэгтэй болно.

Монголбанкны дүрмийн санг Монгол улсын төр бүрэн эзэмшдэг.

Банкны 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг Захирлуудын Зөвлөлийн 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрээр зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх “Барилга байгууламж”, “Борлуулахад бэлэн” хөрөнгө оруулалтыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өргтийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дунгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд саятын орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

Нийцлийн мэдэгдэл

Банкны санхүүгийн тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэдэг.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас дээш хугацаанд (урт хугацаанд) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 32-д толилуулсан болно.

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбардаар шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулсанчлан орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнахгүй.

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БОЛОН ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорхи СТОУС-уудаас бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил юм.

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд ба тайлбарууд

- СТОУС 1, *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг Аих удаа хэрэгжүүлэх (Нэмэлт өөрчлөлт)* – Засгийн газрын зээл – СТОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлтүүд
- СТОУС 7, *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулгууд – Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэршиүүлэн тайлганах – СТОУС 7-д орсон нэмэлт өөрчлөлтүүд*
- СТОУС 10, *Нэгтгэсэн санхүүгийн тайлан, НББОУС 27 Тусдаа санхүүгийн тайлан*

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БА ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (Үргэлжлэл)

Шинэ болон өөрчлөгдсөн стандартууд ба тайлбариуд (Үргэлжлэл)

- СТОУС 11, *Хамтарсан хэлцэл, НББОУС 28 Хараат компани дахь хөрөнгө оруулалт*
- СТОУС 12, *Бусад аж ахуйн нэгжүүд дэх хувь оролцооны тодруулга*
- СТОУС 13, *Бодит үнэ цэнийн хэмжилт*
- НББОУС 19, *Ажиллагсдын тэтгэвэр тэтгэмж (2011 онд хянан засварласан)*
- НББОУС 27, *Тусдаа санхүүгийн тайлан (2011 онд хянан засварласан)*
- НББОУС28, *Хараат болон хамтарсан компани дахь хөрөнгө оруулалт (2011 онд хянан засварласан)*

Доор үзүүлснээс бусдаар дээрх стандартууд болон тайлбариудыг дагаж мөрдсөнөөр Банкны бүртгэлийн бодлогод томоохон өөрчлөлт ороогүй ба санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлээгүй болно.

Бодит үнэ цэнийн хэмжилтүүдийн талаарх зааварчилгааг зөвхөн СТОУС 13 хангаж өгдөг. СТОУС 13 нь байгууллага хэзээ бодит үнэ цэнийг хэрэглэх шаардлагатай вэ гэдгийг өөрчлөөгүй боловч бодит үнэ цэнийг хэрэглэх шаардлагатай эсвэл зөвшөөрөгдсөн үед СТОУС-ын дагуу бодит үнэ цэнийг яаж хэмжих талаар зааварчилгааг зөвхөн хангаж өгсөн. Банкны санхүүгийн тайлангуудад үзүүлэх СТОУС 13-ын нөлөө том биш хэдий ч бодит үнэ цэнийн хэмжилт (гараах үнээр нь хэмжих)-нд хэрэглэх өгөгдөл ба үнэлгээний техникийдийн талаарх нэмэлт шинэ тодруулгуудыг ирээдүйд хийх шаардлагатай болно. СТОУС 13-ын дагуу хийх шаардлагатай шинэ тодруулгыг энэхүү санхүүгийн тайлангуудын Тодруулга 31-аас харна уу.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг гаргах өдрийн байдаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

- СТОУС 9, *Санхүүгийн хэрэглүүрүүд³*
- СТОУС 9, СТОУС 7, НББОУС 39(Нэмэлт өөрчлөлт), *Хейджийн бүртгэл болон СТОУС 9, СТОУС 7, НББОУС 39³-д орсон нэмэлт өөрчлөлтүүд*
- СТОУС 10, СТОУС 12, НББОУС 27 (2011), *СТОУС 10, СТОУС 12, НББОУС 27 (2011)- Охин компани дахь хөрөнгө оруулалтын бүртгэл¹*
- НББОУС 19 Нэмэлт өөрчлөлтүүд, *НББОУС 19 Ажиллагсдын тэтгэвэр тэтгэмжид оруулсан нэмэлт өөрчлөлтүүд – Ажиллагсдын тэтгэмжийн төлөвлөгөө: Ажиллагсдын оруулсан хувь нэмэр²*

2.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БА ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (Үргэлжлэл)

- НББОУС 32 Нэмэлт өөрчлөлтүүд, *НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүрт орсон нэмэлт өөрчлөлтүүд: Толилуулга - Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг цэвэршигүүлэх*¹
- НББОУС 39 Нэмэлт өөрчлөлтүүд, *НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт – Санхүүгийн үүсмэл хэрэгсэл шилжүүлэх болон Хейджийн нягтлан бодох бүртгэл*²
- СТОУТХ 21, *Суутгалууд*³
- Сайжруулалт, 2010-2012 он болон 2011-2013 он, *2013 оны 12 сард гаргасан СТОУС-д оруулсан өөрчлөлтүүд*⁴

¹ 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно

² 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно

³ Хүчин төгөлдөр болох хугацааг тодорхой заагаагүй боловч хэрэгжүүлэх боломжтой

⁴ Эдгээр сайжруулалтыг 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох боловч үүнээс өмнө хэрэгжүүлэх боломжтой

Одоогоор Банк нь энэхүү стандарт болон тайлбарын жагсаалтыг ирээдүйд дагаж мөрдөх нь Банкны тодруулга, санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд нөлөө үзүүлэх эсэхийг үнэлж байна.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО

Гадаадын валютын хөрвүүлэг

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох Монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Банк нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг өдөр бүр дахин үнэлэх бодлого барьдаг. Хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланда хүлээн зөвшөөрнө. Дээрх хөрвүүлгээс үүссэн бодит бус ашиг, алдагдлыг жил бүр “Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн сан” дансанд шилжүүлж эсвэл тус данснаас нөхнө.

Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

Мөнгөөр илэрхийлэгдэх гадаад валютын тэнцлийн үлдэгдлийг төгрөгт хөрвүүлэхэд ашигласан албан ханшийг дор харуулав:

	2013.12.31 байдлаар	2012.12.31 байдлаар
	төгрөг	төгрөг
Ам. доллар	1,654.10	1,392.10
ЗТЭ	2,555.93	2,145.90
Евро	2,275.63	1,835.83
Юань	272.88	223.39

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрүүд - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Банк тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдаад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх санхүүгийн үүсмэл хэрэглүүрүүд

Зах зээлийн эрсдэлүүдийг удирдахын тулд Банк валютын форвард болон своп гэрээ хэлцлүүд гэсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашигладаг. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг “Санхүүгийн хэрэгслийн олз/гарз” дансанд бүртгэдэг.

Санхүүгийн хэрэглүүрүүдэд агуулагдсан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг салгаж авч үзэх ёстой ба тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүд нь агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдэлүүдтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг худалдах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилаагүй тохиолдолд тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь дэлгэрэнгүй орлогын тайланда хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(iii) Худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр

“Худалдах зорилгоор эзэмшиж буй” санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Хүүгийн болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь “Арилжааны цэвэр орлого” дансанд бүртгэнэ.

2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд худалдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр байгаагүй.

(iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр

Энэ бүлгийн санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь удирдлага анх хүлээн зөвшөөрөхдөө энэ бүлэгт оруулахаар шийдвэрлэсэн санхүүгийн хэрэгслүүд байна. Дараах нөхцлүүд хангагдсан үед санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө энэ ангилалд оруулахаар шийдвэрлэж болох ба шийдвэрийг хэрэгсэл нэг бүр дээр гаргана. Үүнд:

- ◆ Энэхүү шийдвэр нь хөрөнгө, өр төлбөрийг хэмжих эсвэл хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх олз гарзыг ялгаатай сууриар орлого, зардалд хүлээн зөвшөөрснөөс бий болох тууштай бус байдлыг арилгах эсвэл дорвitoйгоор бууруулахаар байвал;
- ◆ Эдгээр санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн бүлгийн нэг хэсэг эсвэл аль аль нь бөгөөд тэдгээрийг хучин төгөлдөр эрсдэлийн удирдлагын бодлого эсвэл хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдаж, гүйцэтгэлийг нь бодит үнэ дээр нь суурилан хэмждэг байх;
- ◆ Гэрээнд зааснаас бусад тохиолдолд мөнгөн урсгалыг ихээхэн хэмжээгээр өөрчлөх нэг эсвэл түүнээс олон тооны санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг санхүү хэрэгсэл нь агуулж байвал.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ. Олсон хүүгийн орлогыг “Хүүгийн орлого” дансанд, гарсан хүүгийн зардлыг “Хүүгийн зардал” дансанд гэрээний нөхцлийн дагуу хуримтуулж бүртгэх ба ногдол ашгийн орлогыг төлбөрийн эрх үүссэн үед нь дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэг санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр байгаагүй.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(v) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтанд өөрийн хөрөнгийн ба өрийн үнэт цааснууд багтана. “Худалдах зорилгоор эзэмшиж буй” ба “бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэсэн ангилалд ороогүй өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг “Борлуулахад бэлэн” гэж ангилна. Тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас борлуулж болох өрийн үнэт цаасууд энэ ангилалд орно.

Банк нь аливаа зээл, авлагуудыг “Борлуулахад бэлэн“ санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Анхны хэмжилтийн дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Бодит бус ашиг ба алдагдлыг өөрийн хөрөнгийн (бусад дэлгэрэнгүй орлого) “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өөрийн хөрөнгөд өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдал дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэнэ. Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг “эхэлж авснаа эхэлж зарлагада” зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогоор бүртгэнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Энэхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц”-с хасна.

(vi) Дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтоосон хугацаатай, Банк дуусах хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай, үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Дуусах хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт” гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн арга ашиглаж тооцсон хорогдуулсан өргөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өргтийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн “Хүүгийн орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(vi) Дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Хэрэв Банк бага биш дүнтэй “дуусах хугацаа хүртэл эзэмших” хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас нь өмнө худалдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь “борлуулахад бэлэн” бүлэгт дахин ангилана. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд “дуусах хугацаа хүртэл эзэмших” бүлгээс аливаа нэг санхүүгийн хөрөнгийг дахин ангилахыг хориглодог.

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд дуусах хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт байгаагүй.

(vii) Зээл болон урьдчилгаа

“Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж” ба “Дотоодын банкуудад олгосон зээл” дансанд идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөртэй дараах үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад нь багтана. Үүнд:

- ◆ Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- ◆ Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд;
- ◆ Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэглүүрүүд.

Анх хэмжсэний дараа “Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж” ба “Дотоодын банкуудад олгосон зээл”-ийг үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн “Хүүгийн орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайланд “Үнэ цэнийн бууралтын алдагдал” дансанд хүлээн зөвшөөрнө.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(viii) Зээл болон зээллэг

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгддэггүй, банкны гаргасан санхүүгийн хэрэглүүрүүд зээл болон зээллэг дотор өр төлбөр гэж ангилагддаг. Энэхүү дансанд 'Төв банкны үнэт цаас', 'Гадаад өр төлбөр', 'Засгийн газрын байгуулагуудын харилцах, хадгаламж', болон 'Дотоодын банкуудын харилцах, хадгаламж' багтана. Гэрээт зохицуулалтын агуулга нь бэлэн мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгийг эзэмшигчид шилжүүлэх үүргийг Банкинд үүсгэх эсвэл тогтсон дүнтэй бэлэн мөнгө эсвэл өөр бусад санхүүгийн хөрөнгөөр тогтсон тооны өөрийн хөрөнгийн хувьцааг солихоос өөр аргаар өр төлбөрийг барагдуулахад хүргэнэ. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг зэрэг агуулж байгаа нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг анх гаргасан өдөр нь салгаж бүртгэнэ. Энэ хэрэглүүрээс орох цэвэр орлогын нэг хэсгийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт түүний бодит үнэ цэнэ (төсөөтэй өөр бусад хэрэглүүрүүдийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэ дээр үндэслэн голдуу тодорхойлдог) дээр нь үндэслэн гаргасан өдөр хуваарилна. Тухайн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн нийт дүнгээс өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт тусад нь тодорхойлсон дүнг хасаад үлдсэн дүнг өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэгт оногдуулна. Өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгээс өөр, нийлмэл санхүүгийн хэрэглүүрт агуулагдаж буй үүсмэл шинж чанартай (худалдан авах опцион гэх мэт) аливаа нэг бүрэлдэхүүнийг өр төлбөрийн бүрэлдэхүүн хэсэгт оруулна.

Анх хэмжсэний дараа, зээл болон зээллэгүүд дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжигдэнэ. Хорогдуулсан өртгийг тооцоходоо зээл авах үсийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

(ix) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгө дээр өмнө нь хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд бүртгэсэн аливаа нэг олз гарзыг хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулж, орлого, зардлын дансанд бүртгэнэ. Хорогдуулсан шинэ үнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хоорондох аливаа нэг зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүгийн аргаар хорогдуулна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж тодорхойлబол өмнөх хугацаанд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн дүнг дэлгэрэнгүй орлогын тайланруу шилжүүлэн бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл, авлагын тодорхойлолтод нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусах хугацаа хүртэл нь эзэмших хандлага ба чадвартай байгаа бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг “Худалдах зорилгоор эзэмшиж буй” гэсэн ангиллаас “Зээл ба авлага” гэсэн ангилалд дахин ангилж болно.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(ix) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал (Үргэлжлэл)

Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан ба орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоогоор тооцсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоогоор тооцсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүгийн түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэглүүр тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэглүүрийг “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” бүлэгт дахин ангилаагүй.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- ◆ Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- ◆ Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
 - ◆ Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
 - ◆ Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнхи эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө.

Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('repo')-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнхи эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгө болон хуримтлагдсан хүүг Буцаан худалдан авах гэрээгээр тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүгийн зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Харин хөрөнгө хүлээн авагч нь тус хөрөнгийг борлуулах эсвэл барьцаанд тавих эрхтэй үед тус хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд 'Барьцаанд тавьсан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө' эсвэл 'Барьцаанд тавьсан борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт' гэж санхүүгийн байдлын тайланд дахин ангилна.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл ('урвуу repo')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд "Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа" гэж тусгана. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг "Хүүгийн орлого" гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхитэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон дилерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ) -н дээр үндэслэнэ.

Идэвхитэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээ нь байдаг ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулсан арга, опционы үнэлгээний загвар, зээлийн загвар болон бусад тохиромжтой аргууд багтана.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн тодорхойлолт (Үргэлжлэл)

Зах зээлийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл зах зээлийн мэдээлэл нээлттэй биш үед үнэлгээний аргуудыг ашиглан тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Тэдгээрийн бодит үнэ цэнийг тодорхойлоходо бодит зах зээлийн гүйлгээний дүн болон үнийг тооцож үүнээс банк хамгийн тохиромжтой үнэлгээний загварыг ашигладаг. Бодит үнэ цэнийг тодорхойлоход (форвард үнэлгээний загварт ашиглах хямдруулалтын хүүг тодорхойлох гэх мэт) заримдаа үнэлэмж шаардагддаг. Түүнчлэн санхүүгийн хэрэгслийг анх бүртгэхдээ ашиг алдагдлыг хойшлуулах бөгөөд орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл хэрэглүүрийг дахин хүлээн зөвшөөрөх үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон хэрхэн хэмжсэн талаар бусад шаардлагатай мэдээллийг Тодруулга 31-д үзүүлэв.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоогоор тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (банкууд дахь харилцах, харилцагч нарт олгосон зээл, урьдчилгаа, дусах хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт)-ийн хувьд Банк эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ. Хэрэв Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрно. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүгийн орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг “Хүүгийн орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдхөн ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсч эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл бусаддэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг багцын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн банкны дотооддоо хэрэглэдэг зээллэгийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ.

Үнэ цэнийн бууралтыг нь бүлгээр нь үнэлсэн бүлэг санхүүгийн хөрөнгийн ирээдүйн мөнгөн урсгалыг тухайн бүлэг дэх хөрөнгүүдийн зээлийн эрсдэлийн шинж чанар, түүхэн алдагдал дээр үндэслэн ойролцоолон тооцоолдог. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүдиэс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Өрийн хэрэглүүрүүдийг борлуулахад бэлэн гэж ангилсан тохиолдолд хорогдуулсан өргөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгүүдтэй адил шалгуураар Банк тэдгээрт үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг ганцаарчлан үнэлдэг. Гэсэн хэдий ч, үнэ цэнийн бууралтаар бүртгэх дун нь хуримтлагдсан алдагдал (хорогдуулсан өртөг болон өнөөгийн бодит үнэ цэнийн зөрүүнээс тухайн хөрөнгө оруулалттай холбоотой дэлгэрэнгүй орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрч байсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжих) байна. Ирээдүйн хүүгийн орлого нь бууруулсан бүртгэлийн үнэ дээр суурилах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүгийн орлогыг бусад дэлгэрэнгүй орлогод “Хүүгийн орлого”-ын хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өсвөл үнэ цэнийн бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан буцаана.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өргөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байвал бодит нотолгоонд багтана.

Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнэ цэнийн өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулдаг.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

“Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал

Ажил гүйлгээний үнэ нь ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн зах зээлийн ажил гүйлгээний бодит үнэ цэнэсээ ялгаатай эсвэл нээлттэй зах зээлийн мэдээллийн үнэлгээний аргад суурилсан байвал Банк бодит үнэ цэнэ, ажил гүйлгээний зөрүүг түргэн хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө (Эхний өдрийн ашиг ба алдагдал). Илэрхий нээлттэй мэдээлэлд суурилаагүй бол ажил гүйлгээний үнэ болон үнэлгээний загварын зөрүүг орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөх үед бодит үнэ цэнийг дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрөх.

Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой болсон бөгөөд түүнийг найдвартай хэмжиж болохуйц үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

(i) Хүүгийн орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүгийн санхүүгийн хөрөнгө, “Бодит үнэ цэнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ.

Тооцоололд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэглүүрт шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүгийн салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккруэл сууриар дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг үнэ цэнийн бууралтад орсон бүртгэлийн дунд хэрэглэсэн анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

(ii) Шимтгэлийн орлого

Банкны шимтгэлийн орлого нь ихэвчлэн банк хоорондын төлбөр тооцоо, гадаад банкуудын төлбөр тооцооны шимтгэлээс бүрддэг. Хураамж ба шимтгэлийн орлогыг ихэвчлэн үйлчилгээ үзүүлсэн хугацаанд нь аккруэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Гадаад болон дотоод хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлийг багтаадаг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд богино хугацааны мэдэгдлээр зарцуулж болох хугацаагүй болон гурван сараас бага хугацаатай санхүүгийн хөрөнгө орох ба үүнийг Тодруулга 11-ээс харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийснээс эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулаагүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хямдруулсан өртгөөр бүртгэнэ.

Алт ба үнэт металл

Олон улсын стандартын дагуу алт болон үнэт металлыг гадаадын банкинд алтан болон мөнгөн гулдмай хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь олон улсын нөөцийн нэгээхэн хэсгийг илэрхийлнэ. Эдгээр металлууд нь трой унцаар хэмжигдэн бүртгэгдэх ба Банкны албан ханшаар үнэлэгдэн төгрөгөөр илэрхийлэгднэ. Алтны арилжааны албан ханшийг Лондонгийн Алтны Захын Холбоноос зарласан үнэт металлын ам, долларын ханшид тулгуурлан, Банкны зарласан төгрөг-ам. долларын харьцах ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлдэг. Банк нь алтыг ийм байдлаар эзэмшихээс гадна Монгол дахь үйлдвэрлэгч, аж ахуй нэгжүүдээс цэвэршүүлэгүй алтыг худалдан авч, цэвэршүүлсний дараа гадаад зах зээлд худалдаг. (Тодруулга 15-с харна уу).

Алт ба мөнгийг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд тусгах бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алтны зах зээлийн үнийг харгалzan үздэг. Дахин үнэлгээний олз гарзыг орлогын тайланд хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бодит бус ашиг алдагдлыг жилийн эцэст хуримтлагдсан ашгаас өөрийн хөрөнгө дэх бусад нөөцийн “Үнэт металлын үнэлгээний нөөц” -рүү хаана.

Бусад үнэт металлыг (мөнгөжөөгүй алт ба мөнгө, зоос, соёлын үнэт зүйлс гэх мэт) бараа материалаар хүлээн зөвшөөрч, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Үндсэн хөрөнгө

Барилгыг дор дурьдсанчлан дахин үнэлэгдсэн өртгөөс хуrimтлагдсан элэгдлийг, мөн шаардлагатай бол үнэ цэнэ бууралтын зардлыг хассан дүнгээр тусгадаг.

Банк эзэмшиж буй барилгыг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Барилга байгууламжийн дансны үнэ нь бодит үнээс материаллаг зөрүүтэй эсэхийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлнэ. Дансын үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлогыг болон өөрийн хөрөнгийн дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгөөс өмнө нь үүссэн дахин үнэлгээний илүүдлийг хааж буй дахин үнэлгээний бууралтыг өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрөх ба өөрбусад бүх бууралтыг тайлант жилийн орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүн бодитоор хэрэгжих үед барилга байгууламжийн дахин үнэлгээний илүүдлээр өөрийн хөрөнгө дэх хуrimтлагдсан алдагдлыг шууд бууруулна.

Тоног төхөөрөмжийг өртгөөр нь анх бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дунд нэмж эсвэл тусдаа хөрөнгө болгох хоёрын аль тохиромжтой гэж үзсэнээр нь хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоогоор тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

	Ашиглалтын хугацаа
Барилга	25-60 жил
Тавилга, тоног төхөөрөмж	8-10 жил
Компьютер, техник хэрэгсэл	5-10 жил
Тээврийн хэрэгсэл	6-8 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүдиэс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалтаас ирээдүйд эдийн засгийн үр өгөөж орж ирэхгүй гэж үзсэн үед бүртгэлээс хасна. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг ба тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хэрэглэгдээгүй хэсгээр өөрийн хөрөнгө дэх хуrimtлагдсан алдагдлыг шууд бууруулна.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерийн программ хангамж, лиценз орно. Зөвхөн биет бус хөрөнгийн өргийг зохицтойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь олж авсан биет бус хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэнэ. Дараагийн удаад биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдол болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгана.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бodoх бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өргийг дараах ойролцогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь 3 жил хорогдуулна

Орлогын албан татвар

Монгол Улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвараас чөлөөлөгддөг.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн үргалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлоходоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)

Өмнө нь дахин үнэлэгдэж байсан ба дахин үнэлгээний зөрүүг нь бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч байсан хөрөнгүүд (энэ тохиолдолд өмнөх аливаа нэг үнэлгээний дүн хүртэлх хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлогод мөн хүлээн зөвшөөрнө)-ээс бусад хөрөнгүүдийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Тийм тохиолдолд, хөрөнгийн дансны үнийг нөхөгдөх дүн хүртэл өсгөдөг. Өмнөх жилүүдэд тухайн хөрөнгө дээр үнэ цэнэ бууралтын алдагдал хүлээн зөвшөөрөгүй байсан бол тодорхойлж болох байсан бүртгэлийн дунгээс (элэгдлийг хассан) энэ өссөн дүн илүү гарч болохгүй. Ийм буцаалтын дараа хөрөнгийн бүртгэлийн шинэ дүнг (uldэх үнэ цэнийг хассаны дараах) хөрөнгийн ашиглалтын үлдэх хугацааны туршид системтэйгээр хуваарилах үүднээс элэгдлийн дүнг ирээдүйн тайланд хугацаануудад тохируулдаг.

Ажиллагдсын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалzan олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайландаа зардлаар хүлээн зөвшөөрнө.

Сангүүд

Банкнд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа, энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг дэлгэрэнгүй орлогын тайландаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

2.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (Үргэлжлэл)

Дүрмийн сан

Дүрмийн сан нь эзэмшигчдийн хөрөнгө гэж ангилагддаг. Тодруулга 26-аас харна уу.

Бусад сангүүд

Бусад санд бодит бус ханшийн олз/гарз, мөнгөжсөн алт болон үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарз, нөөцийн дахин үнэлгээ (барилга байгууламжтай холбоотой) болон борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын санг оруулдаг. Тодруулга 27-оос харна уу. Банк өөрсдийн бодлогынхoo дагуу орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн бодит бус ханшийн олз, гарз болон мөнгөжсөн алт, үнэт металлын (мөнгө) дахин үнэлгээний олз/гарзыг бусад санд жил бүрийн эцэст шилжүүлдэг.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг. Хамгийн том үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг дор үзүүлэв. Үүнд:

Сангийн яамнаас авсан зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлт болон дотоодын банкинд олгосон зээлийн анхны бүртгэл

Банк 31,612 сая төгрөг (2012: 26,261 сая төгрөг)-ийн Сангийн яамнаас авсан зээлтэй. Үүнээс 24,064 сая төгрөг (2012: 20,433 сая төгрөг)-ийн эх үүсвэр нь Германы Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт буюу Сангийн яаманд олгосон бүс нутгийн хөгжлийг дэмжих Азийн Хөгжлийн Банк болон Германы Засгийн газрын санхүүжилт юм. Энэхүү санхүүжилт нь жилийн 0.75 хувиас 1 хувь хүртэл маш бага хүйтэй, эдийн засгийн зорилтот салбар эсвэл бусад тодорхой зорилгоор бага хүйтэйгээр олгогдох нөхцөлтэй болно. Удирдлага ийм төрлийн хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрхөд олз үүсэх эсэх талаар нягталж үзсэн. Энэхүү санхүүжилт нь бүс нутаг болоод нийгмийн хөгжилд зориулагдсан учир энэхүү хөрөнгө нь ямар нэгэн ашиг олох зорилгоор нийтэд олгогдох ёсгүй хэмээн дүгнэжээ. Мөн түүнчлэн, эдгээр байгууллагуудаас Монголын банкуудад харьцангуй бага хүйтэй санхүүжилт олгосон. Тиймээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн олзыг бүртгээгүй болно.

Ийм төрлийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр Банк нь бусад шаардлага хангасан банкуудад харьцангуй бага хүйтэй зээлийг олгох боломжтой болсон. Удирдлага ийм төрлийн хэрэгслүүдээс анхлан хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгэх эсэхийг нягталж үзсэн бөгөөд ажил гүйлгээг холбоотой бус талуудтай зах зээлийн хүүгээр хийж байгаа тул гарз бүртгэхгүй байх нь зөв гэж үзсэн. Дээрх дүгнэлтийг хийхдээ удирдлага эдгээр хэрэглүүрүүдийг салангид зах зээлийн хэсэг гэж тооцсон.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (Үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникуудийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй байгаа тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээний талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 31-д толилуулсан болно.

Анод банкинд олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

Банк Анод банкинд олгосон зээлийн үнэ цэнийн бууралтыг үнэлэхээр тогтмол хяналт тавьдаг. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг тогтоохдоо ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахуйц аливаа мэдээлэл байгаа эсэхийг нягталж үздэг. Банкны удирдлага энэхүү зээлийг Сангийн яамны гаргасан Засгийн газрын бондоор Монгол улсын Засгийн газар барагдуулна хэмээж үзэж байсан. Энэхүү санхүүгийн тайлангуудын өдрөөр, Монгол Улсын Их Хурал Засгийн газрын бонд гаргах шийдвэрийг батлаагүй байна. Энэхүү бонд гаргалтын талаарх тодорхойгүй байдлын улмаас Банк нь Анод банкны зээлд 100 хувийн алдагдлын сан байгуулаад байна.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Мөн Банк нь бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байгаа, борлуулахад бэлэн өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтууд дээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэдэг. “Их хэмжээ”, “Урт хугацаа” гэдгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Энэ үнэлэмжийг хийхдээ Банк нь хувьцааны үнийн өөрчлөлтийн түүх, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө ямар хугацаанд, ямар хэмжээгээр доогуур байсан зэрэг олон хүчин зүйлийг үнэлж үзнэ.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (Үргэлжлэл)

Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийн анхны хүлээн зөвшөөрөлт

Тодруулга 18-д толилуулсны дагуу Банк нь 2012 оны 11 дүгээр сараас эхлэн төгрөгийн зээлийг дотоодын банкуудад Засгийн газрын үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн нэг хэсэг болох шатахуун болон хүнсний секторт үйл ажиллагаа явуулдаг дотоодын аж ахуйн нэгжүүдэд дамжуулан зээлдүүлэхээр олгосон. Эдгээр зээлийн нөхцөл, төлбөрийн хугацааг Засгийн газрын хамтарсан тушаалын дагуу тодорхойлсон ба Банк бие даан зээлийн нөхцлийг тодорхойлохгүй. Түүнчлэн оролцох аж ахуйн нэгж, байгууллагуудыг Засгийн газар сонгодог ба сонгондсон байгууллагууд нь Банкнаас дахин санхүүжүүлсэн зээлийг аль ч дотоодын банкаар дамжуулан авч болно.

Засгийн газрын удирдамжийн дагуу банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 0.5 хувиас 4 хувийн хооронд байна.

Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлүүд нь тусгай зорилгоор, тодорхойлсон эдийн засгийн салбаруудыг чиглэсэн тул анхны хүлээн зөвшөөрөлтийн гарз бүртгээгүй байна.

Эрх хүлээн авагч томилогдсон банкуудад тавих хяналт

Банк Эрх хүлээн авагч томилсон банкуудад хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлоходоо Банк болон тухайн банкуудын хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалzan үзсэн:

- ◆ Банк нь хуулийн шаардлагын дагуу Эрх хүлээн авагч томилсон;
- ◆ Эрх хүлээн авагч нь зөвхөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн байр сууринласаас хандаж банкийг татан буулгах тодорхой зорилготой ба тухайн банкны ямар нэгэн стратегийн шийдвэрийг гаргадаггүй;
- ◆ Эрх хүлээн авагч нь хуулиар тодорхойлсон хүрээнд ажиллах ба өр барагдуулах дарааллыг мөн хуулиар тодорхойлсон. Иймд, Эрх хүлээн авагч нь Банкны үр өгөөжид нөлөөлөх зорилгоор тодорхой шийдвэр гаргах эрхгүй болно;

Хэдийгээр Банк Эрх хүлээн авагчийн хүрээнд банкуудад зээл олгож болох боловч энэхүү зээлийг хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийг эргүүлэн төлөх баталгааны хуулийн дагуу Засгийн газрын үүргийг биелүүлэхийн тулд Засгийн газрын нэрийн өмнөөс олгох болно. Ийм учраас эдгээр зээлийн авлагын үр өгөөж нь Засгийн газрын бондын хэлбэртэй байна гэж Удирдлага үзэж байна.

- ◆ Үүнээс гадна Эрх хүлээн авагчаас хүлээн авсан үр өгөөж нь өөрчлөлт багатай байна.

Дээрх зүйлүүд дээр үндэслэн Банк нь хэдийгээр эрх хүлээн авсан банкнуудын үйл ажиллагааг удирдах эрхтэй боловч өөрийн эрхээ үр ашигт нөлөөлөх зорилгоор ашиглаж болохгүй ба тэдгээр үр ашиг нь эрх хүлээн авсан банкны гүйцэтгэлээс хамаардаггүй болно. Иймд удирдлага эдгээр банкуудыг санхүүгийн тайланд нэгтгэх шаардлагагүй гэж үзэж байна.

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (Үргэлжлэл)

Хадгаламжийн Даатгалын Корпораци (ХДК)-д тавих хяналт

Банк Хадгаламжийн Даатгалын Корпораци (ХДК)-д хяналт тавьж байгаа эсэх болон улмаар Банкны санхүүгийн тайланд нэгтгэгдэх хэрэгтэй эсэхийг тодорхойлохдоо Банк болон ХДК-ийн хоорондын харилцааны бодит байдлын талаар үнэлэлт хийсэн. Уг үнэлэлтийг хийхдээ дараах байдлыг харгалzan үзсэн. Үүнд:

- ХДК дахь эрх мэдэл,
- ХДК-ийн үйл ажиллагаан дахь оролцоноос өгөөж хүртэх нөхцөл байдал болон эрх,
- ХДК дахь өөрийн эрх мэдлээ ашиглан Банкны хүртэх ашгийн хэмжээнд нөлөөлөх чадвар.

Банк ХДК-ийн үйл ажиллагаанд шууд оролцож чаддаг бол Банк ХДК-д эрх мэдэлтэй гэж үзнэ. ХДК-ийн дүрмийн дагуу, Үндэсний хороо нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Үндэсний хорооны гишүүн бөгөөд дарга нь байна. Үндэсний хорооны бусад зургаан гишүүд нь:

- Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- Корпорацийн гүйцэтгэх захирал;
- Гурван гишүүн нь Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголын банкны холбооны Ерөнхийлөгч нарын хамтарсан тушаалаар томилогддог.

Корпорацитай холбоотой бүх шийдвэр нь Үндэсний хорооны долоон гишүүдийн саналаар батлагдах ба аль нэг гишүүн нь ХДК-ийн үйл ажиллагааг удирдах давамгайлсан эрхгүй байна. Монголбанкны тэргүүн дэд Ерөнхийлөгч нь Үндэсний хороог даргалах боловч ХДК-ийн үйл ажиллагааг удирдах явцуу эрхгүй бөгөөд Банк нь бусад гурван гишүүдийг томилох хязгаарлагдмал эрхтэй байгаа нь ХДК-д эрх мэдэлгүй гэдгийг илэрхийлж байна. Иймд Удирдлага ХДК-ийг санхүүгийн тайландаа нэгтгэх шаардлагагүй гэж үзсэн.

Тасралтгүй байх зарчим

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн ба 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкны өөрийн хөрөнгө сөрөг гарсан. Банк нь үндэсний мөнгөн тэмдэгт гаргагч тул төгрөгийн хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж үзээд ирээдүйд (урьдчилан харж болох) тасралтгүй байх зарчмаас шалтгаалан Банк үйл ажиллагаа үргэжлүүлэхгүй байх эрсдэл гарагчгүй гэдэгт Удирдлага итгэлтэй байна..

2.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТОМООХОН ҮНЭЛЭЛТ БА ТООЦООЛЛУУД (Үргэлжлэл)

Барилгын дахин үнэлгээ

Банк нь барилгаа бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгддөг бодит үнэ цэнийн өөрчлөлттэй дахин үнэлсэн дүнгээр хэмждэг. Банк нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх бодит үнэ цэнээ үнэлүүлэхээр хараат бус үнэлгээний мэргэжилтэнтэй гэрээ байгуулсан. Харьцуулагдах үнийг ашиглан барилгуудыг зах зээлийн сууриар үнэлсэн.

Барилгуудыг тухайн хөрөнгийн шинж чанар, байршил, нөхцөл байдал гэх мэт зах зээлийн нарийн хүчин зүйлүүдэд тохируулан үнийг харьцуулах замаар зах зээлийн үнэлгээний сууриар үнэлсэн.

Барилгын элэгдэл

Үндсэн хөрөнгийг шулуун шугамын аргаар тооцоолсон ашиглах хугацаа болох 25-60 жилээр элэгдүүлнэ. Удирдлагын зүгээс барилгын элэгдлийн тооцоолсон ашиглалтын хугацаа нь зохистой ба үндэслэлтэй гэдэгт итгэлтэй байна.

3. ХҮҮГИЙН ОРЛОГО

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Дотоодын банкуудад олгосон зээл	114,582	20,022
Засгийн газрын үнэт цаас	6,741	17,279
Сангийн яаманд олгосон зээл	-	15,753
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	7,706	3,489
Санхүүгийн хөрөнгө оруулалт -Борлуулахад бэлэн	3,012	1,157
Бусад хүүгийн орлого	<u>676</u>	<u>1,649</u>
	<u>132,717</u>	<u>59,349</u>

4. ХҮҮГИЙН ЗАРДАЛ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Гаргасан үнэт цаас	109,243	84,351
Гадаад өр төлбөр	55,127	10,042
Засгийн газрын байгууллагуудын хадгаламж	80,247	9,778
Бусад хүүгийн зардал	<u>10,769</u>	<u>602</u>
	<u>255,387</u>	<u>104,773</u>

5. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛЫН АРИЛЖААНЫ ЦЭВЭР АШИГ/(АЛДАГДАЛ)

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Алтны арилжааны ашиг	(36,980)	3,604
Алтны дахин үнэлгээний бодит бус ашиг	(23,021)	15,291
Бусад үнэт металлын арилжааны цэвэр ашиг	<u>(6,804)</u>	<u>1,858</u>
	<u>(66,805)</u>	<u>20,753</u>

6. ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ЦЭВЭР АШИГ/(АЛДАГДАЛ)

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Валютын ханшийн хөрвүүлгийн бодит бус ашиг/(алдагдал)	(264,438)	30,225
Валютын ханшийн зөрүүний бодит ашиг/(алдагдал)	293,963	(38,839)
Валют арилжааны алдагдал	<u>(8,247)</u>	<u>(15,080)</u>
	<u>21,278</u>	<u>(23,694)</u>

7. ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДЛЫН (ЗАРДАЛ)/САНГИЙН БУЦААЛТ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Бусад авлага (Тодруулга 19)	5,244	(51)
Дотоодын банкуудад олгосон зээл (Тодруулга 18)	11,860	(88,565)
Засгийн газрын үнэт цаас (Тодруулга 16)	6,404	-
	23,508	(88,616)

8. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Хураамж ба шимтгэлийн орлого	3,452	2,452
Түрэсийн орлого	601	502
Бусад үйл ажиллагааны орлого	152	343
	4,205	3,297

9. ЗАХИРГААНЫ БОЛОН БУСАД ЗАРДАЛ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Үйл ажиллагааны зардал		
Боловсон хүчний зардлууд	9,983	7,788
Мөнгөн дэвсгэрт хэвлүүлэх зардал	16,484	3,274
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл/хорогдол (Тодруулга 20)	2,038	1,800
Бусад	5,564	4,662
	34,069	17,524

Үйл ажиллагааны бусад зардал

Хадгаламжийн Даатгалын Корпорацийн зардал	50,000	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний гарз	3,618	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	151	8
Үйл ажиллагааны бусад зардал	1,840	1,563
Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн анхлан хүлээн зөвшөөрөлтийн алдагдал	-	17,895
	55,609	19,466
Нийт	89,678	36,990

10. ҮНЭТ ЦААС БОРЛУУЛСНЫ АЛДАГДАЛ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Засгийн газрын үнэт цаас борлуулсны алдагдал	(6,664)	-
Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын борлуулалтын ашиг/ (алдагдал)	135	(453)
	<hr/> (6,529)	<hr/> (453)

11. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Бэлэн мөнгө	63,691	28,317
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж (Тодруулга 12)		
- Богино хугацаат хадгаламж	1,592,170	2,789,889
- Хугацаагүй хадгаламж	247,620	387,748
- Зээлжих тусгай эрхийн хадгаламж	110,459	94,647
	<hr/> 2,013,940	<hr/> 3,300,601

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор дээрх дүнгүүдийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан болно.

12. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Богино хугацаат гадаад валютын хадгаламж	1,592,170	2,789,889
Хугацаагүй хадгаламж	247,620	387,748
Зээлжих тусгай эрхийн хадгаламж	110,459	94,647
Хязгаарласан бэлэн мөнгө	738	604
Дэлхийн банкинд оруулсан хувь, хөрөнгө	104	87
Бусад хувь хөрөнгө	4	4
	<hr/> 1,951,095	<hr/> 3,272,979

Богино хугацаат гадаад валютын хадгаламж

Үүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад ам.доллар, евро, английн фунт, БНХАУ-ын юань, болон австралийн доллараар илэрхийлэгдсэн 92 хүртэлх хоногийн хугацаатай (2012 онд 90 хоног), богино хугацаат хадгаламжууд багтана.

Хугацаагүй хадгаламж

Үүнд гадаадын Төв банкуудад болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан харилцах дансууд багтана.

12. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ (Үргэлжлэл)

Хязгаарлагдсан бэлэн мөнгө

Үүнд гуравдагч талын хүсэлтээр Цюрихийн харья Шүүхээс хязгаарлалт тогтоосон 397,703 щвейцар франк буюу 738 сая төгрөг (2012 онд 604 сая төгрөг) орно. Дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 25-аас харна уу.

Зээлжих тусгай эрхийн хадгаламж

Энэ үлдэгдэл нь Банкнаас ОУВС-д оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2013 оны 12 дугаар сарын 31-нээр энэхүү үлдэгдэл 43.2 сая зээлжих тусгай эрх (2012 онд 44.1 сая зээлжих тусгай эрх) илэрхийлэгдсэн ба энэ дүнд хүү тооцдог.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө

Энэ нь Дэлхийн банкны группийн гишүүн болох шаардлагын дагуу Дэлхийн банкинд байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа (Тодруулга 24-өөс харна уу) ба хүү тооцдоггүй.

Бүх үлдэгдэл дүнгүүд хугацаа хэтрээгүй ба үнэ цэнэ нь буураагүй бөгөөд Удирдлагын зүгээс энэхүү хөрөнгө нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгуулагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна. Эдгээрийн аль нь ч барьцаа хөрөнгөөр бүртгэгдээгүй. Удирдлага эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо гэж итгэж байгаа. Газарзүй шинжилгээ, валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 29-өөс үзнэ үү.

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-БОРЛУУЛАХАД БЭЛЭН

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Өрийн үнэт цаас - борлуулахад бэлэн		
Олон Улсын Төлбөр Тооцооны Банкны гаргасан бонд	494,187	-
АНУ-ын засгийн газрын үнэт цаас	290,149	-
РАМП хөрөнгө оруулалтын данс	166,110	139,469
Өмчийн үнэт цаас - борлуулахад бэлэн		
Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр	3,084	3,084
	953,530	142,553

“РАМП” хөрөнгө оруулалтын данс

2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 0.3 сая ам.доллар (527 сая төгрөг)-ийн мөнгөн хөрөнгө, 100.1 сая ам.доллар (165,583 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкинд байршуулсан.

13. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ-БОРЛУУЛАХАД БЭЛЭН (Үргэлжлэл)

“РАМП” хөрөнгө оруулалтын данс (Үргэлжлэл)

Хөрөнгө оруулалтын данс дахь үнэт цаасны дийлэнх хэсгийг АНУ-ын Засгийн газрын бонд болон бусад орны Засгийн газрын байгууллагаас гаргасан үнэт цаас бүрдүүлж байна.

Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт ба Пүүрсийн рейтинг эсвэл Мүүдийс болон Фичийн рейтингийн аль багаар үнэлэхэд АА- ААА зэрэглэлтэй байна.

Өмчийн хөрөнгө оруулалт, өртгөөр

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцаа нь Монголын ипотекийн корпораци, Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны банкинд оруулсан хөрөнгө оруулалтыг илрэхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй зах зээлийн үнэ байхгүйн улмаас эдгээр хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэдэг. Эдгээр хөрөнгө оруулалтуудад зах зээл байхгүй ба Банк эдгээрийг урт хугацаагаар эзэмших төлөвтэй байна.

Санхүүжигч талын санхүүгийн мэдээлэлд үндэслэн удирдлага 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-нээр энэхүү хөрөнгө оруулалтуудын хувь үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг байхгүй хэмээн үзэж байна.

14. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЛҮҮД

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	503,177	2,031,631
Дотоодын банкууд	<u>1,026,038</u>	<u>92,322</u>
	<u>1,529,215</u>	<u>2,123,953</u>

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк

Банк Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжаараа Автомат Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн дагуу 100,000 ам.доллараас давсан дун Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээнд (“буцаан худалдан авах репо”) хөрөнгө оруулагддаг. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 304.2 сая ам.доллар (503,177 сая төгрөг)-тай тэнцүү байсан. Энэхүү хөрөнгө оруулалт нь хоёр хоногийн хугацаатай, жилийн 0.17 хувийн хүйтэй.

14. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЛҮҮД (Үргэлжлэл)

Дотоодын банкууд

Дотоодын банкуутдай байгуулсан урвуу буцаан худалдан авах хэлцлүүд нь нь ирээдүйн тодорхой нэг өдөр, тогтсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй Төв банк (Тодруулга 21) болон Засгийн газрын үнэт цасуудаар баталгаажсан богино хугацаат зээлийг илэрхийлнэ. Энэхүү хэрэглүүрүүд нь хоёр хоногийн хугацаатай, жилийн 12.5 хувийн хүйтэй ба хугацаа хэтрээгүй, үнэ цэнийн бууралтгүй.

15. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЛ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Бодит үнэ цэнээр		
Мөнгөжсөн алт	251,440	271,909
Мөнгөжсөн мөнгө	305	42
Өртгөөр		
Мөнгөжөөгүй алт, мөнгө	30,127	115,472
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	5,297	52,246
	287,169	439,669

16. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Сангийн яамны үнэт цаас (хорогдуулсан өртгөөрөө)	-	165,614
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	-	(6,404)
	-	159,210

2013 оны туршид гарсан Засгийн газрын үнэт цаасны үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг доор үзүүлэв.

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
01 дүгээр сарын 01-ний байдлаар	6,404	6,404
Сангийн буцаалт (Тодруулга 7)	(6,404)	-
12 дугаар сарын 31-ний байдлаар	-	6,404

17. ДОТООДЫН БАНКУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ, ХАДГАЛАМЖ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Дотоодын банкуудад байршуулсан бонгино хугацаат хадгаламж	405,000	-
Хуримтлагдсан хүү	896	-
	<u>405,896</u>	<u>-</u>

Энэ үлдэгдэл нь дотоодын банкнуудад төгрөгөөр байршиулсан, 365 хүртэлх хоногийн хугацаатай, 4 хувь болон 7 хувийн хүүтэй хадгаламжийг илэрхийлнэ. Дотоодын банкуудад энэхүү хугацаат хадгаламжуудийг 2013 оноос эхлэн байршиулсан.

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	2,770,573	188,360
Анод банкинд хамаарах зээл	77,630	89,490
Бусад зээл	<u>16,888</u>	<u>14,128</u>
	<u>2,865,091</u>	<u>291,978</u>
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	<u>(77,630)</u>	<u>(89,490)</u>
	<u>2,787,461</u>	<u>202,488</u>

Үнийг тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

Банк нь 2012 оны 11 дүгээр сараас эхлэн Засгийн газрын үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хүрээнд 2,770,573 сая төгрөгийн зээлийг дотоодын банкуудад сонгогдсон салбарт (шатахуун, хүнс, барилга гэх мэт) үйл ажиллагаа явуулж буй дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад дамжуулан зээлдүүлүүлэхээр олгосон. Эдгээр зээлийн нөхцөл болон хугацааг Засгийн газар тодорхойлдог ба оролцогч банкууд бие даан зээлийн нөхцлийг тодорхойлох боломжгүй. Түүнчлэн оролцох аж ахуйн, нэгж байгууллагуудыг засгийн газар сонгодог ба сонгогдсон аж ахуй нэгж байгууллагууд нь аль ч дотоодын банкуудаар дамжуулан тус зээлийг (Монголбанк дахин санхүүжүүлсэн) авч болно.

Засгийн газрын удирдамжийн дагуу банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин жилийн 0.5 хувиас 4 хувийн хооронд байна.

Анод банкинд хамаарах зээл

2008 оны 12 дугаар сарын 12-нд Анод банкны богино хугацаанд төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор Банк Анод банк дахь Бүрэн эрхт төлөөлөгчидтэй зээлийн гэрээнд гарын үсэг зурсан. Зээлийн гол зорилго нь харилцагчдын хадгаламжийг Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн дагуу эргэн төлөх байсан бөгөөд дээрх хуулинд Монгол улсын Засгийн газар банкуудад байршсан иргэдийн харилцах, хадгаламжийг батлан даах ба хэрэв банк дампуурсан тохиолдолд Засгийн газар иргэдийн харилцах-хадгаламжийг буцаан олгоно гэж заажээ.

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (Үргэлжлэл)

Зээлийн гэрээгээр 147.9 тэрбум төгрөгийн зээлийн шугам нээлгэсэн ба гэрээний нийт дүнгийн хязгаараас хэтрэхгүйгээр Анод банк нь хэсэгчлэн зээл авч болох бөгөөд хэсэгчлэн авсан зээл тус бүр нь анх олгогдсон өдрөөсөө 6 сарын дотор буцаан төлөгдөхөөр заасан. Зээлийн хүү нь 7 хоногийн Банкны үнэт цаасны хүйтэй тэнцүү ба зээл олгох үед Банкны долоо хоногийн хугацаатай үнэт цаасны хүү жилийн 9.75 хувьтай тэнцүү байв. Гэрээний дагуу хүүг 90 хоног бүр хуримтлуулж, Анод банкны харилцах данснаас шууд хасахаар заасан байна. Анод банкинд олгосон энэхүү зээл нь Анод банкны харилцагчиддаа олгосон 186.3 тэрбум төгрөгийн зээлээр баталгаажсан. Зээлийн анхны олголт нь гэрээнд гарын үсэг зурсан өдөр буюу 2008 оны 12 дугаар сарын 12-ний өдөр байсан.

Уг зээлийг эргэн төлөхөд хүндрэл учирсан тул, 2009 оны 7 дугаар сарын 28-ний өдрийн гэрээний хавсралтанд заасны дагуу зээлийн хугацааг 6 сараас 12 сар хүртэл болгон сунгасан. Мөн 2009 оноос хойш хүүг хуримтлуулахыг зогсоосон ба 2010 ба 2011 онуудад зээлийн эргэн төлөлт мүү байсан. Тиймээс 2010 ба 2011 онд шинээр ямар ч зээл олгогдоогүй бөгөөд Банк Монгол улсын Засгийн газар болон Сангийн яамтай энэхүү зээлийг нөхөн төлүүлэх талаар тохиролцоо хийсээр ирсэн байна.

Банк нь 2012 онд 12.5 тэрбум төгрөгийг, 2013 онд 11.8 тэрбум төгрөгийг барагдуулсан байна.

2010 оноос өмнө Банкны Удирдлага нь Анод банкнаас авах зээлийн авлагыг Сангийн яамнаас гаргах Засгийн газрын бондоос эргүүлэн төлүүлэх замаар Монгол улсын Засгийн газраас барагдуулна гэсэн дүгнэлтэй байсан тул 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэ цэнийн бууралтын алдагдлын санг байгуулаагүй байсан. Гэсэн хэдий ч, Засгийн газрын бонд гаргалт нь Монгол Улсын Их Хурлаар хэлэлцэгдэн батлагдаагүй байна. Иймд тухайн зээлтэй холбогдон бий болох ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон цаг хугацааны талаарх тодорхой бус байдлаас шалтгаалан 2012 онд Банк нь Анод банкны зээлийн үлдэгдэлд үнэ цэнийн бууралтын алдагдлын санг 100 хувиар нөхөж байгуулсан байна. (Тодруулга 7-с үзнэ үү)

Төгрөгөөр олгосон зээл

“Бусад зээл”-ийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд Азийн хөгжлийн банк (АХБ)-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 1,103 сая төгрөгийн (2012 онд 1,406 сая төгрөг) зээл болон Герман улсын Засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 5,225 сая төгрөгийн (2012 онд 500 сая төгрөг) зээл багтаж байна.

АХБ-тай холбоотой зээл нь Монголын хэд хэдэн дотоодын банкуудад олгогдсон бөгөөд дотоодын банкуудад үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх зорилгоор олгогдсон. Зээл нь жилийн 10 хувийн хүйтэй ба эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн банкны данснаас зээлийг шууд төлүүлэх эрхтэй.

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (Үргэлжлэл)

Гадаад валютын зээл

“Бусад зээл”-ийн нөгөө хэсэг болох валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг жижиг болон дунд хэмжээний аж ахуй нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон 9,846 сая төгрөгийн (2012 онд 5,435 сая төгрөг) зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах зорилгоор олгосон 701 сая төгрөгийн (2012 онд 623 сая төгрөг) зээл бүрдүүлж байна.

Герман улсын Засгийн газраас Монгол улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр тусдаа КФВ хөтөлбөрөөр хэрэгжиж байна. Эдгээр зээл нь жилийн 1.25 - 1.75 хувийн хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажаагүй. Энэ хоёр хөтөлбөрийн хүрээнд зээлийг дотоодын 3 банкаар дамжуулан КФВ-ийн тавьсан шаардлагад нийцсэн харилцагч наарт олгосон. Үүний дагуу олгосон зээл нэг бүрийн эргэн төлөлтийн хугацаа нь зээл олгосон өдрөөсөө хамааран өөр өөр байна. Банкны зээлийн эрсдэл нь зээлдэгчдийн эргэн төлөлтөөс хамаарахгүй бөгөөд Банк зээлийн төлөх хугацаа болмогц, тухайн банкны данснаас зээлийг шууд төлүүлэх эрхтэй. Эдгээр зээлийн хөтөлбөрүүд болон эдгээртэй холбоотой Банкны Сангийн яамд төлөх өглөгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 22-ээс харна уу.

Дотоодын банкны ажилчдын ур чадварыг дээшлүүлж, банкны системийг сайжруулах зорилготой зээл нь Монгол улс ба Азийн Хөгжлийн Банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) лимитед компанийн “Банкны Сургалтын Төв” дээр банкны ажиллагсад явуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгогдсон зээл бөгөөд эргэн төлөгдөх хугацаа нь 14 жил.

2013 оны туршид зээлийн үнэ цэнэ бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг доор харуулав.

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
01 дүгээр сарын 01-ний байдлаар	89,490	925
Алдагдал	-	89,490
Сангийн буцаалт	(11,860)	(925)
12 дугаар сарын 31-ний байдлаар	77,630	89,490

2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэ тогтвортжуулах хөтөлбөрүүдийн хүрээнд олгосон зээлүүд, төгрөг болон гадаад валютаар олгосон зээлүүдийн хувьд үнэ цэнэ бууралтын шинж тэмдэг илрээгүй тул үнэ цэнийн алдагдлын сан байгуулаагүй болно.

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (Үргэлжлэл)

Анод банкинд хамаарах зээлээс бусад бүх дотоодын банкуудад олгосон зээл нь барьцаагүй болно.

Анод банкны Бүрэн эрхт төлөөлөгчтэй хийсэн зээлийн гэрээнд зааснаар Анод банкны зээлийн багц тухайн зээлийн баталгаа болж байгаа бөгөөд дээр дурьдсанчлан Анод банк одоогоор татан буугдах үе шатандaa байгаа.

19. БУСАД ХӨРӨНГӨ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Бусад санхүүгийн хөрөнгө		
Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага	204,912	-
Компаниудаас авах авлага	44,821	43,896
Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага	14,461	12,169
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд (Тодруулга 30)	2,803	834
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(59,282)	(56,065)
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Үрьдчилж гарсан зардал	124	6,438
Бусад	617	368
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	<u>(229)</u>	<u>(219)</u>
	<u>208,227</u>	<u>7,421</u>

Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага

Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага нь 119.9 тэрбум төгрөгийн зээл болон 85 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгээс бүрдэнэ. 119.9 тэрбум төгрөгийн зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр бүрэн төлөгдөх ба 85 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг нь 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр эргэн төлөгднө.

Компаниудаас авах авлага

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад өмнөх жилд Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах 31,358 сая төгрөг (2012 онд 26,632 сая төгрөг)-ийн авлага орж байгаа ба эдгээр авлагыг найдвартай тооцон үнэ цэнийн бууралтын алдагдлын санг бүрэн байгуулсан. Банк үүнээс хойш ямар нэгэн алтны опцион хэлцэл хийгээгүй. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аж ахуйн нэгжүүдээс авах авлагын бусад үлдэгдлийг мөн үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн санг бүрэн байгуулсан байсан.

19. БУСАД ХӨРӨНГӨ (Үргэлжлэл)

Компаниудаас авах авлага (Үргэлжлэл)

Эдгээр үлдэгдлүүд нь 2005-2007 онуудад хамаарах ба Банк Төв банкны тухай хуулийн 23-р зүйлийн “Засгийн газар болон банкнаас бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байсан. Банкны Удирдлага нь “Үнэт металл олборлогч, арилжаалагчдын хүсэлтээр арилжаа хийхэд мөрдөх журам”-ыг 2003 оны 02 дугаар сарын 26-ний өдөр Банкны Ерөнхийлөгчийн 99 дүгээр тушаалаар баталсны дагуу тус үйл ажиллагааг шалгаж Банкны үйл ажиллагаанд сергөөр нөлөөлөхгүй гэж үзсэн.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах авлага

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарыг бүхэлд нь эргэн төлөгдөхгүй гэж тооцсоны шалтгаан нь тэдгээр байгууллагуудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой байна.

Бусад санхүүгийн бус хөрөнгө

Бусад санхүүгийн бус хөрөнгө голдуу урьдчилгаа төлбөр, ажилчдад олгосон урьдчилгаа, хангамжийн материал болон бичиг хэргийн материалаас бүрдэнэ.

Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан

2012 ба 2013 оны турш дахь санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөнийг дор харуулав:

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
01 дүгээр сарын 01-ий байдлаар	56,065	56,154
Гадаад валютаар илэрхийлэгдсэн сангийн ханшийн хөрвүүлэг	8,461	(140)
Үнэ цэнийн бууралтын алдагдал	-	218
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн буцаалт	(5,244)	(167)
12 дугаар сарын 31-ий байдлаар	59,282	56,065

Бусад санхүүгийн бус хөрөнгийн хувьд байгуулсан сангийн хөдөлгөөн нь бүхэлдээ гадаад валютын ханшийн нөлөөнөөс үүссэн болно.

20. ҮНДСЭН БА БИЕТ БУС ХӨРӨНГО

	Барилга байшин	Дуусаагүй барилга	Компьютер, тоног төхөөрөмж	Нийт үндсэн хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт
Өргөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
2012 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	23,804	533	8,048	32,385	2,268	34,653
Нэмэгдсэн	814	-	1,652	2,466	108	2,574
Худалдан борлуулсан	-	-	(152)	(152)	-	(152)
Данснаас хассан	-	-	(472)	(472)	-	(472)
Дахин ангилсан	499	(499)	-	-	-	-
	<u>25,117</u>	<u>34</u>	<u>9,076</u>	<u>34,227</u>	<u>2,376</u>	<u>36,603</u>
2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар						
Хуримтлагдсан элэгдэл						
2012 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар	3,354	-	4,213	7,567	1,083	8,650
Тухайн жилийн элэгдлийн зардал	389	-	1,140	1,529	271	1,800
Худалдан борлуулсан	-	-	(14)	(14)	-	(14)
Данснаас хассан	-	-	(464)	(464)	-	(464)
2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	<u>3,743</u>	<u>-</u>	<u>4,875</u>	<u>8,618</u>	<u>1,354</u>	<u>9,972</u>
2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	21,374	34	4,201	25,609	1,022	26,631
дансны үнэ						

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2013 оны 12 дугаар сарын 31

20. ҮНДСЭН ВА БИЕТ БУС ХӨРӨНГО (Үргэлжлэл)

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2013 оны 12 дугаар сарын 31

			Барилга байшин	Дуусаагүй барилга	Комьютер, тоног тохөөрөмж	Нийт үндсэн хөрөнгө	Биет бус хөрөнгө	Нийт сая төгрөг
			сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Өргөг								
2013 оны 01 дугээр сарын 01-ний байдаар			25,117	34	9,076	34,227	2,376	36,603
Нэмэгдсэн			1,414	725	1,812	3,951	-	3,951
Худалдан борлуулсан			-	-	(1,604)	(1,604)	(75)	(1,679)
Данснаас хассан			-	-	(411)	(411)	-	(411)
Дахин үнэлгээгээр нэмэгдсэн			25,649	-	-	25,649	-	25,649
Дахин үнэлгээгээр хасагдсан			(5,448)	-	-	(5,448)	-	(5,448)
2013 оны 12 дугаар сарын 31-ний байдаар			46,732	759	8,873	56,364	2,301	58,665
Хуримтлагдсан элэгдэл								
2013 оны 01 дугээр сарын 01-ний байдаар			3,743	-	4,875	8,618	1,354	9,972
Тухайн жилийн элэгдлийн зардал			545	-	1,229	1,774	264	2,038
Дахин үнэлгээний элэгдэл			20,138	-	-	20,138	-	20,138
Худалдан борлуулсан			-	-	(1,594)	(1,594)	(75)	(1,669)
Данснаас хассан			-	-	(260)	(260)	-	(260)
2013 оны 12 дугаар сарын 31-ний байдаар			24,426	-	4,250	28,676	1,543	30,219
2013 оны 12 дугаар сарын 31-ний байдаар			22,306	759	4,623	27,688	758	28,446
дансны үнэ								

20. ҮНДСЭН ХӨРӨНГӨ (Үргэлжлэл)

Монгол улсад мөрдөгдөж буй хуулийн дагуу Банк нь 5 жилд нэг удаа барилгаа дахин үнэлэх үүрэгтэй. Хамгийн сүүлийн үнэлгээг хараат бус үнэлгээч болох “Үнэлгээ ба төслийн компаниудын консорциум” 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гүйцэтгэсэн.

Дахин үнэлгэдсэн барилга нь түүхэн өртгөөрөө бүртгэгдсэн бол 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд дансны үнээрээ 15,684 сая төгрөг (2012 онд 14,899 сая төгрөг)-өөр илэрхийлэгдэх байсан.

2,504 сая төгрөг (2012 онд 1,641 сая төгрөг)-ийн дансны үнэ бүхий барилга нь Тодруулга 24 -т толилуулагдсан зээллэгийн барьцаанд байгаа болно.

21. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Үнэт цаасны өглөг	<u>1,627,017</u>	<u>752,151</u>

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаас нь 7-28 хоногийн хугацаатай бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүүгийн түвшин нь 10.50-10.88 хувь (2012 онд: 13.25-17.25 хувь) байв. Банк нь үнэт цаасыг инфляцийн түвшинг хянах, илүүдэл мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтээс гаргах зорилгоор гаргадаг.

22. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ӨР ТӨЛБӨР

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг (restated)
Сангийн яамд төлөх зээлийн өр төлбөр		
- Германы Засгийн газар (КФВ)	16,015	13,443
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	8,049	6,990
- Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)	7,548	6,187
Сангийн яамны харилцах, хадгаламж	1,678,412	2,933,065
	<u>1,710,024</u>	<u>2,959,686</u>

Сангийн яамны дансууд

Эдгээр харилцах дансууд нь Банкинд байршуулсан Сангийн яамны төрөл бүрийн харилцах дансууд юм.

22. ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУДАД ӨГӨХ ӨР ТӨЛБӨР (Үргэлжлэл)

Олон улсын байгууллагаас авсан зээллэгтэй холбоотой Сангийн яаманд төлөх өр төлбөр

Эдгээр өр төлбөр нь Монгол улсын Засгийн газраас “КФВ” (Герман улсын Засгийн газрыг төлөөлж) болон Азийн Хөгжлийн Банктай (цаашид “АХБ” гэх) байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Гэрээнд Монгол улсын Сангийн яам нь санхүүгийн төлөөлөгчөөр Банк нь төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд КФВ-аас авсан зээл нь бие даасан хоёр хөтөлбөртэй ба 1995 болон 2003 оноос тус тус хэрэгжиж эхэлсэн. Эдгээр зээлүүд нь европоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүйтэй, 30 жилийн хугацаатай. Эхний болон дараагийн хөтөлбөрийн эргэн төлөлтүүд 2005 болон 2012 оноос эхлэн төлөгдөж эхэлсэн.

АХБ-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээлүүд нь жилийн 1 хувийн (2012 онд: 1 хувь) хүйтэй ба дуусгавар хугацаа нь 27- 30 жил байна.

Сангийн яам нь Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн санхүүгийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэдэг учир Банк КФВ болон АХБ-ны төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь КФВ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийг эцсийн хэрэглэгчдэд хүргэх ўйл ажиллагааг хариуцна.

Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь КФВ болон АХБ-ны гэрээний нөхцөлтэй ижил нөхцөлтэйгээр Сангийн яамнаас эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, КФВ, АХБ болон Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгосон зээлийн талаар Тодруулга 18-д харуулав. Сангийн яаманд өгөх өглөг болон дотоодын банкуудад олгосон зээлийн талаарх Банкны Удирдлагын дүгнэлтийг Тодруулга 2-оос харна уу.

Олон Улсын Хөгжлийн Ассоциациын хувийн хэвшлийг хөгжүүлэх болон санхүүгийн чадавхийг хөгжүүлэх төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт олгосон зээлийг Банк Сангийн Яамнаас дамжуулан авсан ба зээл нь жилийн 1 болон 3 хувийн хүйтэй.

Холбоотой талуудын ажил гүйлгээ, тэдгээрийн үлдэгдлийг Тодруулга 33-т үзүүлэв.

23. ДОТООДЫН БАНКУУДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Харилцах дансдууд:		
- төгрөгөөр	1,748,766	842,958
- валютаар	711,641	528,713
Богино хугацаат хадгаламж	36,790	-
	2,497,197	1,371,671

Харилцах дансны дүн нь дотоодын банкуудаас Банкинд зайлшгүй байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжуудаас бүрдэнэ. Зайлшгүй байлгах нөөцийг банкууд бусдаас татаан төвлөрүүлсэн хөрөнгөд тодорхой хувиар тооцож тогтооно.

Богино хугацаат хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 8.5 хувийн хүүтэй овернайт хадгаламж юм.

24. ГАДААД ӨР ТӨЛБӨР

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Барьцаатай		
Лондонгийн HSBC-ээс авсан зээл	238	389
Барьцаагүй		
Хятадын Ардын Банкнаас авсан зээл	1,649,346	470,788
Олон Улсын Валютын Сан ("ОУВС")		
– ОУВС дахь данс No.1	287	272
– ОУВС дахь данс No.2	7	6
– Зээлжих тусгай эрхийн хуваарилалт (ЗТЭ)	124,620	104,628
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	104	87
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	34	34
Дэлхийн банкны харилцах данс	160	210
АХБ-ны харилцах данс	11	-
	1,774,807	576,414

Лондонгийн HSBC-ээс авсан зээл

Энэ нь үндсэн хөрөнгийн худалдан авалтыг санхүүжүүлэх зорилгоор Лондонгийн HSBC банкнаас 10 жилийн хугацаатайгаар авсан зээл юм. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 онд эхэлсэн бөгөөд хүүгийн түвшинг HSBC банкны жилийн үндсэн хүүн дээр 1.75 хувийг нэмж тооцдог. Зээлийн барьцаанд Тодруулга 20-д танилцуулсан барилгыг тавьсан.

24. ГАДААД ӨР ТӨЛБӨР (Үргэлжлэл)

Хятадын Ардын Банкнаас авсан зээл

Энэхүү үлдэгдэл нь Хятадын Ардын банкнаас зээлсэн 6 сарын хугацаатай юанийн зээл бөгөөд Банк дотоодын банкуудыг юаниар санхүүжүүлэхэд ашигладаг. Хүү нь “200” үндсэн нэгж дээр Шанхай-Интер банкны санал болгосон түвшинг (“SHIBOR”) нэмсэнтэй тэнцүү.

Зээлжих тусгай эрхийн хуваарилалт

ОУВС-ын гишүүн орнуудад ОУВС-д оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилсан. Энэ хуваарилалт нь Монголбанкны ОУВС-д өгөх өр төлбөрийг илэрхийлэх ба үүний эсрэгцээ ОУВС-аас ЗТЭ-ийн хадгаламжийг авсан. (Тодруулга 12-г харна уу). Хуваарилалтын цэвэр хуримтлал нь 124,620 сая төгрөг (2012 онд 104,628 сая төгрөг) буюу 48,757 сая ЗТЭ (2012 онд 48.757 сая ЗТЭ)-тэй тэнцүү байна.

Дэлхийн банк ба Олон улсын хөгжлийн агентлагт оруулсан хувь хөрөнгө

Энэ үлдэгдэл нь Банкнаас Дэлхийн Банк болон Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-т оруулсан хувь хөрөнгө юм.

25. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Бусад санхүүгийн өр төлбөр		
Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ	16,388	2,000
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж	10,395	7,030
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд (Тодруулга 30)	70,017	1,233
Бусад өр төлбөр	7,850	6,545
Бусад өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	9,525	9,209
Аkkreditivийн заргатай холбоотой байгуулсан сан	<u>44,532</u>	<u>36,464</u>
	<u>158,707</u>	<u>62,481</u>

Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ

Дотоодын банкны дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ нь Монгол Улсын дотоодын банкны дүрмийн санг нэмэгдүүлсэнтэй холбоотой нээсэн тусгайлсан дансууд юм. Эдгээр дансуудыг тухайн дотоодын банкууд хөрөнгө оруулалт хийх гэх мэт зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд хязгаарлалттай. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дүрмийн санд анх оруулсан хөрөнгийн хэмжээ нь Голомт банкны дүрмийн сангийн нэмэгдлийг илэрхийлсэн (2012 оны 12 дугаар сарын 31-нээр: Кредит Банк).

25. БУСАД ӨР ТӨЛБӨР (Үргэлжлэл)

Нийгмийн хөгжлийн сан

Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг өөрсдийн ажилчдын ажлын болон амьжиргааны нөхцлийг сайжруулах зорилгоор Нийгмийн Хөгжлийн Санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтанд тэтгэмж, тусламж олгох, ажлын үзүүлэлтээр шагнах, Банкны ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авах болон хэрэгцээтэй үед нь ажилтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны Удирдлага 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай байсан гэж узсэн.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд нь 2014 онд хугацаа нь дуусах дотоодын банкуудтай байгуулсан своп хэлцэл болон шатахууны үнийг тогтвортжуулалтын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгуулсан форвард хэлцлүүдийн бодит үнэ цэнийг илэрхийсэн. Тодруулга 30-г харна уу.

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь төрийн байгууллага болох Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн болон Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах дансуудаас бүрдэнэ.

Аkkредитивийн заргатай холбоотой байгуулсан сан

Аkkредитивийн заргатай холбоотой байгуулсан сан нь 2008 онд үүссэн шийдвэгээгүй хэрэгтэй холбоотой үүссэн. Щвейцар болон Герман улсуудад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн байгууллагатай 2008 оноос хойш хийсэн аккредитивийн гэрээтэй холбоотойгоор шүүхэд нэхэмжилж, шүүх үйл ажиллагаа нь үргэлжилж байгаа. Банк энэ шүүхэд аккредитивийн гэрээний дагуу өөрийн хүлээсэн үүргийн хүрээнд байр сууриа баттай хамгаалж байгаа хэдий ч 2009 онд нийт дүнгээр (хүүг оруулан) нь эрсдлийн сан байгуулсан. 2012 болон 2013 оны туршид гадаад валютын ханшийн хэлбэлзлийн нөлөөнөөс гадна нөөцийн санд өөрчлөлт ороогүй.

Эдгээр аккредитивтэй холбогдуулан Америкийн нэгдсэн улсын өмнөд Флоридагийн дүүргийн шүүхэд Банк залилан, гэрээний зөрчил гэх мэт хууль зөрчсөн үндэслэлээр тодорхой хувь хүн болон байгууллагуудыг шүүхэд дуудан зарга үүсгээд байгаа. Уг хувь хүн болон байгууллагаас нэхэмжилж буй дүн нь Банкны төлж болзошгүй дээр дурдсан өр төлбөрөөс мэдэгдэхүйц хэмжээгээр давж байгаа юм. Хэрэг Банкны хувьд нааштай шийдвэгдэх хандлагатай байгаа хэдий ч хариуцагчид авлагыг бүрэн хэмжээгээр барагдуулна гэсэн хангалттай баталгаа байхгүй байна. Тиймээс Банк санхүүгийн тайланд авлага хүлээн зөвшөөрөгүй боловч нэхэмжилсэн төлбөрөө барагдуулахаар туштай ажиллаж байна.

26. ДҮРМИЙН САН

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Дүрмийн сан	<hr/> 5,000	<hr/> 5,000

Банкны дүрмийн сан нь 100 хувийн Төрийн өмч болно. Дүрмийн сан нь Банкны капиталыг илэрхийлнэ.

Монгол Улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу тухайн жилийн цэвэр ашгийн 40 хувиас доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60%) Улсын төсөвт шилжүүлдэг. Тиймээс Ерөнхий нөөцийн сан нь хуримтлуулсан цэвэр ашгийн 40 хувиас доошгүйг ерөнхий нөөцийн санд хуваарилдаг ба үүнийгээ Банк бүрэн захиран зарцуулах эрхтэй. Энэхүү нөөцийн санд Улсын төсөвт өмнө нь шилжүүлсэн болон ирээдүйд шилжүүлэх дүнг оруулахгүй. Учир нь эдгээр нь тухайн жилдээ Засгийн газарт шилжүүлдэг. 2012 болон 2013 онуудад ерөнхий санруу шилжүүлэг хийгээгүй.

27. БУСАД САН

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгийн сан

Энэ сан нь борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн өөрчлөлтүүдээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан

Дахин үнэлгээний илүүдэл нь Банкны Ерөнхийлөгчийн 2013 оны тушаалаар гүйцэтгэсэн Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн.

Гадаад валютын дахин үнэлгээний сан

Энэ санг гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, өр төлбөрүүдийн хөрвүүлгээс үүссэн болоод хуримтлагдсан ашгаас шилжиж ирсэн ашиг эсвэл алдагдлын дүнг бүртгэхэд ашигладаг.

Үнэт металын дахин үнэлгээний сан

Энэ дансыг нь Банкны эзэмшилд байгаа мөнгөжсөн алтны бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн болоод хуримтлагдсан ашгаас шилжүүлсэн ашиг эсвэл алдагдлын дүнг бүртгэхэд ашигладаг.

27. БУСАД САН (Үргэлжлэл)

2012 ба 2013 оны бусад сангийн хөдөлгөөнийг доор харуулав.

	Борлуулхад бэлэн санхүүгийн хөрөнгийн сан сая төгрөг	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан сая төгрөг	Валютын дахин үнэлгээний сан сая төгрөг	ҮНЭТ металын дахин үнэлгээний сан сая төгрөг	Нийт сая төгрөг
2012 оны 01 дугээр сарын 01-ний байдлаар					
Борлуулхад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит Үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	(837)	-	-	-	(837)
Борлуулах үед орлогын тайланруу шилжүүлсэн Хуримтладсан ашгаас шилжүүлсэн	453	-	-	-	453
2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	(342)	7,788	106,527	36,080	150,053
2013 оны 01 дугээр сарын 01-ний байдлаар					
Борлуулхад бэлэн санхүүгийн хөрөнгийн бодит Үнэ цэнийн өөрчлөлтийн ашиг	425	-	-	-	425
Борлуулах үед орлогын тайланруу шилжүүлсэн Хуримтладсан алдагдалд шилжүүлсэн	(135)	-	(106,527)	(23,021)	(135)
Дахин Үнэлгээни нөөцруу шилжүүлсэн	-	4,263	-	-	4,263
2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	(52)	12,051	-	13,059	25,058

28. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд Банк нь янз бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээж байдаг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байж болох ч эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийг бүрдүүлж байдаг.

	2013 сая төгрөг	2012 сая төгрөг
Болзошгүй авлага		
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага	11,677	-
Болзошгүй өр төлбөр		
Экспортын аккредитивүүд	(279,320)	(61,856)
Үүрэг		
Ашиглагдаагүй зээлийн шугам – Хятадын Ардын Банк	<u>(545,760)</u>	<u>(89,356)</u>
	<u>(813,403)</u>	<u>(151,212)</u>

Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах авлага

Банк гадаадын хэд хэдэн санхүүгийн байгууллагад оруулсан хөрөнгө оруулалтыг өртгөөр нь бүртгэсэн учир нь хөрөнгө оруулалтын шинэ үнэлгээний талаар гуравдагч хөрөнгө оруулагчид зарга үүсгэсэнтэй холбоотой байна. Тиймээс банк нь өртөг болон маргаантай байгаа үнэлгээний зөрүүг зарга шийдэгдэх хүртэл болзошгүй хөрөнгөөр бүртгэсэн. Маргаантай хөрөнгө оруулалтын одоогийн дүн нь (өртгөөр) 2,594 сая төгрөг байна.

Экспортын аккредитивүүд

Экспортын аккредитив нь Монгол Улсын Засгийн газарт экспортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Экспортын аккредитивээр Банк Монгол Улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ. Энэхүү тайланд тусгагдсан экспортын аккредитивын дунд АНУ, Щвейцар болон ХБНГУ-ийн шүүхэд шийдэгдээгүй байгаа заргууд багтсан ба Банк эдгээр хууль зүйн болзошгүй төлбөр үүсгэж болох аккредитивүүдэд 44,532 сая төгрөгийн (2012 онд 36,464 сая төгрөг) найдваргүй авлагын санг байгуулж, Тодруулга 25-д толилуулсан.

Банкны Удирдлага 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар аккредитивийн шийдэгдээгүй хэрэгт байгуулсан сангаас бусад аккредитив, зээлийн шугамаарх үүрэг хариуцлагын бодит үнэ цэнийг материаллаг бус хэмээн дүгнэсэн байна. Ашиглагдаагүй байгаа зээлийн шугам болон аккредитивийн гэрээт үлдэгдэл нь ирээдүйн бэлэн мөнгөний шаардлагыг бий болгохгүй. Учир нь эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

28. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ (Үргэлжлэл)

Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн гэрээ

Банк нь 2011 оны 5 дугаар сард Хятадын Ардын Банктай “Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлцэл”-ийн гэрээ байгуулсан. Төв банкууд санхүүгийн зах зээлийн тогтвортой байлдыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах, хоёр улсын эдийн засгийн хөгжлийн төлөө хоёр орны худалдааг дэмжих зорилгоор энэхүү гэрээг байгуулсан.

Уг гэрээний дагуу Хятадын Ардын Банк (ХАБ) ба Банк нь юаниар төгрөг эсвэл төгрөгөөр юань худалдаа, худалдан авах болон дараа нь түүнийгээ буцаан худалдаа, худалдан авах байдлаар гүйлгээ хийж болно. Эдгээр зорилгын хүрээнд Төв банк бүр нөгөө талдаа зориулан өөрийн орныхоо мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдэх хүү тооцдоггүй тусгай дансдыг нээсэн. Өөрөөр хэлбэл ХАБ юанийн дансыг Банкинд, Банк төгрөгийн дансыг ХАБ-д зориулан тус тус нээсэн.

Төв банкууд энэхүү мөнгөн хөрөнгийг санхүүгийн зах зээлийг тогтвржуулах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах, хоёр орны хоорондын худалдааг санхүүжүүлэхэд болон гэрээнд заасан бусад зорилгоор ашиглана. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа нь 3 - 6 сар байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөөгөөсөө авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 10 тэрбум юань, ХАБ-ын хувьд 2 их наяд төгрөгөөр хязгаарлагдана. Банк ашигласан хөрөнгийг буцаан төлөх өдрөө түүний хүүг гэрээнд тусгайлан заасан хүүгийн түвшнээр тооцож, төлөх үүрэгтэй. Банк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь 200 суурь нэгж дээр Шанхай-Интер Банк Санал болгосон түвшинг (“ШИБОР”) нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин ХАБ төгрөг ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байх ба үүнийг мөн ашигласан хугацаанд тооцно.

Жилийн туршид Банк нь нэмэлт 3.9 тэрбум юанийн худалдан авалт хийсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ашигласан дүн нь 6 тэрбум юань буюу 1,637,280 сая төгрөг хүрсэн. (2012: 2.1 тэрбум юань, буюу 469,119 сая төгрөг). Ашиглаагүй дүн болох 2 тэрбум юань буюу 545,760 сая төгрөг нь (2012: 0.4 тэрбум юань буюу 89,356 сая төгрөг) 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх зээлтэй холбоотой Банкны үүрэг байна.

Бусад шийдэгдээгүй хэргүүд

Тодруулга 25-д дурьдсан аккредитивийн заргатай холбоотой байгуулсан сангаас гадна, удирдлага нь 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар банк нь хариуцагч талаар татагдсан, материаллаг алдагдалд хүргэж болох шийдэгдээгүй хэрэг байхгүй хэмээн дүгнэж байна. Тиймээс удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудад дээр дурьдсан аккредитивтай холбоотой сангаас гадна сан байгуулах шаардлагагүй гэдэгт итгэж байна.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг тиймээс ч эдгээр эрсдэлийг тогтмол хянаж зөв зохистой бодлого баримтлах нь банкны гол зорилго. Эдгээр эрсдэлийг зохистой удирдах нь Монголын банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж инфляцийг зохистой түвшинд барих зөв мөнгөний бодлого явуулахад чухал шаардлагатай. Эдгээр эрсдэлүүд нь банкны тэргүүний зорилгodoо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Энэ нь Төв банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын ханшийн зөрүүнээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Эдгээр санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Банкинд тулгараах эрсдэлүүд нь санхүүгийн (зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн), үйл ажиллагааны, нэр хүндээ хадгалах мөн эрх зүйн эрсдэлүүдээс бүрдэнэ. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус бөгөөд газар тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлого баримталдаг. Банк нь Монгол улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах болон эрсдэлийн удирдлага, хяналттай холбоотой шийдвэрүүд гаргах эрх бүхий “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхитэй хайж байна. Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй байхад Эрсдэлийн удирдлагын алба болон Валют, эдийн засгийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

Эрсдэлийн удирдлагын бүтэц

Захирлуудын Зөвлөл нь эрсдэлүүдийг тодорхойлж хянахад эцсийн хариуцлага хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нар зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьялагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банкны эрсдэлийг ерөнхийд нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь банкны эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн гол хэсэг бөгөөд Захирлуудын Зөвлөл, Ерөнхийлөгчид эрсдэлийн удирдлагын бодлого дээр зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Валют эдийн засгийн газрын захирал, Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын захирал, Эрсдэлийн удирдлагын албаны захирал нар багтдаг.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Эрсдэлийн удирдлагын бүтэц (Үргэлжлэл)

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “хөрөнгө оруулалтын бодлого”-ыг баталж, зөвшөөрөгдхөн эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн Улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид барина. Үүнд гадаад валютын нөөцийн валютын бүтэц, түүний зохицтой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, түүний зохицтой хэлбэлзэл, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэглүүр, харилцагч байгууллагууд болон тэдгээрт тавьсан хязгаарлалт зэргийг тусгана. Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой хэмжээг улирал тутамд батлах бөгөөд энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга юм.

Банкны гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал ба энэ нь банкны нийт хөрөнгөд гадаад валютын хөрөнгийн эзлэх хувиас хамаардаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын явуулдаг үйл ажиллагаа нь гадаад валютын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдан хяналт тавихад түлхүү чиглэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба болон бусад холбогдох газруудад хяналт тавих бөгөөд тэдгээр нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэл болон хэрэгжилт бодлоготой нийцтэй байгаа эсэхэд ерөнхийлөн анхаарч ажилладаг. Санхүүгийн эрсдэлийг удирдахад ашигласан аргуудыг доор дурьдав.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн Удирдлагын Алба ("ЭУА") нь гадаад валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаа, хараат бус хяналтын үүрэг гүйцэтгэдэг. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого, хязгааруудын хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг хариуцдаг.

Улсын гадаад валютын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын зорилго нь Банкны мөнгөний болон гадаад валютын бодлогод тусгагдсан байдаг. Гадаад валютын нөөцийн гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Зах зээлийн валютын ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянаснаар гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлага нь эдгээр зорилтуудад хүрэхэд дэмжлэг болдог. Банк гадаад эрсдэлийг хянахын тулд хөрөнгийг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд хөрвөх валютын бэлэн байдлыг хадгалж байхад шаардлагатай валютын багцын бүтэц, хөрвөх чадвар ба аюулгүй ажиллагааны шаардлагуудыг хангасан хөрөнгө оруулалтын хэрэглүүрүүдийн зөвшөөрөгдөх хязгаар, хүүгийн түвшний эрсдэлийг хязгаарлахад тавигдах хугацааны шаардлагууд зэрэгт зориулсан параметрүүдийг бий болгох ажил ордог.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Эрсдэлийн удирдлагын бүтэц (Үргэлжлэл)

Валют эдийн засгийн газар

Валют эдийн засгийн газар нь холбогдох тусгай албуудаараа дамжуулан хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Валют эдийн засгийн газрын захирал нь хөрөнгийн бүрдэл, хэрэгслүүд, харилцаач талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын хөрөнгийн хэмжээ зэрэг хөрөнгийн асуудлуудыг удирдан хянах үүрэгтэй.

Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар

Банк зорилгодоо хүрэх, бодлого төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд өөрийн үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын систем нь зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (ДХҮАЭГ)-ын эрхэм зорилго юм. Банкны мөрдөж буй бодлого, горимуудын төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилтийн хяналтын түвшний эрсдэлийн удирдлага; үйл ажиллагаа болон системүүд нь хууль журамд нийцэж буй эсэхийг шалгах түвшний эрсдэлийн удирдлага; санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн аюулгүй байдлыг шалгах түвшний эрсдэлийн удирдлага зэргийн зохистой, үр нөлөөтэй байдлыг шалгах, үнэлэх нь ДХҮАЭГ-ын үндсэн чиг үүрэг юм.

ДХҮАЭГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан аудитын хүн хүч нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулах үед эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн үед хийдэг. Банкны ДХҮАЭГ нь 2013 оны хяналтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглэх замаар хяналтын ажлын дарааллыг тодорхойлдог. Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жигнэсэн онооны нийт дүнг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангила.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод хяналтын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагаануудын хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДХҮАЭГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын Зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДХҮАЭГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, гуравдагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болно. Банкны нэг төрлийн эрсдэл юм. Санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог. Зээлийн эрсдэлийг удирдахаа хөрөнгө оруулалт хийх хөрөнгөө зөв сонгох, нэг төрлийн хөрөнгөнд хийх хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаар тогтоо арга замаар удирддаг. Хөрөнгө оруулалтын төрөл, гуравдагч талуудаас хамааралтай үүдэх зээлийн эрсдэлийн түвшний хязгаарыг удирдлагаас ойр ойрхон тогтоож жил тутам тогтмол хяналт тавьдаг.

Банк нь санхүүгийн хөрөнгийн зээлжих чанарыг олон улсын үнэлгээний байгууллагаас тогтоосон жишигт тулгуурладаг бол тухайн гадны байгууллагад (жишээлбэл Төв банк) тусгайлан тогтоосон үнэлгээ байхгүй тохиолдолд тухайн орны үнэлгээнд тулгуурлана. Банк нь хэрвээ олон улсын зах зээлийн байдал тогтвортгүй байвал системийн эрсдэлд орохоос зайлсхийж тухайн байгууллагуудын үнэлгээг үл харгалзан үйл ажиллагаагаа зогсоо шаардлагатай.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг “AAA” рейтингтэй Засгийн газар (эсвэл Төв банк)-ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас “A-“ болон түүнээс дээш рейтинг авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкны дахин санхүүжилтийн журамд зааснаар Монголын дотоодын банкуудад санхүүгийн хэрэглүүрүүд олгоход ашигладаг барьцаа хөрөнгүүдийн үндсэн төрлүүдийг дор дурьдав:

1. Төв банкны үнэт цаас;
2. Богино хугацаат засгийн газрын үнэт цаас;
3. Банкны хүлээн зөвшөөрсөн, Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнуудын (ОУЭЗХАГО) засгийн газраас гаргасан үнэт цаас;
4. Гадаадын томоохон санхүүгийн байгууллагад эзэмшилтэй, AAA рейтингтэй эргэн төлөгдөх чадвар өндөртэй үнэт цаас;
5. Банкны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн байгууллагуудын өрийн бичгүүд;
6. Банкуудад болон гадаадын банкинд байршуулсан хугацаат хадгаламжууд.

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах ёстой. Хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг л биелүүлэгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагаагаа цуцалдаг.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Ретинггүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамаарлтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг тодорхойлоход хэрэглэдэг Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй болон бусад олдоцтой мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг.

Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашиглаагүй байна.

Цаашилбал, бүх харилцагчдад зээлийн хязгаар байдаг бөгөөд энэ нь тэдний зээлийн үнэлгээ, хувь нийлүүлсэн хөрөнгө болон бусад хүчин зүйлд үндэслэгдэнэ. Хөрөнгө оруулалтын хороо нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгийн насжилтын шинжилгээг хийдэг байна. Зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээлэл Захирлуудын Зөвлөлд танилцуулагдах ба тэд үүнийг хэлэлцэн үзэж шаардлагатай шийдвэрийг гаргана.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Доорх хүснэгт нь санхүүтийн хөрөнгүүдийн зээлийн эрдээлийг Муудигийн үнэлгээний системд үндэслэн үнэлж хөрөнгийн ангилал бүрээр харуулав. Доор харуулсан дунгүүд нь үнэ цэнийн бууралтын алдагдын санг оруулаагүй дунгээр үзүүлэгдэж байна.

		Хугацаа хэтрэгчий, үнэ цэнийн бууралтуй				Хугацаа хэтрэснээсээл дангаараа үнэ цэнийн бууралттай	
2013 оны 12 дугаар сарын 31- ний байдлаар		AAA	AA	A	B	Үнэлг- дэгүй	Нийт
Хөрөнгө		сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Гадаадын санхүүтийн байгууллагуудад байршиулсан хөрөнгө, хадгаламж	1,518,168	321,867	15	-	4	-	1,840,054
Борлуулахад бэлэн санхүүтийн хөрөнгө оруулант	922,692	9,814	1,686	-	19,338	-	953,530
Урвуу буцаан худалдан авах хэццэл	503,177	-	-	682,461	343,577	-	1,529,215
Засгийн газрын үнэт цаас	-	-	-	-	-	-	-
Дотоодын банкуудад байршиулсан хөрөнгө, хадгаламж	-	-	-	180,342	225,554	-	405,896
Дотоодын банкуудад олгосон зээл	-	-	-	1,468,035	1,319,426	77,630	2,865,091
Бусад хөрөнгө	31	2,227	-	-	205,493	59,282	267,033
2,944,068	333,908	1,701	2,330,838	2,113,392	136,912	7,860,819	

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Хугацаа хэтэрсэн эсвэл дангваараа үнэ цэнийн бууралгтай

Хугацаа

хэтэрсэн эсвэл

дангаараа

үнэ цэнийн

бууралгтай

НИЙТ

	AA сая төгрөг	AA сая төгрөг	A сая төгрөг	B сая төгрөг	Үнэлэгчийн сая төгрөг	В сая төгрөг	Нийт сая төгрөг
Хөрөнгө							
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	2,662,811	514,910	56	-	4	-	3,177,781
Борлуулхад бэлэн Санхүүгийн хөрөнгө оруулалт	114,737	1,470	-	-	26,346	-	142,553
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,031,630	-	-	62,959	29,363	-	2,123,952
Засийн газрын үнэт цаас	-	-	-	159,210	-	6,404	165,614
Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	-	-	-	-	-	-	-
Дотоодын банкуудад олгосон зээл	-	-	-	109,961	92,527	89,490	291,978
Бусад хөрөнгө	-	836	-	-	-	56,065	56,901
	4,809,178	517,216	56	332,130	148,240	151,959	5,958,779

Хэрэв үнэлэгчийн харилцагч тал нь улсын төв бөнгөн эсвэл гадаадын санхүүгийн байгуулалаа (жишээ нь Английн төв банк) бол тэдгээрийн үнэлгээг тухайн улсын зээлийн зэрэллэлтэй тэнцүүтээр авсан. Бэлэн мөнгө болон зээлжих тусгай эрхийн хадгаламж нь Банкны хувьд зээлийн эрсдэлгүй юм.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Тодруулга 28-д дурьдсанчлан Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газар эсвэл тэдгээрийн харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгсэлийн гол зорилго нь Засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. Зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктай хийсэн гэрээтэй холбоотой ба ашиглаагүй хэмжээгээр эрсдэл тодорхойлогдоно (Тодруулга 28-аас харна уу). Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны Удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дунд нөлөөлдөг. Зээлийн эрсдэл нь Тодруулга 18-д харуулсны дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон зээлийн хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 28-г харна уу).

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь хүүгийн түвшин болон валютын ханш гэх мэт зах зээлийн хувьсагчуудын өөрчлөлтөөс үүдэн хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон хөрвөх чадварын эрсдэлийг үнэлэхдээ удирдлагын гол анхаардаг зүйл нь интервенцийн шаардлага, гадаадын өр төлбөр болон импортын бүтэц юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмжийн шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

Гадаад валютын эрсдэл

Валютын эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэ нь валютын ханшны хэлбэлзлээс үүдэн өөрчлөгджэх байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах хэмжүүрээр тодорхойлогдоно:

- Гадаад валютын нөөцийн удирдлагад ашигладаг валютууд;
- Гадаад валютын нөөцийн удирдлах зорилгоор гадаад валютаар илэхийлэгдсэн активын тухайн валютын эзлэх хамгийн их хувь хэмжээ, богино ба урт хугацааны хөрөнгө оруулалтын багцыг тодорхойлоно.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валютын нөөцөд тавигдах хязгаар нь Хөрөнгө оруулалтын хорооны шийдвэрийн дагуу Банк Ерөнхийлөгчөөр улирал бүр батлагдах ёстой. Энэхүү шийдвэр нь “Жилийн Хөрөнгө Оруулалтын Бодлого”-д үндэслэх ба энэ нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

Доорх хүснэгт нь 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-нээрх ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц өртөж буй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг валютаар илэрхийлэн харуулж байна.

	Санхүүгийн хөрөнгө сая төгрөг	Санхүүгийн өр төлбөр сая төгрөг	Дериватив сая төгрөг	Цэвэр позиц сая төгрөг
2013				
Ам.доллар	2,772,425	(1,184,119)	1,107,134	2,695,440
Монгол төгрөг	4,414,883	(4,281,298)	(929,257)	(795,673)
Юань	213,169	(2,848,227)	(245,091)	(2,880,149)
Евро	209,787	(33,461)	-	188,003
ЗТЭ	110,459	(132,669)	-	(22,210)
Бусад	175,113	(5,034)	-	170,080
	7,895,836	(8,484,808)	(67,214)	(644,509)
2012				
Ам.доллар	4,929,204	(2,699,439)	(229,440)	2,000,325
Монгол төгрөг	448,020	(3,143,102)	229,041	(2,466,041)
Юань	44,301	(475,012)	-	(430,711)
Евро	295,929	(69,909)	-	226,020
ЗТЭ	94,647	(111,549)	-	(16,902)
Бусад	114,224	(4,936)	-	109,288
	5,926,325	6,503,947	(399)	(578,021)

Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцсээрх гадаад валютын болон ЗТЭ-ын ханшийн харьцангуй боломжит өөрчлөлтөд ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгийн үзүүлэх мэдрэмжийг харуулсан. Хүснэгт дэх сөрөг угтатай дүнгүүд нь ашиг ба алдагдал дахь болзошгүй цэвэр хасагдуулгыг илэрхийлэх ба эерэг угтатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валют	Валютын ханшийн өөрчлөлт хувиар	Орлогын тайлан ба өмчийн хөрөнгө дахь нөлөө	Валютын ханшийн өөрчлөлт хувиар	Орлогын тайлан ба өмчийн хөрөнгө дахь нөлөө
	2013	2013 сая төгрөг	2012	2012 сая төгрөг
Ам.доллар	15% (15%)	404,316 (404,316)	5% (5%)	100,016 (100,016)
Юань	15% (15%)	(432,022) 432,022	5% (5%)	(21,536) 21,536
Евро	15% (15%)	26,449 (26,449)	5% (5%)	11,301 (11,301)
ЗТЭ	15% (15%)	(3,331) 3,331	5% (5%)	(845) 845
Бусад	15% (15%)	25,512 (25,512)	5% (5%)	5,464 (5,464)

Эрсдэлийн нөлөөний хэмжээ нь Банкны үндсэн үйл ажиллагааны мөнгөн нэгж (төгрөг) болон ЗТЭ-д хамарагдах мөнгөн нэгжээс бусад валютын хувьд тооцоологдсон болно.

Хүүгийн түвшний эрсдэл

Тус эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс үүдэн ирээдүйн мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэд нөлөөлж болох эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдлийн хэмжээнээс хэтрүүлхэгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хурээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр бүуруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшингийн эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцдаа хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөнгийн шинжилгээний (investment horizon) аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5%-аас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2013 оны 12 дугаар сарын 31

Дараах хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрдэлийн байлыг харуулжээ. Энэ хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн тувшин өөрчлөгдсөн буюу зээлийн хутсаа дуусгавар болсон өдруудийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна:

	Нийт	Хугашаагүй болон 1 сараас бага		1 – 6 сарын хооронд		6 – 12 сарын хооронд		12 сараас дэши		Хүү тооцогүй	
		сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
2013											
Нийт санхүүгийн хөрөнгө		7,898,638	3,871,839	1,926,556		500,882		987,819		611,542	
Нийт санхүүгийн өр төлбөр		(8,554,825)	(6,699,647)	(1,699,778)		(778)		(29,476)		(125,146)	
Нийт хүүгийн мэдрэмжийн зөryy	(656,187)	(2,827,808)	226,778	500,104		958,343		486,396			
2012											
Нийт санхүүгийн хөрөнгө		5,930,334	4,926,610	50,000		238,438		301,442		419,844	
Нийт санхүүгийн өр төлбөр		(6,505,180)	(2,616,574)	(694,904)		-		(115,080)		(3,078,622)	
Нийт хүүгийн мэдрэмжийн зөryy	(574,846)	2,304,036	(644,904)	238,438		186,362		(2,658,778)			

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Доорх хөрөнгө болон өр төлбөрийн хувьд хөвөгч хүүгээр хуимтлагдсан хүү бодогддог: ЗТЭ (Тодруулга 12), ЗТЭ-ийн хуваарилалт, HSBC банк болон Хятадын Ардын Банкнаас авсан зээлүүд (Тодруулга 25). Дараах хүснэгтэд Банкны орлогын тайлангийн зүйлсийн бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүгийн хувь хэмжээний үндэслэлтэй, боломжит өөрчлөлтөд үзүүлэх мэдрэмжийг харуулав.

Орлогын тайлан дахь нөлөө сая төгрөг

2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

100 үндсэн нэгжийн өсөлт	(16,517)
100 үндсэн нэгжийн бууралт	16,517

2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр

200 үндсэн нэгжийн өсөлт	(9,382)
200 үндсэн нэгжийн бууралт	9,382

Дээрх орлогын тайлан дахь нөлөөнүүдийн гол шалтгаан нь хүүний хувь өсөж (багассан) тохиолдолд хүүгийн өр төлбөрт, ялангуяа Хятадын Ардын Банкнаас авсан зээлд төлсөн хүүгийн зардал (их) бага болохтой холбоотой.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Бүс нүүргийн төвлөрлийн эрсдэл. 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийг газарзүйн байршилаар нь дор харуулав.

Монгол сая төгрөг	ЭЗХАХБ сая төгрөг	ОУВС сая төгрөг	ЭЗХАХБ бус сая төгрөг	Нийт сая төгрөг
Хөрөнгө				
Бэлэн мөнгө	63,691	-	-	63,691
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	-	1,639,726	110,459	200,910
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	490	950,446	-	2,594
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	1,026,038	503,177	-	1,529,215
Засгийн газрын үнэт цаас	-	-	-	-
Дотоодын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	405,896	-	-	405,896
Дотоодын банкуудад олгосон зээл	2,787,461	-	-	2,787,461
Бусад санхүүгийн хөрөнгө	207,715	-	-	207,715
Нийг санхүүгийн хөрөнгө	4,491,291	3,093,349	110,459	203,504
Өр төлбөр				7,898,603
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	841,129	-	-	841,129
Төв банкны үнэт цаас	1,627,017	-	-	1,627,017
Засгийн газрын байгууллагуудын харилцах, хадгаламж	1,710,024	-	-	1,710,024
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	2,497,197	-	-	2,497,197
Гадаад өр төлбөр	547	124,914	1,649,346	1,774,807
Бусад санхүүгийн өр төлбөр	104,650	-	-	104,650
Нийг санхүүгийн өр төлбөр	6,780,017	547	124,914	1,649,346
Цэвэр санхүүгийн хөрөнгө	(2,288,726)	3,092,802	(14,455)	(1,445,842)
Болзошгүй өр төлбөр ба Үүрэг		(267,643)		(545,760)
				(813,402)

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Бүс нутгийн төвлөрлийн эрсдэл. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Банкны хөрөнгө болон өр төлбөрийн газарзүйн байршилаар нь дор харуулав.

	Монгол сая төгрөг	ЭЗХАХБ сая төгрөг	ОУВС сая төгрөг	ЭЗХАХБ бус сая төгрөг	Нийт сая төгрөг
2012					
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	28,317	-	-	-	28,317
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршиулсан хөрөнгө, хадгаламж	-	3,133,983	94,647	44,349	3,272,979
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн Урвуу буцаан худалдан авах хэцүэл	490	139,469	-	2,594	142,553
Засгийн газрын үнэт цаас	92,322	2,031,631	-	-	2,123,953
Дотоодын банкуудад олгосон зээл	159,210	-	-	-	159,210
Бусад санхүүгийн хөрөнгө	202,488	-	-	-	202,488
Нийт санхүүгийн хөрөнгө	834	-	-	-	834
	483,661	5,305,083	94,647	46,943	5,930,334
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	828,450	-	-	-	828,450
Төв банкны үнэт цаас	752,151	-	-	-	752,151
Засгийн газрын байгуулагуудын харилцах, хадгаламж	2,959,686	-	-	-	2,959,686
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,371,671	-	-	-	1,371,671
Гадаад өр төлбөр	-	720	104,906	470,788	576,414
Бусад санхүүгийн өр төлбөр	16,808	-	-	-	16,808
Нийт санхүүгийн өр төлбөр	5,928,766	720	104,906	470,788	6,505,180
Цэвэр санхүүгийн хөрөнгө	(5,445,105)	5,304,363	(10,259)	(423,845)	(574,846)
Болзошгүй өр төлбөр ба Үүрэг	(61,856)	-	-	(89,356)	(151,212)

Аудитлагдсан санхүүгийн тайлангууд
2013 оны 12 дугаар сарын 31

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Бусад эрсдэлийн төвлөрөл

Банк Удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээлийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавидаг. 2012 болон 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банкинд ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүнд нөхцөл байдалд өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл нь Банкинд учирдаг хамгийн гол эрсдэлүүдийн нэг юм. Хөрөнгө оруулалтын сонгодог гурван үзүүлэлт (аюулгүй байдал - төлбөрийн чадвар - өгөөж)-ийн хувьд, төлбөрийн чадвар ба аюулгүй байдлын бүх шаардлагууд хангагдсан үед л өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн Банкны хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжих боломжтой. Импортоос ихээхэн хамааралтай, Засгийн газрын гадаад өрийг байнга төлж байх шаардлагатай, дотоодын зах зээл дээрх валютын эрэлт, нийлүүлэлт байнга хэлбэлзэж байдаг нөхцөл байдлын үед төлбөрийн чадвар нь гадаад валютын нөөцийн удирдлагын авч үзэх ёстай чухал асуудал юм. Төлбөрийн чадварыг удирдахын тулд Банк гадаад валютын нөөцийн багцыг хоёр дэд багцад хуваадаг. Үүнд:

- Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл төлбөрийн чадварын багц орно): Энэ багц нь зээлийн өр төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой болгох зорилгоор ашигладаг. Энд бэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас бүрдэнэ. Энэхүү багц нь мөн хугацаат хадгаламжид, өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий мөнгөний зах зээлийн хэрэгсэл (өрийн бичиг)-д, долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаасанд болон мөнгөжссөн алтанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын багц: Дунд болон урт хугацааны өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий Засгийн газрын бонд болон үнэт цаасанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.

Хөрөнгө оруулалтын хороо гадаад валютын нөөцийн багцын хязгаар тогтоох санал гаргадаг. Эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг бууруулахын тулд Улсын гадаад валютын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг тогтоосон:

- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийн богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон харилцах данс болон валютаар илэрхийлэгдсэн бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийн богино хугацаат (1 жил хүртлэх) хөрөнгө болгон 6 сар хүртлэх хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулах.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валютын нэгж арилжааны хязгаар нь 100,000 ам.доллар ба нэг удаагийн шинжтэй арилжааны хязгаар нь 50,000 ам.доллар байхад валютын арилжаанаас үүдэх алдагдлыг зогсох хязгаар нь 400,000 ам.доллар ба энэ нь эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг бууруулдаг байна.

Дараах хүснэгтэд 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн өр төлбөрийг гэрээнд заасан дуусах хугацаагаар нь харуулсан. Дуусгавар хугацааны тайланд тусгасан өглөгүүд нь нийт зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааг оруулан гэрээнд заасан хямдруулаагүй мөнгөн гүйлгээ болно. Санхүүгийн байдлын тайланд дүнгүүд нь хямдруулсан мөнгөн гүйлгээн дээр үндэслэсэн байх тул хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна. Санхүүгийн деривативууд нь форвард болон своп хэлцлүүдээс хүлээн авах болон төлөгдөх гэрээний дүнд орсон болно.

Аккредитивийг дэмжихэд шаардагдах төлбөрийн чадварын хэмжээ нь дуусах хугацааны шинжилгээнд харуулсан өр төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага юм. Учир нь Банк гуравдагч талыг эдгээр гэрээн дээр үндэслэн хөрөнгө татна гэж үздэггүй байна. Доорх дуусгавар хугацааны шинжилгээний хүснэгт дэх одоогийн нийт гэрээнд үндэслэсэн өр төлбөрийн хэмжээ нь ирээдүйд шаардлагатай мөнгөний хэмжээг илэрхийлэхгүй. Учир нь ихэнхи энэ төрлийн гэрээт өр төлбөр нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

Өр төлбөрийн дүн тодорхой бус тохиолдолд тодруулсан дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлын үндсэн дээр тодорхойлно. Гадаад валютаар хийсэн төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшаар шилжүүлэн тооцно.

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Төлбөрийн чадваарын эрсдэл (Үргэлжлэл)

Хамтруулдаагүй мөнгөн урсгал дээр үндэслэсэн санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав:

2013	Ор төлбөр	Хугацаагүй болон 1 сараас бага сая төгрөг		6 – 12 сарын хооронд сая төгрөг		12 сараас дэен сая төгрөг		Нийт сая төгрөг
		Хугацаагүй болон 1 сараас бага сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	6 – 12 сарын хооронд сая төгрөг	12 сараас дэен сая төгрөг	12 сараас дэен сая төгрөг	Нийт сая төгрөг	
	Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	841,129	-	-	-	-	-	841,129
	Төв банкны үнэт цаас	1,630,500	-	-	-	-	-	1,630,500
	Застийн газрын байгууллагад төлөх өр төлбөр	1,679,230	980	974	32,497	32,497	-	1,713,681
	Дотоодын банкуудын харицаах, хадгалаамж	2,497,197	-	-	-	-	-	2,497,197
	Галаад өр төлбөр	125,223	1,675,356	-	-	238	238	1,800,817
	Бусад санхүүгийн өр төлбөр	34,633	-	-	-	-	-	34,633
	Нийт төлөгдсөн своп болон форвард хэмцэлүүд:							
	- Орох урсгал	(752,690)	(354,444)	-	-	-	-	(1,107,134)
	- Гарах урсгал	770,330	404,018	-	-	-	-	1,174,348
	Зээлтгэй холбоотой төлбөрийн үүрэг	825,080	-	-	-	-	-	825,080
	Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	7,650,632	1,725,910	974	32,735	32,735	32,735	9,410,251

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Төлбөрийн чадварын эрслэл (Үргэлжлэл)

Хамдруулагүй мөнгөн урстгал дээр үндэслэсэн санхүүгийн өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээг 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар доорх хүснэгтэд харуулав.

	Хугацаагүй боловн 1 сараас бараа	1 – 6 сарын хооронд	6 – 12 сарын хооронд	12 сараас дээш	Нийт
2012	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	828,450	-	-	-	828,450
Төв банкны үнэт цас	524,500	237,500	-	-	762,000
Засийн газрын байгууллагад төлөх өр төлбөр	2,939,266	64	77	23,804	2,963,211
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	1,371,671	-	-	-	1,371,671
Гадаад өр төлбөр	105,237	470,788	-	389	576,414
Бусад санхүүгийн өр төлбөр	15,575	-	-	-	15,575
Нийт төлгөдсөн своп болон форвард хэлцэлүүд:					
- Орох урстгал	(188,638)	(115,577)	-	-	(304,215)
- Гарах урстгал	188,203	116,411	-	-	304,614
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг	151,212	-	-	-	151,212
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд ирээдүйн хугацаанд төлж болзошгүй өр төлбөрүүд	5,935,476	709,186	77	24,193	6,668,932

29. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (Үргэлжлэл)

Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

